



“ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ”

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2020 он

**“ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН
ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ”**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны захиалагч:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Захиргааны удирдлагын газар

**Судалгааны багийн
гишүүд:**

Б.Алтангэрэл

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм
шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын
төвийн эрхлэгч, хууль зүйн доктор /Ph.D/,
дэд профессор, хурандаа

М.Хүрэлбат

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын
төвийн
эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч

Агуулга

Өмнөх үг	3
Зураг, хүснэгтийн жагсаалт	4-5
Удиртгал	6-14
НЭГ. БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛИЙН ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ	
1.1. Баривчлах шийтгэл ногдуулж буй зөрчил, түүний гаралтад хийсэн шинжилгээ	15-25
1.1.1. Баривчлах байрны чиг үүрэг, хэрэгжилтэд хийсэн шинжилгээ	16-37
1.2. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын төрөл, хэлбэр	38-56
ХОЁР. ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ	
2.1. Зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн шинжилгээ	57-71
2.2. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөний талаарх судалгааны дүн	72-95
ГУРАВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ	
3.1. Дүгнэлт	96-99
3.2. Зөвлөмж	100
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	101
ХАВСРАЛТ	103

ӨМНӨХ ҮГ

Зөрчлийн тухай хууль нь 240 орчим хуулиар хориглож, хязгаарласан 1800 орчим үйлдэл, эс үйлдэхүйг нэгтгэсэн Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг зөрчсөн тодорхой төрлийн зөрчлүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх шийтгэлийн төрөл, хэмжээг хуульчилж өгчээ.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд дунджаар 2,000,000-3,000,000 сая орчим зөрчил үйлдэгдэн эрх бүхий байгууллагаас шийтгэгдэж байгаа хэдий ч жил ирэх тусам үйлдэгдэх зөрчлийн тоо буурахгүйгээр барахгүй ихсэх хандлагатай байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл болон архидан согтуурах, мансуурахтай холбоотой зөрчил ихэсч байгаа нь анхаарал татаж байна.

Зөрчилд оногдуулж буй шийтгэлийн онцгой төрөл болох баривчлах шийтгэл нь хүний чөлөөтэй зорчих эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлан хуулиар эрх олгогдсон баривчлах байранд хориж буй төрийн албадлагын арга хэмжээ юм.

Зөрчил дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх, засч хүмүүжүүлэх үйл хэрэгт 2014 оноос хойш зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж ирсэнээс хойш нилээдгүй хугацаа өнгөрчээ.

Бидний судалгааны ажлын үндсэн зорилго нь баривчлах шийтгэл эдэлж буй этгээдэд явуулж буй зан үйлд нөлөөлөх албадан сургалтын агуулга, хэлбэр, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийг судлан, улмаар тухайн шийтгэлийн үр нөлөөнд дүн шинжилгээ хийхэд чиглэлээ.

Зан үйлд нөлөөлөх сургалт хэдийгээр сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх болон нийгэмшүүлэх ажлын уялдаа холбоо бүхий сургалт-хүмүүжлийн арга хэмжээ бөгөөд практикт баривчлагдсан болон ял эдэлж буй этгээдүүдийн дунд явуулж буй тухайн сургалтын чанар, хүртээмж, үр дүн хангалтгүй байгаа талаар олон асуудлууд байсаар байна.

Энэхүү судалгааны ажил нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүнгийн талаар анхлан хийгдсэн судалгааны ажил тул практик алба хаагч, судлаачдын хувьд судалбал зохих ширээний ном болно гэдэгт гүнээ итгэж байна.

Хүндэтгэсэн:

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХҮРЭЭЛЭНГИЙН
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ ТӨВИЙН ЭРХЛЭГЧ,
ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР /Ph.D /, ДЭД ПРОФЕССОР,
ХУРАНДАА Б.АЛТАНГЭРЭЛ

Зураг, хүснэгтийн жагсаалт:

Зураг 1.	Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж буй хоригдлын тоо /2019, 2020 оны 11.1-ны байдлаар/
Зураг 2.	Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын боловсролын судалгаа
Зураг 3.	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас зөрчлийн хэрэг үйлдэж баривчлагдсан хүмүүсийн судалгаа /2019, 2020 оны 12.01-ны байдлаар/
Зураг 4.	Тэтгэлэг тогтоолгосон хүүхдийн тоо /2010-2019/
Зураг 5.	2011-2019 оны хүүхдийн тэтгэлгийн төлбөр барагдуулалтын байдал мөнгөн дүнгээр /сая.төг/
Зураг 6.	Баривчлах төвд шийтгэл эдэлсэн хүний судалгаа /2015-2020/
Зураг 7.	Баривчлагдсан этгээдээс авсан баривчлах шийтгэлийн үр нөлөөнд хийсэн судалгааны дүн
Зураг 8.	Алба хаагчаас авсан баривчлах шийтгэлийн үр нөлөөнд хийсэн судалгааны дүн
Зураг 9.	Баривчлагдсан этгээдүүдээс авсан эрхийн баталгааны чиглэлээрх судалгааны дүн
Зураг 10.	Баривчлагдсан этгээдүүдээс авсан баривчлах байрны нөхцөл, журмын талаарх судалгааны дүн
Зураг 11.	Баривчлагдсан этгээдүүдээс 2015-2019 онд ар гэртэйгээ түр уулзалт хийсэн судалгаа
Зураг 12.	Баривчлагдсан этгээдээс авсан хоолны чанар, хүртээмжийн талаарх судалгааны дүн
Зураг 13.	Баривчлагдсан этгээдүүдээс авсан алба хаагчдын харьцааны талаарх судалгаа:
Зураг 14.	ШШГБ-ын орон нутгийн алба хаагчдаас авсан баривчлах шийтгэл эдлүүлэх бэлтгэл ажлын талаарх асуулгын дүн:
Зураг 15.	2020 оны эхний хагас жил зан үйлээ засах сургалтад хамрагдсан хүмүүсийн судалгаа
Зураг 16.	Зан үйлд нөлөөлөх эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ
Зураг 17.	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг шинээр хуульчилж өгсөн байдалд өгсөн үнэлгээ
Зураг 18.	Зан үйлд нөлөөлөх сургалтын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ
Зураг 19.	Төрийн бус байгууллагын хэрэгцээний судалгаа
Зураг 20.	Төрийн бус байгууллагын оролцооны эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ
Зураг 21.	Төрийн бус оролцоонд өгсөн үнэлгээ
Зураг 22.	Албадан сургалтын үр нөлөөний талаарх судалгаа
Зураг 23.	Албадан сургалтын үр дүнг дээшлүүлэх талаарх санал
Зураг 24.	Алба хаагчдаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд өгсөн үнэлгээ

Зураг 25.	Зан үйлд нөлөөлөх сургалтын үр дүнг сайжруулах чиглэлээр гаргасан санал
Зураг 26.	2015-2020 оны хооронд хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ажиллаж байсан нийгмийн ажилтны судалгаа
Зураг 27 .	Мэргэжлийн нийгмийн ажилтны судалгаа
Хүснэгт 1.	Монгол Улсын хэмжээнд 2015-2020 оны 11.01-ны хооронд бүртгэгдсэн зөрчлийн судалгаа
Хүснэгт 2.	Зөрчлийн хуульд заасан шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл
Хүснэгт 3.	Монгол Улсын хэмжээнд 2015-2020 оны 11.01-ны хооронд баривчлах шийтгэл оногдуулсан судалгаа
Хүснэгт 4.	Эрүүгийн хуульд тусгагдсан мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг
Хүснэгт 5.	Гэр бүлийн хүчирхийлийн улмаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял шийтгэл, албадлагын арга хэмжээний сүүлийн 3 жилийн байдал
Хүснэгт 6.	Гэр бүлийн хүчирхийлийн улмаас гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа
Хүснэгт 7.	Гэр бүлийн хүчирхийлийн улмаас зөрчил үйлдэж баривчлагдсан этгээдийн боловсролын түвшин /2020 оны 12.01-ны байдлаар/
Хүснэгт 8.	Баривчлагдсан этгээдүүдийн үйлдсэн зөрчлийн төрөл /2020.12.01-ны байдлаар/
Хүснэгт 9.	Баривчлагдсан этгээдийн эрх, үүрэг холбогдох хууль, журамд туссан байдал:
Хүснэгт 10.	Баривчлах байрны ахуй нөхцөл холбогдох хууль, журамд туссан байдал:
Хүснэгт 11.	ШШГТХ-д зан үйлд нөлөөлөх албадан сургалтын талаар туссан байдал
Хүснэгт 12.	Зан үйлд нөлөөлөх сургалтын үйл ажиллагааны харьцуулалт
Хүснэгт 13.	2019 оны байдлаар зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа:
Хүснэгт 14.	Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо шаарддаг албадлагын арга хэмжээ төрлүүд
Хүснэгт 15.	Хорих ангиуд дахь сургалтын орчны судалгаа

УДИРТГАЛ

Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11-ны өдөр батлан гаргаж, мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2.1 дүгээр зүйлд “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ” гэж заажээ. “Хууль зөрчих” гэж хууль, Захиргааны ерөнхий хууль, бусад хуульд заасан журмын дагуу хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнийг ойлгоно гэжээ.

Онолын талаас нь “Зөрчил” гэх ойлголтыг хууль зүйн доктор, дэд профессор Ч.Нямсүрэн “Эрх зүйн зөрчил гэж эрх зүйн хэм хэмжээний шаардлагыг зөрчсөн буюу түүний эсрэг чиглэсэн, нийгэмд хор аюултай, хуульд зааснаар хүлээх тусгай хариуцлага хүлээх эрх зүйн чадамжтай этгээдийн зан үйл” хэмээн бүтээлдээ¹ тэмдэглэжээ. Тиймээс захиргааны зөрчил нь захиргааны журам зөрчсөнөөс үүдэн гардаг². Нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон зан үйлийн горим, эрх зүйн хэм хэмжээг захиргааны журам гэнэ³. Захиргааны хариуцлага хүлээлгэх бодит үндэслэл нь захиргааны зөрчил гаргасан явдал юм. Мөн эрх зүйн зөрчлийг гэмт хэрэг, захиргааны эрх зүйн зөрчил, иргэний эрх зүйн зөрчил, сахилгын зөрчил, олон улсын эрх зүйн зөрчил гэсэн төрлүүдтэй хэмээн үзжээ.

Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна гэж заасан байна. Зөрчил нь дараах хууль зүйн шинжийг агуулдаг. Үүнд:

1. Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн байх;
2. Нийгэмд хор уршигтай байх;
3. Гэм буруутай үйл ажиллагаа байх;
4. Хууль тогтоомжид заасан шийтгэл хүлээх үйлдэл, эс үйлдэл гэсэн шинжүүдтэй байна.⁴

Зөрчлийн тухай хууль батлагдахаас өмнө Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бие даасан 387 хууль байснаас захиргааны хариуцлага ногдуулсан хэм хэмжээ бүхий зүйл, заалттай 177 хуулиас 14 хуульд нь “хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэж ерөнхий байдлаар зааж байсан байна. Захиргааны хариуцлагын тухай хууль нь материаллаг хууль төдийгүй мөн нэг зэрэг процессын хуулийн шинжийг давхар агуулдаг ба 1992 онд батлагдснаас хойш 1995, 1997, 2004, 2006 онуудад нийт 20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсан бөгөөд зарчмын шинжтэй шинэчлэлт огт хийгдээгүй, эрх зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг Захиргааны хариуцлагын тухай хуулиар бүрэн зохицуулж чадаагүй, хэм хэмжээний хоорондын зөрчил, давхардал бий болгосон зэрэг нь ард иргэдийн дунд хууль тогтоох байгууллагын ажилтнуудыг хардах, гаргасан шийдвэрийг хууль бус

¹ Ч.Нямсүрэн, “Эрх зүйн онол” ерөнхий анги, УБ., 2016, 385 дахь тал.

² Ж.Сүхбаатар, “Захиргааны эрх зүй”, УБ., 2005, 35 дахь тал.

³ Мөн тэнд.

⁴ С.Долгорсүрэн, “Захиргааны хариуцлага”, УБ., 2005, 47 дахь тал.

гэж үзэхэд хүргэж байснаас Зөрчлийн тухай хуулийг батлан гаргах шаардлагыг бий болгосон байна.

Зөрчлийн тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч зэрэг үнэт зүйлс, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай оногдуулах, хууль зүйн хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор⁵ баталжээ. Зөрчлийн тухай хууль нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй 230 гаруй хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэсэн⁶ анхны хууль болсон.

Шүүхээс сүүлийн 15 жилийн байдлаар шийдвэрлэсэн захиргааны зөрчлийг судлан үзвэл жилд дунджаар 10,000-20,000 орчим хэрэг шийдвэрлэн, 6000-8000 орчим хүнд баривчлах шийтгэл ногдуулдаг байна.

Хүснэгт 1. Монгол Улсын хэмжээнд 2015-2020 оны 11.01-ны хооронд бүртгэгдсэн зөрчлийн судалгаа⁷

д/д	Аймаг	2015	2016	2017	2018	2019	2020.11.1
1.	Архангай	10197	9069	16003	22332	32539	26804
2.	Баян-Өлгий	6639	7115	8245	10760	14146	11502
3.	Баянхонгор	12494	7741	12179	21188	29352	25941
4.	Булган	11109	9227	13374	21578	31461	25942
5.	Говь-Алтай	6155	4761	6098	9456	15624	18510
6.	Говьсүмбэр	10965	14178	17188	18779	24769	20088
7.	Дархан-Уул	21959	22008	34860	49216	63852	42036
8.	Дорноговь	17101	12275	18251	19671	33016	18856
9.	Дорнод	18761	19041	14425	18198	20002	18863
10.	Дундговь	10242	8384	14546	17727	21591	17536
11.	Завхан	9668	5621	7805	9613	17635	15454
12.	Орхон	17744	15095	22948	23791	31660	29248
13.	Өвөрхангай	9036	8846	20753	24905	43498	58408
14.	Өмнөговь	11388	12493	25131	40219	19311	17056
15.	Сүхбаатар	7639	5138	5623	5278	9438	13612
16.	Сэлэнгэ	22094	15791	23417	23436	26499	19474
17.	Төв	23033	28266	49233	47029	56902	42756
18.	Увс	10216	7320	8803	11880	16442	14839
19.	Ховд	7883	6203	15169	13690	19080	18448
20.	Хөвсгөл	12826	11257	14232	16227	21331	21445
21.	Хэнтий	14139	7262	15868	19383	30763	33365
22.	Улаанбаатар	1.151.800	733.830	962.866	1.253.822	1.596.914	1.453.699
Нийт		1.423.088	1.037.970	1.327.017	1.698.178	2.175.825	2.237.844

Зөрчлийн тухай хуульд зөрчил үйлдсэн тохиолдолд торгох, баривчлах, эрх хасах гэсэн шийтгэл оногдуулахаар зохицуулсан ба 931 торгох, 9 баривчлах, 16 эрх

⁵“Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”, <http://forum.parliament.mn/projects/75>

⁶ Мөн тэнд

⁷ ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны, шинжилгээний газрын тайлан.

хасах, мөн торгох, баривчлах үндсэн шийтгэл дээр нэмэгдүүлэн эрх хасах шийтгэлийг оногдуулахаар заажээ.

Зөрчлийн шийтгэл гэдэг нь зөрчлийн хуульд заасан хэм хэмжээг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн гэм буруутай этгээдэд хүлээлгэж байгаа албадлагын арга хэмжээ юм. Зөрчлийн шийтгэл нь хууль зүйн бусад хариуцлагын нэгэн адил нийтлэг шинж, зарчмыг агуулахын зэрэгцээ доор дурьдсан өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг Үүнд:

- Шийтгэлийг хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хүлээлгэнэ;
- Зөрчил нь нийгмийн хор аюул, учруулсан хохирлын хувьд гэмт хэргийн шинжгүй байна;
- Зөрчлийн шийтгэл хүлээлгэх журмыг хуулиар тогтооно;
- Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна.

Баривчлах гэсэн нэр томъёоны хувьд авч үзвэл Арест буюу Arrectum /шүүхийн тогтоол/ гэсэн латин үг. Үгийн дээрх утгаас авч үзэхэд баривчлах гэдэг ойлголт нь хүний эрх, эрх чөлөөг ямар нэгэн хэлбэрээр хязгаарлаж, нийгмээс тусгаарлах гэсэн үг.

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараахь шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулна:

Хүснэгт 2. Зөрчлийн хуульд заасан шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл

д/д	Шийтгэл	Албадлагын арга хэмжээ
1.	<p>Торгох шийтгэл:</p> <p>Зөрчлийн хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ. Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байх ба нэг торгуулийн нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.</p> <p>Шүүх, эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно. Зөрчлийн хуулийн тусгай ангид</p>	<p>Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх:</p> <p>Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана. Хураасан хөрөнгө, орлогыг хохирол нөхөн төлөхөд зарцуулах, эсхүл устгах, шилжүүлэх эсэхийг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ. Хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.</p> <p>“Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж зөрчил үйлдэн олж авсан мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг арилжаалж бий болгосон бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг</p>

	<p>заасан тохиолдолд хөрөнгө, орлого, нөхөн төлбөр, хохирлын тодорхой хувиар тооцсон хэмжээгээр торгох шийтгэлийг оногдуулах ба хэсэгчлэн төлүүлэх арга хэмжээ хамаарахгүй.</p> <p>Торгох шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтны саналаар шүүх баривчлах шийтгэлээр солино.</p>	<p>түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг ойлгоно.</p>
2.	<p>Баривчлах шийтгэл:</p> <p>Зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ. Баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна. Баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно. Шүүх баривчлах шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй ба энэ тохиолдолд нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэл оногдуулж болно. Хуульд заасан тохиолдолд баривчлах шийдвэр биелүүлэхийг хойшлуулж болно. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцно. Хэд хэдэн зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлийн нийт хугацаа гурван сараас хэтрэхгүй байна.</p>	<p>Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах:</p> <p>Зөрчлийн хуульд заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, зэвсэг, хэрэгслийг хураана. Зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл гэдэгт зөрчил үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналга, зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг ойлгоно.</p>
3.	<p>Эрх хасах шийтгэл:</p> <p>Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл зөвшөөрлийг хүчингүй болгохыг эрх хасах шийтгэл гэнэ. Хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан журмын дагуу тооцсон онооны бүртгэлийг</p>	<p>Хохирол, нөхөн төлбөр гаргуулах:</p> <p>Зөрчлийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.</p>

	<p>үндэслэж эрх хасах шийтгэлийг оногдуулж болно. Зөрчлийн хуульд заасан тохиолдолд эрх хасах шийтгэлийг торгох шийтгэл дээр нэмж оногдуулна. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх хууль, захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон журмыг байнга, эсхүл ноцтой зөрчсөн, эсхүл тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх журмыг зөрчсөн зөрчилд нь оногдуулсан шийтгэлийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн бол эрх хасах шийтгэлийг үндсэн шийтгэл дээр нэмж оногдуулна.</p>	<p>Тайлбар: Энэ бүлэгт заасан “эрх бүхий албан тушаалтан” гэж зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг ойлгоно.</p>
4.		<p>Албадан эмчлэх: Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх түүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно. Албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.</p>
5.		<p>Албадан сургалт: Зөрчлийн хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна. Албадан сургалттай холбоотой харилцааг хуулиар зохицуулна.</p>

Торгох, баривчлах шийтгэлийг үндсэн, эрх хасах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр оногдуулна. Зөрчлийн хуульд заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчлийн үр дагаврыг арилгах, учирч болзошгүй хохирол, хор уршгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол зөрчил илэрсэн өдрөөс үйл ажиллагааг зогсооно.

Тээврийн хэрэгсэл ашиглан зөрчил үйлдсэн нь автомат ажиллагаатай зураг-дүрс бичлэгийн техник, хэрэгслээр бэхжүүлэгдсэн бол тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчид шийтгэл оногдуулна. Тээврийн хэрэгслийг өөр хүн эзэмшиж,

эсхүл ашиглаж байсан нь тогтоогдсон бол өмчлөгч, эзэмшигчийг шийтгэлээс чөлөөлж, зөрчил үйлдсэн хүнд шийтгэл оногдуулна.

Баривчлах шийтгэл нь дараах онцлог шинжтэй байна.Үүнд:

1.Зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ.

Баривчлах шийтгэлийн агуулга нь зөрчил үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой нөхцөл, журам бүхий байранд саатуулахад оршино. Энэ шийтгэл нь нийгмээс тусгаарлах агуулгатай байдаг онцлогтой.

Хэдийгээр зөрчил үйлдэн баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн этгээд нь түр хугацаанд тусгаарлагдан хоригдож байгаа ч хэвлэл мэдээллийн хэрэгслэл үзэх, ашиглах, холбогдох зардлаа өөрөө хариуцах, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, найз нөхөд болон өмгөөлөгчтэйгөө түр уулзах, захидал харилцаа, сонин сэтгүүл захиалах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг эрхээр бүрэн хангагдсан байдаг учраас нийгмээс бус олон нийтээс тусгаарлагдсан гэж ойлгох нь зүйтэй гэж үзэж байна.

2.Баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна.

Шүүх баривчлах шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй. Энэ тохиолдолд баривчлах шийтгэл нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэл оногдуулж болно.

3.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцно.

Түүнчлэн баривчлах шийдвэр биелүүлэхийг хойшлуулж болно. Хэд хэдэн зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлийн нийт хугацаа гурван сараас хэтрэхгүй байна.

4.Баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно.

Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Баривчлах шийдвэр биелүүлэх журмаар зохицуулж байна.

Хүснэгт 3. Монгол Улсын хэмжээнд 2015-2020 оны 11.01-ны хооронд баривчлах шийтгэл оногдуулсан судалгаа⁸

д/д	Аймаг	2015	2016	2017	2018	2019	2020.11.01
1.	Архангай	260	34	180	225	404	338
2.	Баян-Өлгий	167	72	212	221	265	231
3.	Баянхонгор	409	102	413	466	395	389
4.	Булган	184	46	126	179	277	376

⁸ ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны, шинжилгээний газрын тайлан.

5.	Говь-Алтай	149	18	140	114	185	251
6.	Говьсүмбэр	140	18	92	108	131	104
7.	Дархан-Уул	395	162	184	251	317	231
8.	Дорноговь	284	58	217	278	284	210
9.	Дорнод	605	412	452	235	311	377
10.	Дундговь	219	33	129	139	112	86
11.	Завхан	300	55	221	197	288	292
12.	Орхон	797	378	700	809	922	809
13.	Өвөрхангай	433	215	635	981	1286	1331
14.	Өмнөговь	230	49	220	274	203	233
15.	Сүхбаатар	130	52	81	131	160	189
16.	Сэлэнгэ	472	215	519	427	398	306
17.	Төв	432	101	336	496	528	481
18.	Увс	220	38	195	224	251	338
19.	Ховд	245	29	296	338	374	380
20.	Хөвсгөл	277	30	163	272	326	350
21.	Хэнтий	406	296	603	554	487	447
22.	Улаанбаатар	6420	2967	5231	4062	7392	7871
Нийт		13174	5380	11345	10981	15296	15620

Баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны үндсэн онцлог нь баривчлах байр, төв буюу баривчлагдсан этгээдийн дунд явуулах нийгэмшүүлэх ажил нь зан үйлд нөлөөлөх сургалт болон сэтгэл зүйн үйлчилгээ гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд явагдана. Зөрчлийн хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5-т Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна гэжээ. Баривчлах байрны дотоод журамд зааснаар баривчлах төв /байр/ нь сургалтын танхимтай байх бөгөөд шүүхийн шийтгэвэрт заасан хугацаагаар албадан сургалтад хамруулна, сургалт нь баривчлагдсан хүний зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх бөгөөд хөтөлбөрийн дагуу явагдана, сургалтыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болохоор заасан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/73 тоот тушаалийн хавсралтаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан

сургалтын хөтөлбөр”, “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-ын хүрээнд баривчлах байранд албадан сургалтыг зохион байгуулж байна.

Судалгааны ажлын зорилго, зорилт:

Судалгааны ажлын зорилгоо баривчлах шийтгэл эдэлж буй этгээдүүдийн дунд явуулж буй зан үйлд нөлөөлөх албадан сургалтын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн практикт тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, улмаар баривчлах шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхтэй холбогдсон дүгнэлт-зөвлөмж гаргах зорилгыг өмнөө тавин ажиллалаа.

Зорилгоо хангах хүрээнд дараах дэд зорилтуудыг дэвшүүлсэн болно.

1. Шүүхээс баривчлах шийтгэл оногдуулсан зөрчлийн бүтцэд дүн шинжилгээ хийх;
2. Баривчлах байранд явуулж буй зан үйлд нөлөөлөх албадан сургалтын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
3. ШШГЕГ-ын харьяа аймаг, орон нутагт баривчлах шийтгэл эдлүүлэх шаардлага, боломжийн талаар дүн шинжилгээ хийх зэрэг болно.

Судалгааны ажлын арга зүй:

Судалгааны ажлыг явуулахад нийгмийн шинжлэх ухааны нийтлэг судалгааны арга болох диалектикийн аргыг иш үндэс болгон түүхчлэх, харьцуулах, бичиг баримтад дүн шинжилгээ хийх, анкетын болон ярилцлагын аргыг ашигласан болно.

Түүнчлэн Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дугаар тушаалаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ийг эх үндэс болгосон бөгөөд эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохдоо эрдэм шинжилгээ, судалгаа-боловсруулалтын ажлын нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, ажиглалт болон ярилцлагыг ашиглаж боловсруулалт хийсэн болно. Түүнчлэн судалгааны урьдчилан бэлдсэн асуулгыг дараах хүрээнд авлаа.

1. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөө, хэрэгжилтийн талаарх санал асуулгыг ШШГЕГ-ын харьяаны төв, орон нутгийн хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн 62 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч;
2. Албадлагын арга хэмжээний нэг төрөл болох зан үйлд нөлөөлөх албадан сургалтын чанар, үр дүн, тухайн ажиллагаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны талаарх асуулгыг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 13 ахлах шийдвэр гүйцэтгэгч, 47 шийдвэр гүйцэтгэгч;
3. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүн, хэрэгцээний талаарх санал асуулгыг Улаанбаатар хот болон орон нутгийн баривчлах байранд баривчлагдсан 452 этгээдээс анкетын аргаар судалгаа хийн энэхүү судалгааг гүйцэтгэсэн болно.

НЭГ. БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛИЙН ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

1.1.Баривчлах шийтгэл ногдуулж буй зөрчил, түүний гаралтад хийсэн шинжилгээ

Өнөөгийн дагаж мөрдөж буй Зөрчлийн тухай хуульд дараах зөрчил үйлдсэн хүнд баривчлах шийтгэл ногдуулахаар заасан байна.

Нэг. Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах:

Мансуурсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуульд мансууруулах бодистой холбоотой дараах гэмт хэргүүдийг хуульчилж өгсөн ба дээрх гэмт хэргийн шинжийг агуулаагүй үйлдэл, эс үйлдэл нь зөрчил болно.

Хүснэгт 4. Эрүүгийн хуульд тусгагдсан мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг

1.	20.7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	<p>1.Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгоор хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3.Энэ гэмт хэргийг:</p> <p>3.1.байнга тогтвортой;</p> <p>3.3.улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>4.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.</p> <p>5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.</p>
2.	20.8 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх орон байраар хангасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй

	бодис хэрэглэх орон байраар хангах	тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3.	20.9 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
4.	20.10 дугаар зүйл. Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах	1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын тайланд 2016 оны байдлаар дэлхийд 247 сая хүн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг, үүнээс 29 сая хүн нь уг бодисоос шууд хамааралтай болсон талаар дурьдсан. Монгол Улсын талаар НҮБ-ын 2010 оны тайланд дурьдсанаар Монгол Улс нь хар тамхи, мансууруулах бодис дамжин өнгөрөгч улс гэж үзсэн байсан бол 2014 оны тайланд дурьдсанаар манай улсыг хэрэглэгч улс орон болсон гэж дүгнэсэн нь цаашид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлага тулгарч буйг анхааруулсан явдал юм.

Манай хөрш орнуудын хувьд дээрх төрлийн гэмт хэрэг, холбогдогчийн тоо, эд мөрийн, баримтаар хураагдаж буй бодисын хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж, синтетик төрлийн мансууруулах бодис хууль бус зах зээлд өргөн нэвтэрч байгаа нь Монгол улсын үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, удмын санд сөргөөр нөлөөлж болзошгүй байдал үүссэн.

Улсын хэмжээнд 2018 оны 12 дугаар сарын байдлаар энэ төрлийн 197 хэрэгт 402 хүн холбогдон шалгагдсан нь урьд онтой харьцуулахад 96 хэргээр буюу 95%, холбогдогч 151 хүнээр буюу 60,1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогчдыг насны байдлаар авч үзвэл 17 нас буюу насанд хүрээгүй хүний тоо 2 дахин, 19-25 насны холбогдогч 37.8 хувиар, 26-35

насны холбогдогч 88.0 хувиар, 35-аас дээш насны холбогдогч 20.08 хувиар тус тус өсчээ. 2018 оны 12 сарын байдлаар нийт шалгагдсан этгээдүүдээс насанд хүрээгүй буюу дунд сургуулийн сурагч 20, их, дээд сургуулийн оюутнууд 64 байна.

Мансуурах хэлбэр нь хуулиар хориглосон сэтгэцэд нөлөөт бодис санаатай ба санамсаргүй байдлаар хэрэглэж буй үйлдэл байна. Баривчлах төвд зөвхөн 2020 оны эхний хагас жил 72 мансуурсан зөрчил үйлдэж баривчлагдсан байна.

Хоёр. Танхайрах:

Танхайрах зөрчил гаргаж үйлдэж буй этгээд олон нийтийн газарт, эсхүл орон байранд:

- а.хэрүүл маргаан үүсгэж;
- б.бусдыг өдөөн хатгаж;
- в.бусдын амгалан тайван байдал алдагдуулж;
- г.олон нийтийг үл хүндэтгэж;

д.үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж байдаг.

Зөрчлийн тухай хуульд “олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах, танхайрах” гэсэн хоёр төрлөөр танхайрах зөрчлийг тус тусад нь ялгаж зохицуулсан. Олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах байдлыг энэхүү хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаар “олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчим, гудамж талбайд бие зассан, эсхүл нус, цэр, тамхины иш хаясан” бол олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах гэж үзэх юм.

Баривчлах төвд зөвхөн 2020 оны эхний хагас жил 278 этгээд танхайрсан зөрчил үйлдэж баривчлагдсан байна.

Гурав. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих:

Зөрчил үйлдсэн этгээд нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:

- а.зодсон;
- б.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;
- в.бусадтай харилцахыг хязгаарласан;
- г.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах

эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн том зөрчлийн нэг төдийгүй үүний хохирогч нь дийлэнхдээ хүүхэд, эмэгтэйчүүд болдог. НҮБын Эмэгтэйчүүдийн Байгууллагын мэдээлснээр дэлхий дээр өмнөх 12 сарын хугацаанд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр, хамтрагчийн зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.

Монгол Улс 2016 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, 2017 оноос эхлэн мөрдөж байгаагаас гадна Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт энэ чиглэлийн асуудлыг тусган өгч, хэрэгжүүлж байгаа.

Судалгааны дүнгээр МУ-д гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэйн 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртсөн. Эдгээр эмэгтэйчүүдийн 4 хүн тутмын 1 нь (26.5%) хэн нэгэнд хандаж, хэлж байгаагүй байна. Цагдаагийн ерөнхий газарт гэмт хэрэг болон зөрчлийн гэсэн 2 төрлийн бүртгэлээс гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоон мэдээлэл гардаг.

Цагдаагийн байгууллагад 2020 оны эхний 3 сард 545.9 мянган зөрчил бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас 3131 зөрчил шалган, 2244 зөрчлийг шийдвэрлэжээ. Өмнөх оны мөн үеэс нийт зөрчил 15.0 (71.1 мянга) хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн зөрчил 61.6 (1193) хувиар, үүнээс шийдвэрлэсэн нь 99.3(1118) хувиар тус тус өсжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчилд 1813 иргэн өртөж, хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 72.8 (764) хувиар өссөн байна. Тэдний 92.7 (1681) хувь нь эмэгтэйчүүд байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн зөрчил 2019 оны эхний улиралд өдөрт дунджаар 21 удаа бүртгэгдэж байсан бол 2020 оны эхний улиралд 34 болж өссөнийг харуулж байна.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн 3131 зөрчлийн:

- 72.6% нь нийслэлд, 27.4% нь орон нутагт,
 - Зөрчлийн хуулийн “5.4.4.1 зодсон;” зүйлийг зөрчсөн нь 76.6%,
 - “хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан” зүйлийнх 18.1%, бусад холбогдох зүйлийнх 5.3%,
 - 94.2% нь гэр, орон сууцанд, 5.8% нь бусад газарт,
 - 10 зөрчлийн ойролцоогоор 7 нь шөнө оройн 19-24 цагийн хооронд гарчээ.
- Шийдвэрлэсэн 2244 зөрчлөөс 50 иргэнийг 6.3 сая төгрөгөөр торгох, 2194 иргэнийг баривчлах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 28 (2.3 дахин)-аар, баривчилсан шийтгэл 1090 (98.7%) хувиар тус тус өссөн байна.


Баривчлах төвд зөвхөн 2020 оны эхний хагас жил 3396 этгээд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил үйлдэж баривчлагдсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэгт оногдуулсан шүүхийн шийдвэрийн биелэлт:

1.Хорих ял:


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэж /ЭХ-ийн 11.7/ хорих ялаар шийтгэгдэж ял эдэлж байгаа хоригдлын тоон судалгааг урьд оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж буй хоригдлын тоо /2019, 2020 оны 11.1-ны байдлаар/



Насны хувьд авч үзвэл 20-24 насны-0, 25-34 насны-21, 35-44 насны-21, 45-54 насны-25 нийт-71 хүн байна⁹.

Зураг 2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын боловсролын судалгаа



2.Хорихоос өөр төрлийн ял:

Улсын хэмжээнд 2020 оны 11 дүгээр сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдсэн 2 ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавьж ажилласан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хэргээр буюу 50 хувиар буурсан байна.

2.1.Албадлагын арга хэмжээ:

Нийслэл, орон нутаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгүүдэд 2020 оны 9 дүгээр сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэж албадлагын арга хэмжээ авагдсан оны үлдэгдэл 40 этгээд байгаа ба шүүхээс ирсэн 50, эрэн сурвалжилж албадан ирүүлсэн 1, нийт 91 этгээдэд хяналт тавьж, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлж, хяналтын хугацаа дууссан 43, хугацаанаас өмнө ялаас чөлөөлсөн 2 шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулсан 17, дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн 3, нас барсан 2, тайлант хугацаанд шинээр эрэн сурвалжилсан 2 тус тус хасагдаж, нийт 34 этгээд хяналтад байгаа болно. Албадлагын арга хэмжээг хэмжээг төрлөөр нь авч үзвэл:

• *Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэж, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн талаар:*

⁹ Хорих ял эдлүүлэх албаны 2019, 2020 оны статистик, мэдээ дэлгэрэнгүй судалгаа

2020 оны 11 дүгээр сарын байдлаар хорих ял оногдуулахгүйгээр тэнссэж, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан оны үлдэгдэл 38 этгээд байгаа ба шүүхээс ирсэн 34, эрэн сурвалжилж албадан ирүүлсэн 1, нийт 73 этгээдэд хяналт тавьж, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлж, хяналтын хугацаа дууссан 28, хугацаанаас өмнө ялаас чөлөөлсөн 1, тэнссэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах арга хэмжээг зөрчсөний улмаас, шийдвэрийг хүчингүй болгож хорих ялаар солисон 9, зайлсхийж эрэн сурвалжлагдсан 1, дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн 1, хяналтын хугацаанд нас барсан 1 нийт 41 хасагдаж хяналтанд 32 этгээд байна.

Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн дээрх 73 этгээдүүдэд шүүхээс зан үйлээ засах сургалтад хамрагдах 23, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах 8, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх зорчин явахдаа хяналт тавьж буй эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх 2, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах 34, согтууруулах ундаа, мансууруулах бодис 38 этгээдэд хэрэглэхийг хориглох үүрэг хүүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг тус тус давхардсан тоогоор оногдуулжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам, сургалтын төлөвлөгөө”-ний дагуу хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нараар сургалт явуулж байна. Хөдөлмөрлөх дадал олгох сургалтыг хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нараар болон “Гэр бүл хүүхдийн сэтгэл зүйн боловсролыг дэмжих төв” төрийн бус байгууллага болон нутаг дэвсгэрийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх “Насан туршийн боловсролын төв”, орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглосон үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнтэй тус тус хамтран сургалт зохион байгуулан ажилласан байна.

• Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоогдсон этгээдийн талаар:

2020 оны 11 дүгээр сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлийн гэмт хэргийн улмаас хорих ялаар шийтгэгдэж хугацаанаас өмнө тэнсэн суллагдах албадлагын арга хэмжээ авагдсан оны үлдэгдэл 2 этгээд байгаа ба шүүхээс ирсэн 16 нийт 18 этгээдэд хяналт тавьж, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлж, хяналтын хугацаа дууссан 15, дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн 1, нийт 16 хасагдаж хяналтанд 2 этгээд байна.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Хорих ял эдлүүлэх алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгүүдээс хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоогдсон этгээдүүдийн талаарх мэдээ, дэлгэрэнгүй судалгааг нэрсээр гаргуулан авч, нэгдсэн бүртгэл хөтлөн тухайн этгээдэд хуульд заасан үүргийг танилцуулж, мэдэгдэх хуудсыг гардуулах, шүүгчийн захирамж, холбогдох материалын бүрдлийг ханган тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлсэн.

Хүснэгт 5. Гэр бүлийн хүчирхийлийн улмаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял шийтгэл, албадлагын арга хэмжээний сүүлийн 3 жилийн байдал¹⁰:

Шүүхийн шийдвэрийн төрөл		Хэмжих нэгж	Гүйцэтгэвэл зохих			Гүйцэтгэсэн			Үлдэгдэл		
			2018	2019	2020	2018	2019	2020	2018	2019	2020
Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн		Нийт ялтны тоо	5	4	2	4	4	2	-	-	-
Үүнээс	Торгох ял	Ялтны тоо	4	4	2	4	4	2	-	-	-
		Мөнгөн дүн	1800,0	1500.0	800.0	1800,	1500.0	800.0	-	-	-
	Нийтэд тустай ажил хийлгэх ял	Ялтны тоо	1	-	-	1	-	-	-	-	-
		Мөнгөн дүн	300	-	-	300	-	-	-	-	-
Албадлагын арга хэмжээ авагдсан		Нийт этгээдийн тоо	52	83	91	9	44	57	43	39	34
Үүнээс	Тэнсэж, үүрэг хүлээлгэх эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ	тоо	48	70	73	7	32	41	41	38	32
	Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон	тоо	4	13	18	2	12	16	2	1	2

Дээрх хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн албадлагын арга хэмжээ авагдсан 91 этгээдүүдийг боловсролын түвшинг авч үзвэл 20-24 насны 3, 25-34 насны 32, 35-44 насны 29, 45-49 насны 19, 50-64 насны 10 ялтан буюу 80 ялтан 25-49 насны хооронд байгаа нь 89,2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6. Гэр бүлийн хүчирхийлийн улмаас гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа

Насны бүлгээр	Этгээд	Боловсролгүй	Бага	Бүрэн бус дунд боловсролтой	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Нийт	93	8	6	9	51	7	12
20-24	3	-	1	-	1	--	1
25-34	32	3	2	2	18	2	5
35-44	29	1	1	4	17	2	4
45-49	19	1	1	3	12	-	2
55-64	10	3	1	-	3	3	-

Статистик, мэдээ судалгаанаас харахад шинэчлэн батлагдсан Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш гэр бүлийн


¹⁰ Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны 2018, 2019, 2020 оны статистик, мэдээ

хүчирхийлийн улмаас гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийг тоон судалгаа өссөн үзүүлэлттэй байна. Боловсролын түвшингээр нь үзвэл боловсролгүй 8, бага боловсролтой 6, бүрэн бус дунд 9, тусгай мэргэжлийн 7, дээд боловсролтой 12 буюу бүрэн дунд боловсролтой 51 ялтан байгаа нь нийт ялтны 54,8 хувийг эзэлж байна.

3.Зөрчил:

Гэр бүлийн хүчирхийлийн улмаас зөрчил үйлдэж /ЗТХ-ийн 5.4/ Баривчлах төвд 2020 онд баривчлагдсан этгээдийн тоон судалгааг урьд оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 3. Гэр бүлийн хүчирхийлийн улмаас зөрчлийн хэрэг үйлдэж баривчлагдсан хүмүүсийн судалгаа /2019, 2020 оны 12.01-ны байдлаар/



Зөрчил үйлдэж баривчлагдсан 7420 этгээдийн насны түвшинг авч үзвэл 20-24 насны 319, 25-34 насны 2039, 35-44 насны 2692, 45-54 насны 1577, 55-64 насны 730 этгээд буюу 63,7 хувийг 25-44 насны хооронд эзэлж байна.

Хүснэгт 7. Гэр бүлийн хүчирхийлийн улмаас зөрчил үйлдэж баривчлагдсан этгээдийн боловсролын түвшин /2020 оны 12.01-ны байдлаар/

Насны бүлгээр	Нийт	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Нийт	7420	473	952	1640	2903	632	820
20-24	319	10	62	47	164	27	9
25-34	2039	21	206	506	966	175	165
35-44	2692	180	364	626	1061	196	265
45-54	1577	206	250	264	556	153	148
55-64	730	52	64	159	152	73	230
65 дээш	63	4	6	38	4	8	3

Гэр бүлийн хүчирхийлийн улмаас баривчлагдсан этгээдүүдээс 2019 онд 524 этгээд давтан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж баривчлагдаж байсан бол 2020 онд давтан энэ төрлийн зөрчил үйлдэж 140 этгээд баривчлагдсан байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулбал буурсан үзүүлэлттэй байна.

Дөрөв. Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих:

Жагсаал цуглааныг зохион байгуулагч, оролцогч нь:

-зэвсэг, хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис

-орчин тойрон, хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явсан бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.


Тав. Хүүхдийн эрхийг зөрчих:

Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Аливаа улс, үндэстний оршин тогтнох нэг гол үндэс суурь нь гэр бүлийн бат бэх харилцаа байдаг. Гэр бүлийн үнэт зүйл болох үр хүүхдээ тэжээн тэтгэх асуудал нь хүний ёс зүй, хариуцлагатай салшгүй уялдаатай бөгөөд нэгэнт гэр бүл цуцалсан тохиолдолд хүүхдийн тэтгэлэгийн асуудал яригддаг.


Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Энэхүү үүргээ эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэж болохоор хуульд заасан. Хэрэв тэтгэлэгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлэгийн хэмжээг хүүхдийн насны байдлыг харгалзан шүүх тогтоодог.

Зураг 4. Тэтгэлэг тогтоолгосон хүүхдийн тоо /2010-2019/



2019 оны жилийн эцсийн байдлаар хүүхдийн тэтгэлэгийн биелүүлбэл зохих 12783 гүйцэтгэх баримт бичгийн 41,8 тэрбум төгрөгөөс 1481 гүйцэтгэх баримт бичгийн 15,8 тэрбум төгрөгийг бодитой биелүүлснээс 10,6 тэрбум төгрөгийг хэсэгчлэн төлүүлжээ. Гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 11,6 хувийн үзүүлэлттэй, 11302 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна.

Зураг 5. 2011-2019 оны хүүхдийн тэтгэлгийн төлбөр барагдуулалтын байдал мөнгөн дүнгээр /сая.төг/¹¹



Зургаа. Бэлгийн дарамт учруулах

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.7-т “бэлгийн дарамт” гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэжээ.

Зөрчлийн тухай хуульд зааснаар бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Долоо. Хулгайлах

Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг албадан сургалтад хамруулж долоо хоноогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд 2020 оны эхний хагас жилийн байдлаар 338 хүн хулгайлах зөрчлөөр баривчлах шийтгэл эдэлсэн байна.

Найм.Хөрөнгө завших

Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоо хоноогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

2017 онд шинээр батлагдсан Зөрчлийн тухай хуульд 300,000 төгрөгнөөс доош хохирол учирсан бол хулгайлах, хөрөнгө завших зөрчил болохоор заасан.

¹¹ ШШГЕГ-ын 2018, 2019 оны үйл ажиллагааны тайлан

Ес. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Монгол Улсад үйлдэгдэж буй зөрчлийн дийлэнхи хэсгийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил эзэлдэг ба Цагдаагийн байгууллагад 2020 оны эхний хагас жилийн байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 1,972,075 бүртгэгдэн 600 хүн баривчлах шийтгэл эдэлсэн байна.

Улсын хэмжээнд зөвхөн 2020 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих-1,972,075, олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах-87,440, хүний биед халдах-14,653, иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих-13,525, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих-8,838, хүүхдийн эрхийг зөрчих-2,743, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих-2,571, танхайрах-3,150, гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих-903 нийт-2,105,898 зөрчил үйлдэгдсэн байна.

Зураг 6. 2020 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар улсын хэмжээнд үйлдэгдсэн зөрчлийн судалгаа

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ	903				
ТАНХАЙРАХ	3,150				
АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ..	2,571				
ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ЗӨРЧИХ	2,743				
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ..	8,838				
ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ..	13,525				
ХҮНИЙ БИЕД ХАЛДАХ	14,653				
ОЛОН НИЙТИЙН ГАЗАРТ ЗҮЙ БУСААР БИЕЭ..	87,440				
ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН..					1,972,075

1.1.1.Баривчлах байрны чиг үүрэг, хэрэгжилтэд хийсэн шинжилгээ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төв нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль Монгол Улсын олон улсын гэрээ, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон Баривчлах байрны дотоод журмыг удирдлага болгоно.

Шүүхийн шийтгэврээр оногдуулсан баривчлах шийтгэлийг нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа “Баривчлах төв”-д, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын харьяа “Баривчлах байр”-д эдлүүлж байна. Баривчлах төв нь хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаа нь дараах онцлог шинжтэй байна.

1.Шийтгэлийн зорилгоос хамааран баривчлах байрны чиг үүрэг нь тодорхойлогдож байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуульд зааснаар “шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино” гэжээ. Шийтгэлийн зорилготой уялдан баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны зорилго нь:

- дахин зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх;
- зөрчил үйлдсэн этгээдэд хуулиар тогтоосон нөхцөл, журам бүхий тусгай зориулалтын байранд саатуулах;
- нийгэмшүүлэх болон цээрлүүлэх арга хэмжээний зохистой харьцааг тогтоох зэрэг байна.


Эцсийн дүнд нийгэмд шударга ёсыг тогтоон, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан нийгмийн үнэт зүйлийг төлөвшүүлэхэд оршиж байна.

2.Баривчлах шийтгэлийг зөвхөн зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулсан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр оногдуулж байна.

3.Баривчлах шийтгэлийг хуулиар эрх олгогдсон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Цагдаагийн байгууллага гүйцэтгэж байна.

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд 2015-2020 оны хооронд шүүхээс оногдуулсан баривчлах шийтгэл эдлүүлсэн хүний тоог авч үзвэл, 2015 онд-6278, 2016 онд-3031, 2017 онд-5159,2018 онд-4356, 2019 онд 7815, 2020 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар-5584 хүн шийтгэл эдэлсэн байна.

Зураг 6. Баривчлах төвд шийтгэл эдэлсэн хүний судалгаа /2015-2020/



Баривчлах төвд 2020 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар баривчлагдсан этгээдүүдийн үйлдсэн зөрчлийн төрлийг авч үзвэл дийлэнхи нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн зөрчил байгаа нь анхаарал татаж байна.


Хүснэгт 8. Баривчлагдсан этгээдүүдийн үйлдсэн зөрчлийн төрөл /2020.12.01-ны байдлаар/

	д/д	Зөрчлийн тухай хуулийн заалт	Баривчлагдан ирсэн этгээдийн тоо	Эзлэх хувь
2020 он	1	Танхайрах /ЗТХ-5.2.1 олон нийтийн газар/	365	6.5%
	2	Мансуурах /ЗТХ-5.1.3/	51	0.9%
	3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих /ЗТХ-5.4.4/	4029	72.32%
	4	Хулгайлах /ЗТХ-8.6.1/	390	6.9%
	5	Хөрөнгө завших /ЗТХ-8.7.1/	2	0.03%
	6	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /ЗТХ-14.7.5 эрхгүй үедээ согтуугаар/	732	13.1%
	7	Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих /ЗТХ-5.13.2/	10	0.17%
	8	Хүүхдийн эрх зөрчих /6.20.6/	5	0.08%
	9	Бэлгийн дарамт учруулах /ЗТХ-6.26.1/	0	
Нийт			5584	100%

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төв нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудад заасан зөрчил гарган шүүхээс баривчлах шийтгэл оногдуулсан **32223** этгээдэд 7-30 хоногийн баривчлах шийтгэлийг эдлүүлсэн байна.

Судалгаанд хамрагдсан 452 этгээдийн баривчлах шийтгэлийн үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад 247 хүн буюу 54,6 ямар ч үр нөлөөгүй, 144 хүн буюу 31,8% нь дунд зэрэг, 61 хүн буюу 13,4% нь сайн үр нөлөөтэй байна гэж хариулжээ.

Зураг 7. Баривчлагдсан этгээдээс авсан баривчлах шийтгэлийн үр нөлөөнд хийсэн судалгааны дүн



Баривчлах төвд ажиллаж буй 41 алба хаагчаас баривчлах шийтгэлийн үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад 31 алба хаагч буюу 75,6% баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай, 9 алба хаагч буюу 21,9% нь ямар ч үр нөлөө алга, сайн үр нөлөөтэй гэж үзсэн алба хаагч байхгүй байна.

Зураг 8. Алба хаагчаас авсан баривчлах шийтгэлийн үр нөлөөнд хийсэн судалгааны дүн



Баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Баривчлах байрны дотоод журамд баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдлыг тогтоож өгчээ.

Нэг. Баривчлагдсан этгээдийн эрх, үүрэг:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 146.1-т “Баривчлагдсан этгээд нь баривчлах шийтгэл эдлэх хугацаандаа баривчлах байрны захиргаа, түүний алба хаагчийн хяналтад байх бөгөөд энэ хуулийн 210.1.1, 210.1.2, 210.1.3, 210.1.5, 210.1.9, 210.1.10, 210.1.11, 210.1.12, 210.1.13, 210.1.15-д заасан эрх эдэлж, энэ хуулийн 211 дүгээр зүйлд заасан үүрэг хүлээнэ” гэжээ.

Хүснэгт 9. Баривчлагдсан этгээдийн эрх, үүрэг холбогдох хууль, журамд туссан байдал:

д/д	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан байдал	Баривчлах байрны дотоод журамд туссан байдал
Нэг. Баривчлагдсан этгээдийн эрх /хоригдлын эрх/:		
1.	210.1.1. хорих ял эдлэх нөхцөл, журам, эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах; 210.1.2. хорих ангийн захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах; 210.1.3. өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах; 210.1.5. эмнэлгийн тусламж авах; 210.1.9. хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах,	Зургаа. Баривчлагдсан хүний эрх, үүрэг 6.1. Баривчлагдсан хүн дараах эрхийг эдэлнэ: 6.1.1. баривчлах төв /байр/-ийн нөхцөл, журам, өөрийн эрх, үүргийн талаар мэдээлэл авах; 6.1.2. хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах;

	<p>эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах; 210.1.10.хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах; 210.1.11.өөрөө зөвшөөрсөн эсэхээс үл хамааран эрүүл мэндэд нь эрсдэл учруулж болзошгүй аливаа туршилтаас ангид байх; 210.1.12.энэ хуульд заасан журмын дагуу зөвшөөрөгдсөн тоо, хэмжээний хоол, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн болон нэн тэргүүний бусад зүйл худалдан авах; 210.1.13.шашны зан үйл үйлдэх; 210.1.15.хуваарилагдан очсон хорих ангийн байршил, холбоо барих мэдээллийн талаар гэр бүлийн гишүүнд мэдэгдэх.</p>	<p>6.1.3.баривчлах төв /байр/-ийн ахуй нөхцөл, бусад асуудлаар гомдол, хүсэлт гаргах; 6.1.4.хууль, эрх зүйн туслалцаа авах; 6.1.5.эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах; 6.1.6.ахуйн хэрэгцээний эд зүйл худалдан авах; 6.1.7.хориглосноос бусад ном, сонин сэтгүүл, хэвлэл ашиглах;</p>
Хоёр.Баривчлагдсан этгээдийн үүрэг /хоригдлын үүрэг/:		
2.	<p>211.1.Хоригдол дараахь үүрэг хүлээнэ: 211.1.1.хорих ангид мөрдөх хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий албан тушаалтнаас баталсан дүрэм, журам, хорих байгууллага, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг заавал биелүүлэх; 211.1.2.хорих байгууллагаас тогтоосон цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдөх; 211.1.3.хорих байгууллагын алба хаагчаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахих; 211.1.4.тогтоосон журмын дагуу зохион байгуулж байгаа сургалтад хамрагдах; 211.1.5.эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөгөө, шаардлагыг биелүүлэх, хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх; 211.1.6.эзэмшиж байгаа эд хөрөнгө, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах, эвдэж гэмтээхгүй байх; 211.1.7.гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд уриалах, өдөөн хатгах, зохион байгуулах идэвхтэй үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх; 211.1.8.хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтан, бусад хоригдол болон хорих байгууллагад байгаа бусад хүнтэй хүндэтгэлтэй харьцах; 211.1.9.эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг сахих. 211.2.Хорих ангид суулт хийх, өлсгөлөн зарлах, хоригдол хөдөлгөөнт утас ашиглах, хадгалах</p>	<p>6.2.Баривчлагдсан хүн дараах үүрэг хүлээнэ: 6.2.1.баривчлах төв /байр/-ийн дотоод журмыг чанд сахин мөрдөх; 6.2.2.албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх; 6.2.3. эрүүл ахуй, ариун цэвэр сахих; 6.2.4.өөрт эзэмшүүлсэн эд зүйлсэд ариг гамтай хандах; 6.2.5.зохион байгуулж буй сургалтанд тогтмол хамрагдах;</p>

<p>болон бэлэн мөнгө, валют, үнэт зүйл ашиглах, хадгалахыг хориглоно.</p> <p>211.3.Хоригдол энэ хуульд заасан эрхээ эдлэхдээ энэ хууль, хорих ангийн дотоод журам болон бусад хоригдол, хорих ангийн алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх үүрэгтэй.</p> <p>211.4.Хорих ял эдэлж байгаа гадаадын иргэн энэ зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээхийн зэрэгцээ гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгжээр дамжуулан өөрийн улсын Дипломат төлөөлөгчийн газрын ажилтантай уулзах, харилцах эрхтэй.</p>	
--	--

Дээрхээс хүснэгтээс харахад баривчлагдсан этгээдийн эрх, үүргийг хоригдолтой адилтгасан нь ойлгомжгүйгээр барахгүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хоригдлын эрхийг эдлэх боловч дахин Баривчлах байрны дотоод журмаар мөн адил эрх эдлэх нь тодорхойгүй байдал үүсгэж байна.

Хоёр.Баривчлах байрны ахуй нөхцөл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.1."Баривчлагдсан этгээд нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 24.1, 24.4-д заасан ахуйн хангамжаар, энэ хуулийн 231.6-д заасан хэмжээний илчлэгтэй хоол, хүнсний зүйл болон хувцас, хэрэгцээтэй үедээ хэрэглэх ундны усаар хангагдана" гэж заажээ.


Хүснэгт 10.Баривчлах байрны ахуй нөхцөл холбогдох хууль, журамд туссан байдал:

<p>Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд туссан байдал</p>	<p>Баривчлах байрны дотоод журамд туссан байдал</p>
<p>24.1.Хоригдсон этгээд нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөл, унтаж амрах боломжоор хангагдана.</p> <p>24.5.Хоригдсон этгээд нь аллага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад ном, сонин, сэтгүүлийг хорих өрөөндөө байлгаж болно.</p>	<p>2.2.Баривчлах төв /байр/ нь агааржуулах төхөөрөмжтэй байх ба байгалийн болон ердийн гэрэлтүүлэгтэй, салхивчтай байна.</p> <p>2.3.Баривчлах төв /байр/-д нэг хүнд ноогдох зай талбайн хэмжээ нь 2.5м²-с багагүй байна.</p> <p>Долоо.Баривчлагдсан хүний ахуй хангамж, үйлчилгээ</p> <p>7.1.Баривчлагдсан хүний бие, өрөөнд дараах эд зүйл байлгахыг зөвшөөрнө:</p> <p>7.1.1.тухайн улирлын хувцас.дотуур хувцас;</p> <p>7.1.2.ариун цэврийн хэрэгсэл /оо, сойз, гар нүүрийн болон эдийн саван, алчуур, сахлын машин, жижиг хэмжээтэй 1 үйлдэлтэй хумсны хутга, нүүр, гарын тос, хуурай, нойтон салфетка, ариун цэврийн цаас, эмэгтэй хоригдлын хувьд ариун цэврийн хэрэглэл, гоо сайхны хэрэгсэл/;</p> <p>7.1.3.хучлага, гудас, ор хөнжлийн даавуу;</p>

	<p>7.1.4.эрүүл ахуйн шаардлага хангасан хоёр килограмм хүртэлх гурилан бүтээгдэхүүн;</p> <p>7.1.5.эмчийн бичгээр зөвшөөрсөн мансууруулах, тайвшруулахаас бусад эм /тоо, ширхэг, нэрийг дурьдсан байна/-ийг сувилагчид хадгалуулан, шаардлагатай үед жорын дагуу авч хэрэглэх;</p> <p>7.1.6.аллага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад сонин, ном, сэтгүүл 5-с дээшгүй, тэмдэглэлийн дэвтэр, хуванцар гадартай тосон бал тус бүр 1 ширхэг;</p> <p>7.2.Энэ журмын 7.1-д зааснаас бусад эд зүйлсийг баривчлагдсан хүний бие болон өрөөнд байлгахыг хориглоно.</p> <p>7.3.Баривчлах төв /байр/ нь эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн халуун усны өрөөтэй байна.</p> <p>7.4.Баривчлагдсан хүнийг долоо хоногт нэг удаа усанд орох боломжоор хангана.</p> <p>7.5.Халуун усанд ороход шаардагдах ариун цэврийн хэрэгсэл/ савангаас бусад/-ийг баривчлагдсан хүн өөрөө хариуцана.</p> <p>7.6.Баривчлагдсан хүний өөрийнх нь хүсэлтээр буюу ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын дагуу түүний үсийг засна;</p> <p>7.7.Баривчлагдсан хүнд олгож буй хучлага, гудас, ор дэвсгэрийн хэрэгслийг угааж, ариутгасан байна.</p> <p>7.8.Энэ журмын 7.1.3-т зааснаас бусад эд зүйлийг баривчлагдсан хүн өөрөө хариуцна.</p>
--	--


Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээд баривчлагдан этгээдийн эрхийг хангах ажлыг та хэрхэн дүгнэж байна вэ? гэсэн асуултанд 228 хүн буюу 50,4% нь сайжруулах шаардлагатай, 146 хүн буюу 32,3% нь муу, 78 хүн буюу 17,2% нь хангалттай сайн гэж хариулжээ.

Зураг 9. Баривчлагдсан этгээдүүдээс авсан эрхийн баталгааны чиглэлээрх судалгааны дүн



Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээд баривчлах байрны нөхцөл, журам таны хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу? гэсэн асуултанд 151 хүн буюу 33,4% нь муу, 78 хүн буюу 17,2% нь сайн, 223 хүн буюу 49,3% нь хангахгүй байна гэж хариулжээ.

Зураг 10. Баривчлагдсан этгээдүүдээс авсан баривчлах байрны нөхцөл, журмын талаарх судалгааны дүн




Гурав.Баривчлагдсан этгээд бусадтай харилцах:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 146.3-т “Баривчлагдсан этгээд 7 хоногт нэг удаа 1 цаг хүртэл хугацаагаар бусадтай уулзалт хийж, нэг удаа илгээмж авч, нэг удаа захидал илгээж болно”, 146.4-т “Баривчлагдсан этгээд өдөрт 1 цагаас доошгүй хугацаагаар гадаалах, биеийн тамирын дасгал хийх болон 7 хоногт нэг удаа 5 минутаас ихгүй хугацаагаар утсаар ярьж болно”, холбогдох зардлыг өөрөө хариуцна гэжээ.

Баривчлагдсан хүн нь ажлын 5 хоногт 1 удаа, 1 цагаас ихгүй хугацаагаар бусадтай уулзах, 1 удаа илгээмж авах, 1 удаа захидал илгээж болно.Нийгмийн ажилтны зөвшөөрлөөр 7 хоногт 1 удаа 5 минутаас ихгүй хугацаагаар утсаар ярьж болно. Уулзалтыг баривчлах төв /байр/-ийн даргын баталсан хуваарийн дагуу дарга, дэд даргын зөвшөөрлөөр ээлжийн даргын хяналтад зохион байгуулна. Баривчлагдсан хүн нь 1 цагаас дээшгүй хугацаагаар гэр бүлийн гишүүн, найз нөхөдтэйгээ уулзаж болох бөгөөд харуул хамгаалалтын ажилтан байнгын хяналт тавих ба хориотой эд зүйл дамжуулахыг хориглоно. Харуул хамгаалалтын ажилтан нь уулзалтаар хүлээн авсан эд зүйлд үзлэг хийж, энэ журмаар зөвшөөрсөн эд зүйлийг баривчлагдсан хүнд хүлээлгэн өгөх, зөвшөөрснөөс бусад эд зүйлсийг уулзалтаар ирсэн хүнд буцаан өгч, тэмдэглэл үйлдэнэ.

Зураг 11.Баривчлагдсан этгээдүүдээс 2015-2019 онд ар гэртэйгээ түр уулзалт хийсэн судалгаа



Баривчлах төв /байр/-ийн даргын баталсан хуваарийн дагуу баривчлагдсан хүнийг өдөрт 1 цагаас багагүй хугацаагаар гадаалуулж, биеийн тамирын дасгал хийлгэх ба хэт халуун, хүйтэн зэрэг цаг агаарын хүндрэлтэй үед гадаалуулах эсэхийг төв /байр/-ийн дарга шийдвэрлэнэ.

Дөрөв.Баривчлагдсан этгээдийн цай, хоол:

Баривчлагдсан хүнд өдөрт 2 удаа халуун хоол, гурван удаа цай, нэг удаа гурилан бүтээгдэхүүн өгөх бөгөөд баривчлагдсан нэг хүнд ногдох хоногийн хоолны илчлэг нь 2800 килокалориос багагүй, 0.5 литр байх ба хэрэгцээт үедээ уух ундны усаар хангагдана. Баривчлагдсан хүнд хоногт олгож буй хоолны дээжийг улирал тутамд шинжилгээнд өгч, илчлэгийг тодорхойлуулах бөгөөд хууль тогтоомжид заасан хэмжээнд хүрээгүй бол нэмэгдүүлэх арга хэмжээ авна. Хоолны илчлэг тодорхойлуулсан баримтыг Баривчлах төв /байр/-ийн санхүүд хадгална.


Эмч нь хоол бэлтгэх, боловсруулах, олгох явц, хүнсний хадгалалт, хамгаалалт, гал тогоо, хоолны хэрэгслийн ариун цэвэр, цэвэрлэгээ, эрүүл ахуйн шаардлагад өдөр тутам хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, хоолны дээжийг хадгалан, 72 цагийн дараа бүртгэл хөтлөн устгана. Албаны тогооч нь хоолны орц, амт чанар, түүнчлэн баривчлагдсан хүн бүрт хоол олгогдож байгаа эсэхэд хяналт тавих ба хамгаалалтын ажилтнууд хоол олгох үед байлцана. Баривчлах төв /байр/-ийн, гал тогоонд баривчлагдсан хүнд нэг өдөрт олгогдох хүнсний орц, 7 хоногийн хоолны цэсийг ил байрлуулдаг байна.

Баривчлах төв болон байрны захиргаанаас дараах төрлийн төлбөрт үйлчилгээг баривчлагдсан хүнд үзүүлж болно. Үүнд:

- 1.төлбөрт өрөөнд байрлуулах;
- 2.захиалгаар хоол, хүнсний бүтээгдэхүүн, ариун цэвэр, ахуйн хэрэглээний зүйлс, ном, сонин, сэтгүүл зэргийг худалдаалах.

Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээд баривчлах байрны хоолны чанар, хүртээмжийн шаардлагыг тань хангаж байна уу? гэсэн асуултанд 31 хүн буюу 6,8% нь хүртээмжтэй сайн, 174 хүн буюу 38,4% нь сайжруулах шаардлагатай, 247 хүн буюу 54,6% нь муу гэж хариулжээ.


Зураг 12.Баривчлагдсан этгээдээс авсан хоолны чанар, хүртээмжийн талаарх судалгааны дүн



Тав.Баривчлагдсан этгээдийн гаргасан гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэсэн байдал:

Баривчлагдсан хүн нь баривчлах төв /байр/-ийн нөхцөл байдал болон алба хаагчдын зан, харилцааны талаар гомдол, хүсэлт гаргаж болно. Баривчлах төв /байр/-ийн нийгмийн ажилтан нь гомдол, хүсэлт гаргасан хүнтэй биечлэн уулзаж, энэ талаар төв /байр/-ийн даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Зураг 13.Баривчлагдсан этгээдүүдээс авсан алба хаагчдын харьцааны талаарх судалгаа:



Өнөөдрийн байдлаар зөвхөн нийслэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төв нь баривчлах шийтгэлийг эдлүүлж байна. Зөрчлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу улсын хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь орон нутаг дахь салбар нэгжүүдээрээ баривчлах шийтгэлийг гүйцэтгэх нь удирдлага, зохион байгуулалт, эрх зүй, хүний нөөц, төсөв, санхүүгийн олон асуудлыг дагуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг орон нутагт Цагдаагийн байгууллага гүйцэтгэж байгааг 2021 оноос үе шаттайгаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Судалгааны ажлын хүрээнд баривчлах шийтгэл оногдуулсан этгээдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа орон нутаг дахь газар, хэлтсүүдэд шилжүүлэх боломжтой эсэх талаарх ирүүлсэн судалгаанаас харахад дараах газруудад өргөтгөл, засвар үйлчилгээ хийж, алба хаагчийн орон тоог шийдвэрлэснээр баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийг хүлээн авах боломжтой байна. Үүнд:

Нэг. Цагдан хорих байруудын нөхцөл байдал болон баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийн тоон судалгаа, баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийг хүлээн авах боломжтой газруудын талаар.

-Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр нь 2015 оны 10 дугаар сарын 25-ны өдөр ашиглалтад орсон ба 1350 м² талбай бүхий 2 давхар барилга юм. Тус газрын цагдан хорих байр нь сахилгын байр, тусгаарлах тасалгаа, насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй болон өсвөр насны хоригдогч хүлээн авах зориулалт бүхий нийт 20 хорих өрөөтэй бөгөөд 80 хоригдогч хүлээн авах багтаамжтай. Цагдан хорих байранд сард дунджаар 18-19 хүн шинээр хоригддог

бөгөөд 2019 онд нийт 224 хүн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж хоригдсон байна. Он гарсаар өнөөдрийн байдлаар нийт 57 хүн шинээр хоригдсон нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 5 хоригдогч буюу 8,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өнөөдрийн байдлаар цагдан хорих байранд 32 хоригдогч хоригдож байна.

Тус аймагт 2017 онд 456, 2018 онд 309, 2019 онд 282, нийт 1047 буюу сард дунджаар 23-38 хүн баривчлах шийтгэлээр шийтгүүлж байх тул тус газрын цагдан хорих байрны 2 дугаар давхрын 12 хорих өрөөнд засвар хийснээр баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн хүнийг хүлээн авах боломжтой;

-Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр нь 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдөр ашиглалтад орсон ба 1395 м² талбай бүхий 2 давхар барилга юм. Тус газрын цагдан хорих байр нь сахилгын байр, тусгаарлах тасалгаа, насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй болон өсвөр насны хоригдогч хүлээн авах зориулалт бүхий нийт 18 хорих өрөөнтэй бөгөөд 54 хоригдогч хүлээн авах багтаамжтай. Цагдан хорих байранд сард дунджаар 2-3 хүн шинээр хоригддог бөгөөд 2019 онд нийт 33 хүн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж хоригдсон байна. Он гарсаар өнөөдрийн байдлаар нийт 16 хүн шинээр хоригдсон нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 4 хоригдогч буюу 20 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өнөөдрийн байдлаар цагдан хорих байранд 9 хоригдогч хоригдож байна. Тус аймагт 2017 онд 131, 2018 онд 142, 2019 онд 80, нийт 353 буюу сард дунджаар 7-11 хүн баривчлах шийтгэлээр шийтгүүлж байх тул цагдан хорих байрны 2 дугаар давхрын 9 хорих өрөөнд засвар хийснээр баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн хүнийг хүлээн авах боломжтой;

-Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр нь 2015 оны 12 дугаар сард ашиглалтад орсон ба 546 м² талбай бүхий 2 давхар барилга юм. Тус газрын цагдан хорих байр нь сахилгын байр, тусгаарлах тасалгаа, насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй болон өсвөр насны хоригдогч хүлээн авах зориулалт бүхий нийт 12 хорих өрөөтэй бөгөөд 48 хоригдогч хүлээн авах багтаамжтай. Цагдан хорих байранд сард дунджаар 5-6 хүн шинээр хоригддог бөгөөд 2019 онд нийт 66 хүн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдан хоригдсон байна. Он гарсаар өнөөдрийн байдлаар нийт 41 хүн шинээр хоригдсон нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 12 хоригдогч буюу 29,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өнөөдрийн байдлаар цагдан хорих байранд 14 хоригдогч хоригдож байна.

Тус аймагт 2017 онд 195, 2018 онд 224, 2019 онд 201, нийт 620 буюу сард дунджаар 15-20 хүн баривчлах шийтгэлээр шийтгүүлж байх тул цагдан хорих байранд өргөтгөл засвар хийснээр баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн хүнийг хүлээн авах боломжтой;

-Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангийн цагдан хорих байр нь 2014 онд ашиглалтад орсон ба 240 м² талбай бүхий албан контор, нэг цонх, цагдан хорих байр бүхий 3 давхар барилга юм. Тус ангийн цагдан хорих байр нь сахилгын байр, тусгаарлах тасалгаа, насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй болон өсвөр насны хоригдогч хүлээн авах зориулалт бүхий нийт 20 хорих өрөөтэй бөгөөд 80 хоригдогч хүлээн авах багтаамжтай. Цагдан хорих

байранд сард дунджаар 13-14 хүн шинээр хоригддог бөгөөд 2019 онд нийт 160 хүн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдан хоригдсон байна. Он гарсаар өнөөдрийн байдлаар нийт 81 хүн шинээр хоригдсон нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 8 хоригдогч буюу 9,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өнөөдрийн байдлаар цагдан хорих байранд 35 хоригдогч хоригдож байна.

Тус аймагт 2017 онд 384, 2018 онд 791, 2019 онд 835, нийт 2010 буюу сард дунджаар 13-40 хүн баривчлах шийтгэлээр шийтгүүлж байх тул цагдан хорих байранд өргөтгөл засвар хийснээр баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийг хүлээн авах боломжтой;

-Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн цагдан хорих байр нь 1985 оны 11 дүгээр сарын 10-нд онд ашиглалтад орсон хуучин барилга ба 700 м² талбай бүхий 1 давхар хуучин барилга юм. Тус ангийн цагдан хорих байр нь сахилгын байр, тусгаарлах тасалгаа, насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй болон өсвөр насны хоригдогч хүлээн авах зориулалт бүхий нийт 15 хорих өрөөтэй бөгөөд 28 хоригдогч хүлээн авах багтаамжтай. Цагдан хорих байранд сард дунджаар 13-14 хүн шинээр хоригддог бөгөөд 2019 онд нийт 159 хүн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдан хоригдсон байна. Он гарсаар өнөөдрийн байдлаар нийт 77 хүн шинээр хоригдсон нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 2 хоригдогч буюу 2,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өнөөдрийн байдлаар цагдан хорих байранд 27 хоригдогч хоригдож байна.


Тус аймагт 2017 онд 77, 2018 онд 269, 2019 онд 302, нийт 648 буюу сард дунджаар 5-15 хүн баривчлах шийтгэлээр шийтгүүлж байх тул цагдан хорих байрны дэргэд 44 хүний багтаамжтай баривчлах байранд засвар хийснээр баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийг хүлээн авах боломжтой байна.

Хоёр. Баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийг хүлээн авахад шаардлагатай алба хаагчдын бүтэц, орон тоо, судалгаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-т баривчлах байрны орон тооны талаар тусгаагүй байх тул дээрх газруудад баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдэд тавих хяналт, харуул хамгаалалтыг эхний ээлжинд газар тус бүрт сэтгэл зүйч 1, хамгаалалтын ажилтан 4, сувилагч 4, дүрс бичлэгийн хяналтын ажилтан 4, буюу нийт 65 алба хаагчийн орон тоонд, цалингийн сангийн тооцоолол хийхэд жилд 662.8 сая төгрөг, НДШ-н зардалд 13.3 сая төгрөгийн тооцоо судалгаа гарч байна.

ШШГЕГ-ын харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн 61 алба хаагчаас ШШГБ-аас аймаг, орон нутагт баривчлагдсан этгээдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулах боломж өнөөгийн нөхцөлд бий юу? гэсэн асуулгад бүрэн боломжтой-9, хугацаа болоогүй-0, бэлтгэл ажлыг сайтар хангах хэрэгтэй-41, мэдэхгүй-11 хариулсан байна.

Зураг 14. ШШГБ-ын орон нутгийн алба хаагчдаас авсан баривчлах шийтгэл эдлүүлэх бэлтгэл ажлын талаарх асуулгын дүн:



Судалгааны дүнгээс харахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас баривчлах шийтгэлийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн зайлшгүй бэлтгэл ажил шаардлагатай байна.

1.2.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын төрөл, хэлбэр

Баривчлах байр, төв буюу баривчлагдсан этгээдийн дунд явуулах нийгэмшүүлэх ажил нь зан үйлд нөлөөлөх сургалт болон сэтгэл зүйн үйлчилгээ гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд явагдана.

Зөрчлийн хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5-т Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна гэжээ. Баривчлах байрны дотоод журамд зааснаар баривчлах төв /байр/ нь сургалтын танхимтай байх бөгөөд шүүхийн шийтгэвэрт заасан хугацаагаар албадан сургалтад хамруулна, сургалт нь баривчлагдсан хүний зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх бөгөөд хөтөлбөрийн дагуу явагдана, сургалтыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болохоор заасан байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь:

- 1.Сэтгэл зүйн сургалт
- 2.Эрх зүйн сургалт гэсэн төрөлтэй байна.

Нэг. Сэтгэл зүйн сургалт:

Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр боловсруулан, түүнийг хорих ангид хэрэгжүүлэх нь өнөөгийн нийгэмд ихээхэн чухал буюу цаг үеэ олсон, үр дүнтэй ажлын нэг юм. Хэдийгээр манай оронд сэтгэл зүйн үйлчилгээ хөгжөөд төдийлөн удаагүй байгаа ч хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх салбарт энэхүү үйлчилгээг хөгжүүлж буй сайшаалтай бөгөөд нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж байна. Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхой түвшинд ахиулахад тухайн нийгмийн хувь хүн бүрийн хөгжил чухал байр суурь эзэлнэ. Өөрөөр хэлбэл, хувь хүн бүрийн хөгжлөөс улс орны хөгжил хамаарна гэсэн үг. Гэтэл манай нийгмийн өнөөгийн байдлыг авч үзвэл нийт хүн амын тодорхой хувь нь (0.3 орчим) хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ял эдэлж байна. Эдгээр хүмүүсийн дунд нэлээдгүй хувь нь нэг бус удаа буюу дахин гэмт хэрэг үйлдсэн бөгөөд тэднийг ял эдэлж байх хугацаанд нийгэмшүүлэх, төлөвшүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тодорхой хэмжээгээр зохион байгуулдаг ч үр дүн төдийлөн гардаггүй. Энэ нь тэдэнд чиглэсэн үйл ажиллагаа нь салангид буюу зохион байгуулалтгүй, түүнийг хэрэгжүүлж буй мэргэжилтнүүдийн мэдлэг, чадвар, туршлага дутмаг, мөн тэднийг төлөвшүүлэх тодорхой зорилго бүхий хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдээгүй зэрэг олон хүчин зүйлстэй холбоотой юм.

Гэмт хэрэг үйлдсэн хүмүүс тодорхой хугацаанд ял эдэлж, тэдэнд шийтгэл хүлээлгэж байгаа ч ял эдэлнэ гэдэг нь зөвхөн эрхийг нь хязгаарласан орчинд он жилүүдийг өнгөрөөнө гэсэн үг биш, харин энэ хугацаанд тухайн хоригдогчийн

асуудал бүхий буюу нийгмийн эсрэг зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн янз бүрийн үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлж, тухайн хүнийг засаж залруулах нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэх болно. Хэдийгээр ял эдлэх хугацаанд нь хөдөлмөр эрхлүүлж, түүгээр дамжуулан тухайн хүнд эерэг нөлөөлөл бий болгохыг зорьж байгаа ч бидний хүсэн хүлээж буй үр дүнд төдийлөн гарахгүй байна. Харин хоригдогчдын хувьд ажил хөдөлмөр эрхэлснээрээ нэг талаас цаг хугацааг өнгөрүүлэх, нөгөө талаас ялын хоногыг багасгах талаас нь тусган авч буй байдал ажиглагдаж байна.

Дэлхийн улс орнуудын жишгээс харахад ял эдэлж буй хоригдогчдод зориулсан олон төрлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээр нь хоригдогчдын хандлага, зан үйлийг өөрчилж, дахин гэмт хэрэг үйлдэхээс бүрэн сэргийлэхэд чиглэгдсэн байна. Бидний зорилго ч мөн адил хоригдогчийг төлөвшүүлж, өөрсдийн зан үйл, хандлагаа өөрчлөн, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлж, нийгэмд хариуцлагатай иргэн болж, зөв замаар бие даан амьдрахад тэдэнд туслах явдал юм. Үүний тулд тодорхой системтэй хөтөлбөр боловсруулж, түүний дагуу ажиллан, үр дүнг тооцож, сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх шаардлагатай байна.

Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийн хамрах хүрээ:

Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ял эдэлж буй хоригдогчдын дунд хэрэгжүүлнэ. Тэдэнд зориулан сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр нь дараах чиглэлээр боловсруулагдсан болно. Үүнд:

1. Удиртгал хөтөлбөр
2. Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх
3. Харилцааны чадвар сайжруулах
4. Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх
5. Уур бухимдлаа зохицуулах
6. Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх
7. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх

Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрт хорих ангид ял эдэлж буй бүхий л хоригдогчдыг хамруулахыг зорих боловч нэг бүлэгт хамрагдах хүмүүсийг сонгохдоо хоригдогчийн үйлдсэн гэмт хэргийн төрөл, хувь хүний онцлог, хандлага, нийгмийн чадварын түвшин зэргийг харгалзах хэрэгтэй. Зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн аливаа хөтөлбөрүүдэд ердийн нөхцөлд өөрийн хүсэл эрмэлзлийн дагуу хамрагдаж буй хүмүүс мэдэгдэхүйц ахиц өөрчлөлтөд буюу үр дүнд хүрдэг. Гэвч хорих ангийн нөхцөлд өөрийн хүсэлтээр гэхээс илүүтэй байгууллага, нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу албадлагаар хөтөлбөрт хамруулах магадлалтай.

Сэтгэл зүйн үйлчилгээний ямар хөтөлбөрт хэн хамрагдах шаардлагатайг хоригдогч хорих ангид ирсэн даруйд үнэлгээ хийж тодорхойлох ёстой. Гэхдээ хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлж эхлэх гэж буй өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан тус асуудалд уян хатан хандах хэрэгтэй.

Сэтгэл зүйн үйлчилгээний тодорхой нэг хөтөлбөрт хамрагдсан хүн өөр бусад хөтөлбөрт хамрагдах бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл, хэрвээ шаардлагатай бол нэг хүн бусад боломжтой бүх хөтөлбөрт хамрагдаж болно. Харин хэрвээ тухайн хүн архины хамааралгүй, мөн хүчингийн гэмт хэрэг үйлдээгүй бол эдгээрт чиглэсэн хөтөлбөрт хамрагдах шаардлагагүй.

Сэтгэл зүйн үйлчилгээний дээр өгүүлсэн 6 чиглэлийн хөтөлбөрт хоригдогчдийн нийгэм, сэтгэл зүйн байдал болон архины хэрэглээний түвшинг тодорхойлсон үнэлгээгээр ерөнхийдөө архины хамааралтай, харилцааны ерөнхий чадвар сул, өөрийн үнэлэмж доогуур, уураа барьж чаддаггүй, хүчирхийлэгч зан авиртай, хүчингийн гэмт хэрэг үйлдсэн зэрэг хүмүүсийг хамруулна гэж үзвэл ял эдэлж буй бүхий л хоригдогч хамрагдана.

Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх хөтөлбөр:

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын практикт ихэвчлэн дараах 3 загварыг ашигладаг. Үүнд:

- Танин мэдэхүй – зан үйлийн онол нь архины шалтгаант зан үйлийн гажуудлыг уураг тархины дээд мэдрэлийн үйл ажиллагаатай холбоотой учир шалтгаан, хийсвэр бодол, мэдрэхүй, тооцоолон бодох, хэл яриа, ой санамж, бодол санаанд нөлөөлснөөр биеэ авч явах байдлыг өөрчлөхөд чиглэгдэнэ.

- Сэтгэл зүй, оюун санааны боловсролын загвар нь гол зорилго нь архи уухаа зогсоох биш харин бие болон оюун, сэтгэцийн хувьд эрүүлжих явдал байдаг. Архи уухгүй байж тэсвэрлэх нь сэтгэл зүйн эмчилгээний эцсийн зорилго биш харин эмчилгээний нэгэн арга юм. Өөрийн өөрчлөгдсөн зан чанараа буцаан олж, өөрийн хийсэн үйлдлээ хүлээн зөвшөөрөх, уудаггүй байх үеийн сайхан мэдрэмжийг олж цаашдын замналаа болгож хэвшүүлэхэд гол үндэс суурь нь болно.

- Фармакологийн загвар нь архины хамаарлыг бие махбодын зүгээс бууруулахад чиглэсэн дисульфирамын бүлгийн эмийн бэлдмэлийг хэрэглэх арга хандлага юм. Үүнийг ашиглахын тулд сэтгэцийн эмч, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах хэрэгтэй.

Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх хөтөлбөр нь дараах 12 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Өөрийн үйлдлээ тунгаан бодох, эргэн санах, хүлээн зөвшөөрөх
2. Өөрийн зан чанартаа дүн шинжилгээ хийх, дотны харилцаа үүсгэх
3. Архи, согтууруулах ундааны сөрөг үр дагавар, үр нөлөөг ухаарах
4. Өөрийгөө мэдэрч ойлгох
5. Архинд донтох эмгэгийн талаар танин мэдэх
6. Архины шалтгаант сэтгэцийн болон бие махбодын хамаарлыг ойлгох
7. Шийдвэр гаргах чадвараа хөгжүүлэх нь
8. Сэтгэлийн хөдөлгөөнөө хянаж, зохицуулах нь
9. Царцмал мэдрэмжийг хайлуулах, нээлттэй харилцаа холбоо тогтоох чадварыг нэмэгдүүлэх
10. Гэр бүл, нийгмийн үнэ цэнэ, давхар хамаарал
11. Архигүй эрүүл амьдралын богино болон урт хугацааны төлөвлөгөө зохиож сурах, сонголтоо хийх

12. Эрсдэлийг тодорхойлох, түүнээс сэргийлэх төлөвлөгөө боловсруулах.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөөний 1 удаагийн уулзалт 1 цаг 30 минут үргэлжлэх бөгөөд уулзалтын давтамж долоо хоногт 1 удаа байна. Нийт 12 удаагийн бүлгийн зөвлөгөөний уулзалтыг зохион байгуулах ба хөтөлбөрийг 2,5-3 сарын хугацаанд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт хамрагдах хүмүүсийг асуумжын судалгаар үнэлэн сонгож бүлэг болгон зохион байгуулна. Тухайн хорих ангийн онцлог, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжилтний нөөц боломж зэргээс шалтгаалан бүлэгт 5-аас 10 хүртэлх тооны хүмүүсийг хамруулж болно. Гэхдээ архины шалтгаант зан үйлийн улмаас хоригдогчдын зан үйлийг өөрчлөх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг бүлгээр хэрэгжүүлэх нь хамгийн тохиромжтой хэмжээ юм. Бүлгийг хаалттай байдлаар зохион байгуулна. Хөтөлбөрийн хугацаанд бүлэг доторх хувь хүнтэй ганцаарчлан ажиллана. Эдгээр зүйлсийг тооцон нэг хорих анги дээр хэчнээн бүлэг үүсгэж, зэрэгцүүлэн ажиллаж болохыг сэтгэл зүйчид байгууллагын удирдлагатай хэлэлцэж, шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, хэрвээ нэг хорих ангид 2-3 сэтгэл зүйч ажилладаг бол нэгэн зэрэг 2-3 бүлэг үүсгэж тус хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна. Үүнд:

- Бусдад хор хохирол учруулсан зан үйлдээ дүгнэлт хийж, өөрийн буруутай үйлдлийг ухамсарласан байна.
- Согтуугаар болон гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн өөрийн зан чанар, дотоод нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, өөрийгөө таньж мэднэ.
- Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлөх гадаад буюу орчны хүчин зүйлсийг тодорхойлж, түүнээс сэргийлэхэд хэрэгтэй зүйлсийг ойлгосон байна.
- Эрсдэлтэй зан үйлийг бууруулах, зохицуулах, засаж сайжруулахад хэрэгцээтэй чадваруудыг тодорхой хэмжээгээр хөгжүүлсэн байна.
- Нийгэмд буюу олон нийтийн дунд аюулгүй иргэн байхад хэрэгтэй хандлага, бодол санаа, зан үйлд суралцсан байна.
- Өөрийгөө захирч чаддаг болоход суралцсан байна.
- Согтуугаар болон гэмт хэрэг дахин үйлдэх эрсдэлээс сэргийлэх, зохицуулах чадвар эзэмшсэн байна.
- Эрүүл зөв амьдрах мэдлэг хандлагатай болж, архи, согтууруулах ундааны хэрэглээгүй зөв амьдралын сонголтыг хийж, дадал сууна.

Харилцааны чадвар сайжруулах хөтөлбөр:

Харилцаа гэж юу вэ? Харилцаа нь зөвхөн мэдээлэл дамжуулаад зогсохгүй бүлэг ба хамт олны амьдралын явцад хүмүүс бие биетэйгээ харилцан үйлчлэлцэх, үзэл санаа, итгэл үнэмшил, хандлагаа солилцож тогтсон хандлагыг төлөвшүүлэх үйл явцыг харилцаа гэнэ. Харилцааны үед үр дүнг бүхэлд нь тодорхойлж байдаг.

I. Мэдээллийн хэлхээ холбоо

II. Зохицуулалтын хэлхээ холбоо

III. Сэтгэл хөдлөл мэдрэмжийн хэлхээ холбоо гэсэн 3 чиг үүрэг хэрэгждэг. Харилцааны сэтгэл зүйн үндсэн бүрдлүүд

- I. Мэдээлэл
- II. Сэтгэл хөдлөл, мэдрэмж
- III. Хандлага
- IV. Хувийн өвөрмөц онцлог

Мэдээлэл

Харилцагчид эхлээд мэдээллийг бэлтгэх боловсруулах, оновчтой арга замаар харилцагчдаа дамжуулах, ойлгож хүлээн авах зан үйл, аргад суралцан зохих хэмжээнд нь асуудлыг цогцоор нь шийдэх чадвар дадал, сэтгэл санааны бэлтгэлтэй байх шаардлагатай.

Сэтгэл хөдлөл, мэдрэмжийн онцлог нь аливаа хүн гадаад дотоод нөхцөл байдлын өөрчлөлтөөс хамаарч зан үйл, хандлага, сэдэл сонирхолоо өөрчлөхөд хүрдэг.

Гадаад дотоод учир шалтгааны үүднээс хүний сэтгэл санаанд олон талын өөрчлөлт үүсэх бөгөөд үүний үр дүнд тодорхой зүйлд анхаарлаа хандуулах, юмс үзэгдлээс түр хугацаагаар хөндийрэх, орчны өөрчлөлтөд дасан зохицох, уян хатан хандах сэтгэл зүйн боломж бүрддэг.

Харилцааны нэг чухал хэсэг болсон сэтгэл хөдлөлийн байдал нь харилцагчдын зүгээс олон янзын үнэлгээ, чиг баримжаа, хандлагыг төрүүлэх ба энэ нь харилцан үйлчлэлийг тодорхой өнгө аястай болгон чимж байдаг.

Харилцагчийн зан үйлд гарч буй өөрчлөлтүүдийг олж харах, сонсоход тухайн хувь хүний дотоод сэтгэл, сэтгэл хөдлөлийн өнгө төрх, мэдрэмж нэн чухал үүрэгтэй. Хүний сэтгэл хөдлөлийн хөөрлийн байдал хэт сул байх юм бол үйл ажиллагааны өдөөлт, түлхэц, сэдлийн таатай нөхцөлийг хангаж чадахгүйд хүрнэ. Гэтэл хэт хөөрөл үүсэх юм бол мөн сэдэл, сонирхлын боломжийг алдагдуулж, хүний үйл ажиллагааг ямар ч зохион байгуулалт, эмх цэгцгүй болгож хувиргах болно.

Харилцааны үйл явцад сэтгэл хөдлөлийн процесс нь сэтгэл зүйн хүчин зүйлүүд бие махбодийн шинжтэй нөлөөллөөс дутахгүйгээр үйлчлэл үзүүлж байдаг. Хандлага Харилцааны үйл явцын чухал хэсэг болох хандлага нь харилцагчдын зан байдал, оюун бодол, үг яриа, сэтгэл хөдлөл зэргээр дамжин гаднаа илэрдэг, тухайн хүн өөртөө, бусдад, нийгэмд хандах зан үйлийн шинж юм.

Өнөөг хүртэл амьдарсан амьдралын тань жаргал, зовлон, баяр, гуниг гээд энэ бүгд нь таны үзэл бодол, үг хэллэг, сэтгэл хөдлөл итгэл бишрэлийн тань нийлбэр болох хандлагын үр дүн юм. Та зан үйлээ өөрчилье гэвэл хандлагаа өөрчлөх нь чухал. Хандлагын мөн чанар нь:

- Өөртөө зөв хандах
- Бусдад хүнлэг хандах
- Нийгэмд өөриймсөг хандах нь гол зорилт юм.

Тухайн хүний харьцааны арга барил нь ертөнцийг хэрхэн тусган авч, ямар өнцөгөөр харж байгаагаас хамаардаг. Нэг нь өөдрөг үзэлтэй байхад өөр нэгэн нь гутранги үзэлтэн байж болно. Хэн нэг нь онолдох дуртай байхад өөр нэгэн нь

бүгдийг гараар хийх сонирхолтой байх гэх мэт. Өөр хоорондоо адилхан хүн байдаггүй, хүн болгоныг өөрийн гэсэн онцлогтой болгож өгдөг зүйл нь энэ юм.

Хүмүүс хоорондоо харьцаа тогтоох, түүнийгээ таслалгүй үргэлжлүүлэхэд эдгээр онцлог нь тун ч чухал ач холбогдолтой болж ирдэг. Хувь хүн бүрийн зан үйл, харилцааны давтагдашгүй өвөрмөц онцлогийг харгалзан үзэж харилцах нь харилцаа амжилттай болох бүрэлдхүүн хэсэг юм.

“Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх хөтөлбөр:

Хүмүүс хүчирхийлэл үйлдэх зан үйлээ өөрчлөхдөө эдгээр үе шатуудыг дамжин өнгөрөх ба эхний үе шатад явагдсан ахиц өөрчлөлт нь дараагийн үе шатанд шилжих нөхцлийг бүрдүүлж байдаг. Аль ч үе шатнаас эргэж буцах буюу тэвчээр алдаж болох бөгөөд энэ нь өөрчлөлтийн чухал нэгэн бүрэлдэхүүн хэсэг юм. Өөрөөр хэлбэл хүмүүс хүчирхийлэл үйлдэх зан үйлээ өөрчилж шинэ зан үйлд суралцах, шинэ чадвар дадал эзэмших гэж хичээх явцдаа оролдлого нь бүтэлгүйтэх тохиолдол гарч болно. Иймээс ч эхний буюу бодолгүй байх үе шатнаас хэвших үе шат руу шууд дамжин орох боломжгүй гэж тайлбарладаг.

1. Бодолгүй байх үе. Хүчирхийлэл үйлдэх зан үйлээ өөрчлөх бодолгүй байх буюу зан үйлээ өөрчлөх шалтгаан байхгүй гэж үзнэ. Эдгээр хүмүүс хүчирхийлэх зан үйлийн асуудлын талаар тодорхой ойлголт мэдлэггүй байх, эсвэл тухайн зан үйлийн эрсдлийн талаар мэдэж байвч, түүнийг өөр дээрээ авч үзэхээрээ эрсдлийн зэрэглэлийг бууруулж ойлгодог. Энэ шатанд байгаа хүмүүс тухайн асуудлыг нухацтайгаар авч үздэггүй учраас түүнийг өөрчлөх талаар хичээдэггүй, эсхүл өөрчлөх оролдлого хийгээд бүтэлгүйтэж амжилтгүй болж байсан байж болох тул өөрчлөлт хийж чадна гэдэгтээ итгэдэггүй, өөрчлөлт хийх тухай бодохыг ч хүсдэггүй болсон байх талтай. Бодолгүй байх үе шатанд байгаа хүмүүсийн хувьд зан үйлийг өөрчлөх хөтөлбөр үйлчилгээнд сайн дураараа ирж тусламж үйлчилгээ авах нь бараг байдаггүй бөгөөд заримдаа огт өөр зорилго, /тухайлбал, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан болон бусад ялтнуудын анхаарлыг татах/ шалтгаанаар ирж үйлчилгээнд хамрагдах тохиолдол ч гардаг. Тэдэнд хүчирхийлэл үйлдэх зан үйл, түүний үр дагаварын талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай ба тухайн зан үйлийн улмаас үүсэх эрсдлүүдийг өөр дээрээ дүгнэн үзэж эхлэхэд нь туслах үүднээс энэ шатны зөвлөгөө өгөх үйлчилгээний зорилго, үйл ажиллагаа чиглэдэг.

2. Бодож эргэцүүлэх үе. Өөрчлөлтийн эл үе шатанд байгаа хүмүүс өөрийн зан үйлд асуудал байгааг ойлгож, өөрчлөх талаар бодож эхэлдэг бөгөөд магадгүй ойрын 6 сарын дотор өөрчлөлт хийхээр төлөвлөж байдаг. Хэдийгээр тэд асуудал байгааг олж харж, ойлгож ухаарсан ч хүчирхийлэл үйлдэх зан үйлээ өөрчлөх талаар тодорхой алхам хийгээгүй буюу энэ тал дээр хараахан бэлэн биш байдаг. Тэд өөрсдийн зан үйлээ өөрчлөхийн давуу ба сул талуудыг цэгнэн үзэхийн зэрэгцээ олон зөрчил бэрхшээлтэй тулгарч байдаг. Учир нь зарим тохиолдолд тэд өөрсдийн хүчирхийлэл үйлдэх зан үйлийнхээ сул талыг олж харсан ч, түүнийг өөрчлөхийн ашиг тусыг хараахан ойлгож ухаарч чадаагүй байдаг. Тиймээс ч хүчирхийлэл үйлдэхгүйгээр бусад хүмүүстэй харилцахыг хүсэж байгаа ч, бодит хэрэг дээрээ тодорхой алхам хийдэггүй. Өөрөөр хэлбэл энэ үе шатанд байгаа хүмүүс өөрчлөлт

хийхийн чухлыг хүлээн зөвшөөрдөг ч харин өөрчлөлт хийхээр хараахан шийдвэр гаргаагүй байдаг. Энэхүү шийдвэрийг гаргахад 30-с доошгүй хоног шаардагддаг.

3. Бэлтгэл үе. Энэ үе шатанд хүн тун удахгүй буюу ойрын нэг сарын дотор өөрийн хүчирхийлэх зан үйлдээ өөрчлөлт хийж эхлэхээр хатуу шийдсэн байдаг. Тэд зан үйлээ өөрчлөхийг хүсэж байгаагаар сайтар ухаарсан байх ба өөрчлөлт хийхээр зарим нэгэн оролдлогуудыг хийж эхэлсэн байдаг. /Тухайлбал хараалын үг хэрэглэхгүй байх аргуудыг тогтмол биш ч ганц нэг удаа хэрэглэж турших гэх мэт/. Мөн тэд өөртөө хэвшүүлэхээр зорьж буй шинэ зан үйлийн талаар төдийгүй өөрчлөлт хийх өөрийн чадавх боломжийн талаар эргэцүүлэн бодно. Улмаар шинэ зан үйлд суралцах болон саад бэрхшээлийг даван гарах өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх эхний оролдлого алхмуудыг хийхийг хичээдэг. Тэдэнд эрсдэл бүхий хүчирхийлэх зан үйлээ өөрчилж эерэг харилцааны шинэ чадвар дадал эзэмшихийн давуу тал, ашиг тусыг ойлгон, тэрхүү өөрчлөлтийг хийх хүсэл эрмэлзлэл хүчтэй төрж эхэлдэг. Тиймээс энэ үе шатанд байгаа хүмүүс өөрчлөлтийн ашиг тусыг мэдэрснээр эерэг шинэ зан үйлд суралцаж хэвшүүлэхийн төлөөх өөрчлөлтийг хийхэд бэлэн болсон байдаг.

4. Үйлдэл хийх үе. Энэ үе шатанд байгаа хүмүүсийн хувьд зан үйлдээ тасралтгүй буюу наад зах нь бүтэн өдрөөс аваад цаашилбал зургаан сар хүртэлх хугацаанд төлөвлөсний дагуу өөрчлөлт хийх ба хүчирхийлэл үйлдэхгүйгээр бусадтай харилцах эерэг, шинэ дадал чадваруудыг эзэмших үйлдэл, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тухайн хүн өөрчлөлт хийхээр санаа шулуудаж, зорилгодоо хүрэхийн төлөөх тодорхой алхам бүхий үйлдлүүдийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Жишээлбэл, гэр бүлийнхэн болон ойр дотныхон, бусад ялтнууд зэрэг хүмүүстэй хүч хэрэглэхгүйгээр харилцах, уурлаж бухимдахгүйгээр өөрийгөө илэрхийлэх, бусдыг хүлээцтэй сонсох, хараалын үг хэрэглэхгүй байх зэрэг харилцааны чадваруудыг өдөр бүр тасралтгүй хийж хэрэгжүүлдэг. Энэ үеийн нэг чухал анхаарах асуудал нь янз бүрийн шалтгаан, өдөөгч хүчин зүйлсийн нөлөөгөөр тэвчээр алдаж, хүчирхийлэл бүхий эрсдэлт зан үйлээ дахин үйлдэх магадлалтай. Хэвшил болсон эрсдэлт зан үйлээ өөрчлөх үйл явц нь маш их стрессийг дагуулахын хамт хэт их чармайж хичээснээс болж ачааллаа дааж чадахгүйд хүргэж ч болно. Тиймээс эдгээр хүмүүст өөрчлөлтийг амжилттай хийж шинэ, эерэг зан үйлийг хэвшүүлэхийн тулд ихээхэн хичээл чармайлт, тэвчээр шаардлагатай гэдгийг ойлгуулах нь чухал. Нөгөөтэйгүүр өөрчлөлтөд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг багасгаж, орчны дэмжлэгийг сайжруулан, урамшуулан дэмжих замаар тухайн хүнийг тэвчээр алдаж, эргэж буцахаас сэргийлэх нь энэ шатанд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн хөтөлбөр үйлчилгээний зорилго оршино.

5. Хэвших үе. Зургаа буюу түүнээс дээш сарын хугацаагаар шинэ зан үйлийг тасралтгүй хэвшүүлнэ. Энэ шатанд байгаа хүмүүс дээр дурдсанчлан харилцааны эерэг чадвар, дадал бүхий шинэ зан үйлээ өдөр тутмын амьдралдаа идэвхтэй хэрэглэж хэвшүүлсэн байдаг. Тэд тэвчээр алдахаас сэргийлэх арга хэмжээг ч авч эхэлсэн байдаг. Зан үйл нь дадал болсон байх бөгөөд хувь хүний ахуй амьдралын нэг хэсэг болж эхэлсэн байдаг. Гэхдээ энэ үе шатанд байгаа хүмүүсийн хувьд ч тэвчээр алдаж, эргэж буцах нь сэтгэл зовоосон асуудал хэвээр байдаг. Жишээлбэл: 7, 8 сарын турш бусдыг хүндлэн зөв, сайхан харилцаатай байсан хүн гэнэт нэг өдөр

хуучин зан авир, өвчин нь сэдэрч бусдыг хүчирхийлэн, түрэмгийлэх тохиолдол амьдрал дээр гарч байдаг. Мэдээж өмнөх үе шатуудыг бодвол энэ хүртэл өөрчлөгдөж чадсан хүмүүсийн хувьд шинэ зан үйлийг дадал хэвшил болгоход харьцангуй хялбар байдаг. Тиймээс шинэ зан үйлээ өдөр тутмын амьдрал, үйл ажиллагааныхаа салшгүй хэсэг болгож тогтмол хэвшүүлэхийн тулд тодорхой хэмжээний шахалт хэрэгтэй. Үүнээс үзвэл өмнөх үе шатуудад хийгдэж байсан өдөөгч буюу сэдрээх зүйлийг хянах, дэмжих харилцааг бэхжүүлэх, урамшуулан бататгах харилцаа бүхий үйл явцууд ч цаашид үргэлжлэн явагдсаар байдаг.

Уур бухимдлаа зохицуулах зохицуулах хөтөлбөр:

Уур бухимдлаа зохицуулах хөтөлбөр нь дараах 6 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Өөрийгөө шинжихүй
2. Уурыг хүлээн зөвшөөрөх нь
3. Уур бухимдлыг зохицуулах арга зам
4. Уур бухимдлаа хэрхэн хянах вэ?
5. Уур бухимдлаа хэрхэн зохистой илэрхийлэх вэ?
6. Уур бухимдлаа зохицуулах чадвар: Өөрийгөө үнэлэхүй

Тус сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр нь бэлгийн хүчирхийлэл үйлдэж, бусдын эрх ашгийг хохироон, ял эдэлж буй хоригдогчдод чиглэгдсэн болно. Хөтөлбөрийн гол зорилго бол хоригдогчдын бэлгийн хүчирхийлэл үйлдэх зан үйлийг бууруулах, улмаар хүчингийн гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэхэд чиглэнэ. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгч нь ихэнхдээ өөртөө итгэлгүй, харилцаа холбоо тогтоох, шийдвэр гаргах, сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах чадвар сул хүмүүс байдаг бөгөөд энэ нь хүчингийн гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг болохыг судлаачид тодорхойлсон байдаг. Иймээс тус хөтөлбөрийн хүрээнд мөн тэдгээр хоригдогчдын шийдвэр гаргах, сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, харилцаа холбоо тогтоох чадварыг сайжруулна.

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх хөтөлбөр

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын практикт ихэвчлэн дараах 3 загварыг ашигладаг. Үүнд:

- Танин мэдэхүй – зан үйлийн онол нь бэлгийн зан үйлийн гажуудлыг өөрчлөх болон бэлгийн хүчирхийлэл үйлдэхтэй уялдаа холбоотой бодол санааг өөрчлөхөд чиглэгдэнэ.
- Сэтгэл зүйн боловсролын загвар нь бэлгийн хүчирхийлэл үйлдэгч өөрийн хийсэн үйлдэлдээ хариуцлага хүлээх, тухайн гэмт хэргийн хохирогчийн шаналал, зовлон, бэрхшээлийг ойлгож мэдрэхэд гол үндэс суурь нь болно.
- Фармакологийн загвар нь бэлгийн хариу үйлдлийг бууруулахад чиглэсэн эмийн бэлдмэлийг хэрэглэх арга хандлага юм. Үүнийг ашиглахын тулд сэтгэцийн эмч, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах хэрэгтэй.

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна. Үүнд:

- Бусдад хор хохирол учруулсан зан үйлдээ дүгнэлт хийж, өөрийн буруутай үйлдлийг ухамсарласан байна.
- Бэлгийн хүчирхийлэл үйлдэхэд хүргэсэн өөрийн шинж чанар, дотоод нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, өөрийгөө таньж мэднэ.
- Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлөх гадаад буюу орчны хүчин зүйлсийг тодорхойлж, түүнээс сэргийлэхэд хэрэгтэй зүйлсийг ойлгосон байна.
- Эрсдэлтэй зан үйлийг бууруулах, зохицуулах, засаж сайжруулахад хэрэгцээтэй чадваруудыг тодорхой хэмжээгээр хөгжүүлсэн байна.
- Нийгэмд буюу олон нийтийн дунд аюулгүй иргэн байхад хэрэгтэй хандлага, бодол санаа, зан үйлд суралцсан байна.
- Өөрийгөө захирч чаддаг болоход суралцсан байна.
- Бэлгийн хүчирхийлэл дахин үйлдэх эрсдэлээс сэргийлэх, зохицуулах чадвар эзэмшсэн байна.

Хоёр.Эрх зүйн сургалт:

Зан үйлд нөлөөлөх эрх зүйн сургалтын үндсэн мөн чанар нь гэмт хэрэг, зөрчил үйлдэгчидэд:

- 1.Гэр бүлийн тухай болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгаалалын тухай хууль;
- 2.Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль;
- 3.Шаардагдах бусад хуулиудаар сургалт ордог.

Эрх зүйн сургалтын агуулга нь зөвхөн хуулийг зааж, мэдүүлэх гэхээсээ илүү, тухайн хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, учирж болох сөрөг үр дагаварыг ухамсарлуулан ойлгуулахад оршдог.

Сэтгэл зүйн болон эрх зүйн сургалтыг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүний хувийн онцлог, зөрчлийн шинж болон бусад нөхцөл байдлыг харгалзан ялгамжтай байдлаар явуулбал зохистой юм. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд сургалтын төлөвлөгөө боловсруулахад тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн үйлчлүүлэгчийн онцлогт тохируулан, түүнд байгаа нөөц боломжуудыг ашиглан, зорилгодоо хүрэх хамгийн оновчтой, үр дүнтэй арга замыг сонгох нь чухал.

Зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас хүлээж буй тодорхой үр дүнгээс гадна, өөр гарч болох бусад үр дүнг тооцоолж, төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй. Төлөвлөгөө боловсруулах үе шатанд хариуцсан ажилтан нь үйлчлүүлэгчтэй хамтран дараах зүйлсийг хийнэ. Үүнд:

- Үйлчилгээний зорилгыг оновчтой, тодорхой байдлаар томъёолох;
- Зорилгодоо хүрэх арга замуудыг тодорхойлох;
- Хэн, юу хийхийг тодорхой болгох;
- Тэдгээр зүйлийг ямар хугацаанд хийж гүйцэтгэхийг тодорхойлох;
- Шаардлагатай нөөц, эх сурвалжуудыг тодорхойлох;
- Үйлчилгээг хэзээ дуусгавар болгохыг тодорхойлох;

Гэрээ байгуулах нь сайн дурын үйлчлүүлэгчийн хувьд өөрийн хүсэж буй зорилгодоо хүрэхийн тулд, харин сайн дурын бус үйлчлүүлэгчийн хувьд хэдийгээр

нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, улмаар эцсийн үр дүнд өөрт нь үр ашигтай байх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тодорхой үүрэг хариуцлага хүлээж, түүндээ эзэн болоход тустай байх болно.

Үйлчилгээний төлөвлөгөөний нэлээдгүй зүйлсийг гэрээний маягтад тусган оруулдаг. Тухайлбал, үйлчилгээний зорилго, хэн, юуг, ямар хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай, үйлчилгээний үр дүнг хэрхэн тооцох гэх мэтчилэн. Үйлчлүүлэгчтэй хийх гэрээний маягтын олон янзын загвар байдаг.

Хариуцсан ажилтан өөрийн үйлчлүүлэгчид тохирох өвөрмөц интервенцийг¹² сонгож, тохиргоо хийн, хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ үйл ажиллагаа нь үйлчилгээний зорилгоос хамааран янз бүр буюу маш өргөн хүрээтэй байна. Тухайлбал, үйлчлүүлэгчийн зан үйлийг өөрчлөх буюу сөрөг зан үйлийг бууруулах эсвэл өөрийнх нь эерэг зан үйлийг улам батжуулж, хөгжүүлэх, шинэ зан үйлийг хэвшүүлэх, уур бухимдлаа зохицуулж сурах сургалтад хамруулах, асуудлыг даван туулах чадварт сургах гэх мэтүйл ажиллагаа байж болно.

Хэрэв та мэргэжлээрээ төдийлөн туршлагажаагүй байгаа бол үүнийг туршлагатай ажилтан, сэтгэл зүйч, эсвэл мэргэжлийн зөвлөлөөр хамтран хэлэлцэж хийх нь тохиромжтой байх болно.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх үйлчилгээн дараах төрлүүдтэй байж болно.

1) Сэтгэл зүйн сургалт

- Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр, тухайлбал:
- Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх;
- Уур бухимдлаа зохицуулах;
- Харилцах ур чадвараа дээшлүүлэх;
- Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх;
- Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;
- Хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүй
- Гэр бүлийн сэтгэл зүй

2) Бясалгалын сургалт

3) Хууль, эрх зүйн сургалт

Дээрх үйлчилгээнүүдийг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

- Ганцаарчилсан;
- Бүлгийн;
- Аль, алиныг нь хослуулсан хосолмол байдлаар;

Үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн, эсхүл хослуулан хэрэглэх тохиолдол цөөнгүй байдаг. Жишээ нь, үйлчлүүлэгч ганцаарчилсан зөвлөгөө авахын зэрэгцээ гэр бүлийн болон бүлгийн үйлчилгээнд давхар хамрагдах шаардлага цөөнгүй тулгардаг. Энэ бол бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулж буй үйлчилгээний хосолмол хэлбэр юм.

¹²Интервенц гэдэг нь аливаа үйлчилгээний хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Дээрх үйлчилгээнүүд нь нийгэм, сэтгэл зүйн гэсэн 2 том шинжлэх ухаан байдаг ба энд бүгдийг нь оруулах боломжгүй юм. Иймд практик туршлагад өргөн хэрэглэгддэг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид маш өндөр үр нөлөө үр нөлөө үзүүлж байгаа хэдэн аргын талаар авч үзье.

1) Дотоод хүчийг бэхжүүлдэг уламжлалт дасгалууд

- иог
- мөргөл
- бясалгал
- амьсгалын дасгал

2) Номын засал

Номын засал гэдэг нь хүнд ном уншуулах замаар эмчилгээний нөлөө үзүүлэх арга юм. Номын засал сэтгэл засалд төрөлд багтдаг бөгөөд сэтгэл судлал, сэтгэц заслын өвөрмөц арга техниктэй хослуулах нарийн төвөгтэй арга гэж Б.В.Н.Мясищев тодорхойлсон. Эмчилгээний зорилгоор 1836 онд И.Е.Дядьковский энэ аргыг анх хэрэглэсэн. АНУ-ын Эмнэлэгийн номын сангийн нийгэмлэгээс “Номын засал гэдэг нь эмнэлэг болон сэтгэц заслын хүрээнд үйлчлүүлэгчийн хувийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор уншуулах материалыг мэргэжлийн түвшинд сонгож ашиглах явдал юм” гэж тодорхойлсон. Номыг сонгохдоо тухайн хүний унших чадварыг анхаарах ёстой. Эхлээд тухайн үйлчлүүлэгчийн эмзэг сэдвийг хөндөхгүй, богино хэмжээний сонирхолтой, сургамжит өгүүллэг гэх мэт байж болно.

- Амар хялбар өгүүлэхүйц хэмжээтэй (сонгосон номны өгүүлэхэд бэрхшээл учруулах байдлыг тооцох);
- Номын баатар шиг болох (номын баатар шиг болоход чадал хүрэх мэт сэтгэгдэл төрүүлэх);
- Номын өгүүлж буй нөхцөл байдал амьдралын нөхцөл байдалтай ихэнх тохиолдолд маш их төстэй байдаг.

Бүлгийн номын засал

Бүлгийн номын засалд унших чадвар болон уншигчийн сонирхлыг харгалзан гишүүдийг сонгон авахыг шаарддаг. Бүлгийн номын заслыг 5-8 үйлчлүүлэгчтэй гүйцэтгэх нь тохиромжтой. Бүлгийн хичээлийн үед номыг бүхэлд нь уншаад хэлэлцүүлэг эхэлдэг. Хэлэлцүүлгийн үр дүнд бүлэг дэх хүмүүсийн хоорондын харилцааны бүтэц тодорхой болдог. Хэлэлцүүлгийн үеийн ярианд бичлэг хийж, сэтгэл засалч задлан шинжилгээ хийдэг.

Номын засал нь эрэгтэй гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид нэн тохиромжтой заслын хэлбэр юм. Учир нь эрэгтэй хүн сайн уншдаг, хүнтэй харилцах, ярилцах дургүй онцлогтой холбоотой. Иймд номыг мэргэжлийн түвшинд дэс дараалалтайгаар сонгож уншуулах нь хурдан хугацаанд зан үйлд нь өөрчлөлт орох магадлал өндөр байдаг.

3) Байгалийн засал

Байгаль бол эмчилгээний нөлөө үзүүлдэг сэтгэл заслын бие даасан арга гэдгийг зүй ёсоор хүлээн зөвшөөрдөг. Ихэнх эрдэмтэд байгаль хүний сэтгэл санааны байдалд эерэгээр нөлөөлдөг гэдгийг үгүйсгэдэггүй бөгөөд сэтгэл заслын орчин

болдог гэж үздэг. Сэтгэл засалч үйлчлүүлэгчийн сэтгэц болон сэтгэл зүйн байдалд дан ганц үгээр нөлөөлөөд үр дүн нь төдийлөн гарахгүй тул өөр бусад аргуудыг хэрэглэдэг. Үүнд хөгжим, ном, байгаль хөдөлмөр гэх мэт багтдаг.

4) Ярианы засал

Боммерт ярианы засал нь тодорхой тооны хүмүүс болон сэтгэл засалч үйлчлүүлэгч хоёрын хоорондын нийгмийн харилцаа, аман ба аман бус харилцааны төлөвлөсөн, системчилсэн сонгон сайжруулсан хэлбэр юм гэж тодорхойлсон. Зорилго нь хүнд нөхцөлд байгаа үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн зөрчилдөөнийг багасгах, өөрийн өвөрмөц “Би”-гийн дүр төрхийг тодорхойлохын тулд өөрийн зовлон зүдгүүр, зан төлөвийн хүрээнд шинэ хандлагыг бий болгоход туслах явдал юм.

5) Хөгжмийн засал

Сэтгэл заслын орчин нөхцөлд хөгжим ашиглан сэтгэл засал хийх арга. Хөгжим нь хүний бие организмд эмчилгээний нөлөө үзүүлдэг бөгөөд XVII зуунд хөгжмийн засалд шинжлэх ухааны тайлбар хийх анхны оролдлого, XIX зуунд туршилтын судалгаа хийгдсэн байна. Хөгжмийн заслын нөлөөллийг 4 чиглэлд хувааж үздэг. Үүнд:

- сэтгэл заслын явц дахь сэтгэл хөдлөлийг идэвхжүүлэх;
- бие хүмүүсийн хоорондын харилцааны (харилцааны үүрэг ба хэрэгцээ) дадлыг хөгжүүлэх;
- психовегетатив (сэтгэц, оюун ухаанаас үл шалтгаалах дотоод эрхтэний мэдрэлжүүлэлт) үйл явцын нөлөөллийг зохицуулах;
- гоо зүйн хэрэгцээг дээшлүүлэх;

Хөгжмийн засал нь идэвхтэй ба жорын гэсэн 2 үндсэн хэлбэртэй. Идэвхтэй хөгжмийн засал гэдэг нь хөгжмийн зэмсэг тоглож сурах буюу эзэмших, хөгжим зохиох, уран сэтгэмжлэх, бүтээх зэрэг хөгжмийн идэвхтэй үйл ажиллагаанд орох заслын чиглэл юм. Жорын гэдэг нь зорилготойгоор хөгжмийг ухамсарлан ойлгох үйл явц юм. Энэ нь 3 хэлбэртэй.

- харилцааны (итгэлцэл, харилцан ойлголцол бий болгож, хамтдаа хөгжим сонсох хэлбэр);
- хариу үйлдлийн (катарсист хүрэхэд чиглэсэн хэлбэр, өөрөөр хэлбэл, сэтгэл хөдлөлийн тэнцвэрт байдалд оруулах);
- зохицуулалтын (сэтгэл санааны хямралтай байдлыг багасгах хэлбэр);

Бүлгийн хөгжмийн засал

Практикт жорын заслыг ихээхэн хэрэглэдэг. Бүлэг дэх үйлчлүүлэгчид хөгжмийн бүтээлийг сонсох явцдаа уран сэтгэмж, харилцаа холбоо, өөрийн бэрхшээлтэй хүнд асуудал, үзэл бодол зэрэгтээ задлан шинжилгээ хийдэг.

Нэг удаагийн хичээлийн үед хөгжмийн гурван бүтээлийг сонсох нь тохиромжтой байдаг. Хөгжмийн бүтээлийг бүлгийн гишүүдийн сэтгэл хөдлөлийн ачаалал, сэтгэл санааны өөрчлөлт, хөдөлгөөн, хурд зэргийн ялгаатай байдлыг харгалзан сонгодог.

Эхний бүтээл нь хөгжмийн бүх хичээлийн ач холбогдлыг мэдрүүлэх, үйлчлүүлэгч сэтгэл санаагаа илэрхийлэх, харилцааг бий болгох, цаашид сонсох бэлтгэлийг хангах зэрэг нөхцөлийг бүрдүүлэхүйц байх ёстой.

Хоёрдугаар бүтээл нь шилжилт, дүрийн тоглолт гэх мэтийг агуулсан, хамгийн их ачаалалтай бүтээл байна. Энэхүү бүтээлийн үүрэг нь үйлчлүүлэгч өөрийн амьдралаас харилцаа холбоо, бодол санаа, төсөөллөө олж харахад тусалж, сэтгэл хөдлөлөө эрчимжүүлэх сэдлийг бий болгоход оршино.

Дээрх сэтгэц заслын аргууд нь хүнийг хамгийн хурдан хугацаанд харилцааны эерэг, шинэ дадал чадвартай болгодог. Хуучин зан үйлийг сэдрээх зүйлсийг оновчтой тодорхойлж, тэдгээрийг хяналтандаа байлгахын сацуу эрсдэл багатай эерэг дадал чадваруудад суралцсанаар өөрчлөлтийг амжилттай хийх үндэс бүрдэнэ. Бэлтгэл үе шатнаас эхлээд үйлдэл хийх, хэвших үе шатны аль алинд нь хүчирхийлэх зан үйлийг дахин сэдрээхээс сэргийлж, орлох шинэ дадал чадваруудыг эзэмшихэд нь үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлэх нь сэтгэл зүйн хөтөлбөр үйлчилгээний нэн чухал зорилт оршино. Үүнийг зан үйлийг өөрчлөх хосолмол онолын загварт (орлох зүйлийг сонгох) үйл явц гэж тодорхойлдог.

б) Бясалгалын сургалт

Бясалгалын сургалт нь өөрийгөө удирдан жолоодож тайвшруулах, амьдралын эерэг хандлага, зөв дадал, сэтгэлгээ, чадвар суулгахад оршино. Бясалгалын сургалтыг зөвхөн мэргэжлийн багш хөтлөн явуулах шаардлагатай. Зан үйл, хандлагыг өөрчлөх зорилгоор бясалгалын сургалтыг явуулахдаа сэтгэл заслын сургалттай хосолж явуулах нь өндөр үр дүнтэй. Тухайлбал, хорих 421 дүгээр ангид явуулсан бясалгалын сургалтын тайланд дараах байдлаар үр дүнг тодорхойлсон байна.

“Бясалгал хийсэн хүмүүсийн 90 хувь нь уур бухимдал зохицуулах, эерэг бодол төлөвших, чадваржих зэрэг нөлөөлөл үзүүлж байгаа нь ажиглалт, тандалт болон сэтгэл зүйн проектив аргаар нотлогдсон. Мөн сургалтад хамрагдсан хүмүүсийн стресс түгшүүр буурч, биеийн эрүүл мэнд сайжрах, өөрийгөө үнэлэх үнэлэмж нэмэгдсэн зэрэг ач холбогдолтой сургалт болсон.

Үйлчилгээг үзүүлэх явцад мониторингийг хэд хэдэн удаа хийж болох бөгөөд энэ нь үйлчилгээг өөрчлөх шаардлагатай эсэх, эсвэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох ба эцсийн үнэлгээ нь үйлчилгээний үр дүнг тооцохоос гадна, дараагийн удаа ижил төстэй асуудалтай өөр үйлчлүүлэгчид тус үйлчилгээг үзүүлэхэд юуг анхаарах, цаашид хэрхэн сайжруулах зэргийг тодорхойлох ач холбогдолтой. Ихэнх тохиолдолд үйлчилгээний ерөнхий хугацаанаас хамааран, үйлчилгээг тогтвортой үзүүлж эхэлснээс хойш 1-2 долоо хоногийн дараа эхний мониторинг хийх боломжтой.

Мониторинг хийхэд хэрэглэдэг ерөнхий аргуудын зэрэгцээ үзүүлж буй үйлчилгээтэй уялдуулан өвөрмөц аргуудыг ашиглаж болно. Тухайлбал, үйлчлүүлэгчийн харилцааны ур чадварыг сайжруулах интервенцийг хэрэгжүүлсэн бол тухайн үйлчлүүлэгч бусадтай хэрхэн харилцаж байгааг бодит нөхцөлд ажиглаж, тэмдэглэл хөтлөх, харилцааны ур чадвараа хэрхэн ашиглаж, дадал хэвшил болгож

байгаа талаар асуулга бөглүүлж, өөрийн үнэлгээ хийлгэх гэх мэт аргуудыг хэрэглэж болно.

Үйлчилгээг үнэлэхэд тоон, чанарын объектив, субъектив аргууд, стандартчилагдсан сорил, өөрийн үнэлгээ, эргэцүүлэл гэх мэт олон төрлийн аргыг ашиглаж болно. Тухайлбал, анхны уулзалт, зөвлөгөөн дээр хэрэглэж байсан зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг тодорхойлох асуулт болон харилцааны чадвар тодорхойлох бусад сорилыг ашиглан үнэлгээ хийх, үйлчилгээний үр дүнгийн талаар ярилцаж, санаа бодлыг солилцож болно.

Үйлчилгээний үр дүнг тодорхойлсны дараа үйлчилгээг төгсгөнө. Үйлчилгээг төгсгөх талаар эртнээс бэлтгэлтэй байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, үйлчилгээний явцад үйлчилгээ тодорхой хугацаагаар үргэлжлэх бөгөөд үйлчилгээ дуусахад хэр хугацаа үлдэж байгааг сануулж байх нь зүйтэй.

Үйлчилгээг төгсгөх уулзалтын хөтөлбөртөө үйлчилгээний үр дүн, үйлчлүүлэгчид гарсан ахиц дэвшлийн талаар үйлчлүүлэгчтэйгээ ярилцахын зэрэгцээ харилцан бие биедээ талархлын үг хэлэх, дурсгалын зүйл өгөх зэрэг зүйлсийг оруулж болно. Тухайлбал, хичээл зүтгэл, өөрийн цаг, завьг зориулан эрсдэлт зан үйлээ өөрчлөхийн тулд сургалт, үйлчилгээнд хамрагдсанд нь хүн бүрт талархал илэрхийлнэ. Түүнчлэн өөртөө төдийгүй, гэр бүл, найз нөхдөдөө тустай сайн шийдвэр гаргасан явдал нь эерэг зан үйлийг хэвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байсныг дурдана.

Хамгийн чухал нь хэвшүүлж дадсан, хийж бүтээсэн бүхнээ өдөр тутмынхаа амьдралд тогтмол хэрэгжүүлж байх нь эрүүл саруул, сэтгэл хангалуун, аз жаргалтай ажиллаж, амьдарч, бусдын хайр хүндлэлээр дүүрэн явахад тань чухал түлхэц болно гэдгийг зөвлөж болох юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад зан үйлд нөлөөлөх сургалтыг дараах 3 хэлбэрээр явуулж байна. Үүнд:

Нэг. Шүүхийн шийдвэрээр зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах

Зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд зан үйлд нөлөөлөх сургалтыг аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс хариуцан зохион байгуулна. Хорих ял эдлүүлэх албаны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн ажил хариуцсан нэгж нь зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулах талаар аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны Албадлагын арга хэмжээний хэрэгжилт хариуцсан нэгж нь хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг тус тус гүйцэтгэнэ.

Сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу зөвшөөрөл бүхий төрийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бол тухайн байгууллагатай шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга гэрээ байгуулж, хамтран ажиллана.

Зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга баталсан хөтөлбөрийн хүрээнд, батлагдсан төлөвлөгөөний дагуу хорих анги бүхий шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, тус орон тоо батлагдаагүй байгууллагад удирдлагын шийдвэрээр тухайн чиг үүргийг хариуцан гүйцэтгэх алба хаагч, эсхүл төрийн болон төрийн бус байгууллагын сургалтын багш явуулна.

Хорих ял дээр нэмж зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч шүүхээс шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсыг хүлээн авсан даруйд ял эдэлж байгаа хорих ангид тухайн хоригдолд сургалт явуулах хугацаа, хуваарь бүхий мэдэгдлийг хүргүүлж, хяналт тавьж ажиллана.

Шийдвэр гүйцэтгэгч нь зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд сургалтад хамрагдах хугацаа, хуваарь бүхий мэдэгдлийг гардуулж, сургалтын агуулга, хөтөлбөрийг танилцуулан тэмдэглэл хөтөлнө.

Оролцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн шинж, хяналт тогтоосон хугацаанаас хамаарч сургалтыг ялгамжтай байдлаар зохион байгуулж болно. Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь сургалтын орчин бүрдүүлэх, суралцагчийг сургалтад бүрэн хамруулах, сургалтын талаар нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, тайлан, мэдээ гаргах үүргийг хүлээх ба сургалтын талаар бусад байгууллагатай харилцаж, хамтран ажиллах эрхтэй.

Зан үйлд нөлөөлөх сургалт нь дараах төрөлтэй байна:

1. сэтгэл зүйн сургалт
2. эрх зүйн сургалт

Сургалтыг танхимийн болон зайны хэлбэрээр зохион байгуулж, суралцагчдыг бүлгээр болон ганцаарчилсан хэлбэрээр сургалтад хамруулж болно. Сургалтын 8 цагийг 1 багц цагт тооцох ба суралцагч улиралд 1-ээс доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байна. Сургалтын 1 цаг нь 45 минут байна.

Суралцагч нь дараах үүрэг хүлээнэ:

1. сургалтын журмыг дагаж мөрдөх;
2. сургалтын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, сургалтад бүрэн хамрагдах;
3. сургалтын ажилтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
4. сургалтын хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах;
5. сургалтаар олсон мэдлэг, үр дүнг шалгуулах.

Оролцогч нь дараах эрх эдэлнэ:

1. сургалтын хугацаа, ач холбогдлын талаар мэдээлэл авах;
2. сургалттай холбоотой ном, сэтгүүлийг авч ашиглах;
3. гадаадын иргэн, харааны болон сонсголын бэрхшээлтэй оролцогчийн хүсэлтээр хэлмэрч, орчуулагчийг өөрийнх нь зардлаар оролцуулах.

Сургалтын ажилтан нь дараах эрхийг эдэлнэ:

- сургалтад оролцогчдод хууль ёсны шаардлага тавих;

- сургалтад хамрагдаж буй оролцогчийг үнэлж, дүгнэх;
- аюулгүй байдлаа хангуулах.

Сургалтын ажилтан нь дараах үүрэг хүлээнэ:

- сургалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;
- суралцагчийн сургалтад хамрагдсан талаарх баримт, сургалт явуулсан тухай тайланг тогтоосон хугацаанд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;
- албаны болон оролцогчийн хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байх;
- оролцогчтой хувийн харилцаа тогтоохгүй байх.

Эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нь дараах эрхийг эдэлнэ:

- суралцагчийн сургалтад хамрагдаж буй байдлыг шалгах;
- суралцагчид хууль ёсны шаардлага тавих.

Эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нь дараах үүрэг хүлээнэ:

- зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн талаар бүртгэл хөтлөх;
- оролцогчдын сургалтад хамрагдаж байгаа эсэхэд хяналт тавих;
- сургалт явагдах газар, хугацааны талаар оролцогчид урьдчилан мэдэгдэх;
- сургалтын ажилтанд суралцагчийн талаар холбогдох мэдээллийг тухай бүр гаргаж өгөх;
- суралцагч үүргээ биелүүлээгүй бол холбогдох арга хэмжээг авах

Шийдвэр гүйцэтгэгч нь сургалт явуулах газар, хугацааны талаар суралцагчид урьдчилан мэдэгдэж, тэмдэглэл үйлдэн, хяналтын хувийн хэрэгт хавсаргах бөгөөд суралцагчийн талаарх судалгаа, холбогдох мэдээллийг сургалтын ажилтанд тухай бүр гаргаж өгнө. Сургалтын ажилтан нь суралцагчдын ирцийг бүртгэж, сургалтын дэвтэрт хичээлийн цаг, сэдвийн талаар тэмдэглэж, баталгаажуулна. Сургалтын ажилтан нь оролцогч бүрийн сургалтад хамрагдсан байдлын талаар баримт үйлдэж, тухайн сургалт явагдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид өгнө. Сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа тохиолдолд энэ баримтыг шийдвэр гүйцэтгэгч үйлдэнэ. Шийдвэр гүйцэтгэгч нь ирүүлсэн баримтыг хянаж, хяналтын хувийн хэрэгт хавсаргах ба суралцагчийн заасан хугацаагаар сургалтад хамрагдсан эсэхийг улирал бүр тооцож, тэмдэглэл үйлдэнэ.

Шийдвэр гүйцэтгэгч нь суралцагчийн сургалтад хамрагдаж буй байдлыг төлөвлөгөөт болон гэнэтийн, эсхүл сургалтын ажилтнаас мэдээлэл авч биечлэн шалгаж, энэ талаар баримтжуулна. Шийдвэр гүйцэтгэгч нь заасан арга хэмжээг хэрэгжүүлэх явцад зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд зохих журмын дагуу сургалтад хамрагдаагүй, эсхүл сургалтын журмыг зөрчсөн тохиолдолд түүнээс үүдэн гарах үр дагавар, хариуцлагын талаар танилцуулж, гарын үсэг зуруулна.

Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан хугацаа, хуваарийн дагуу зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдаагүй бол шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.9 дэх хэсэгт заасны дагуу шийдвэрлүүлнэ. Зан үйлд нөлөөлөх сургалтад заасан хугацаа, хуваарийн дагуу хамрагдсан суралцагчийн шүүхээс тогтоосон сургалтад хамрагдах хугацаа дуусмагц Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 193 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Сургалтад хамрагдах болон хамрагдсан оролцогчийн талаарх нэгдсэн бүртгэлийг орон нутгийн хэмжээнд тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, улсын хэмжээнд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө.

Аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь сургалт явуулсан талаарх тайланг сар бүрийн 20-ний өдрөөр тасалбар болгон 23-ны өдрийн дотор Хорих ял эдлүүлэх албаны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн ажил хариуцсан нэгжид хүргүүлнэ.

Хорих ял эдлүүлэх албаны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн ажил хариуцсан нэгж нь тайланг сар бүр нэгтгэн үр дүнг тооцон, Хорих ял эдлүүлэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны даргад тус тус танилцуулна.

Хоёр. Хорих ял эдэлж буй хоригдол, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолоор биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдэд зохион байгуулах зан үйлд нөлөөлөх сургалт

Энэ сургалтын зорилго нь:

1. Зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд холбогдох хууль, эрх зүйн ерөнхий ойлголт, мэдлэгийг олгож үйлдсэн гэмт хэрэгтээ дүгнэлт хийх чадвар, хуулийг хүндэтгэн, сахин биелүүлэх ухамсрыг дээшлүүлэх;

2. Зан үйлд нөлөөлөх сургалт зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээд зан үйлээ өөрчлөх сэдлийг төрүүлэх, өөрчлөхөд нь дэмжлэг үзүүлэх, үйлдсэн гэмтр хэргийн хор уршгийг ойлгуулахад чиглэгдсэн байна.

Зан үйлд нөлөөлөх сургалтыг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

- *Танхимын сургалт*: Танхимын сургалтыг лекц, семинар, дасгал ажил, хэлэлцүүлэг, харилцан ярилцах хэлбэрээр хүртээмжтэй байдлаар зохион явуулна.

- *Зайны сургалт*: Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хорио цээрийн дэглэм тогтоосон зэрэг шаардлагатай тохиолдолд олон нийтийн сүлжээ, зарим программ хангамжийн тусламжтайгаар зайны сургалт зохион байгуулж болно.

Заах арга зүй

Зан үйлд нөлөөлөх нэгж хичээлийн арга зүйд дараах шаардлага тавигдана. Үүнд:

Тухайн хичээлийн зорилгыг хангахуйц арга, хэлбэрийг сонгох ба хичээлийн агуулгад тохирсон;

Оролцогчдыг хичээлд жигд, идэвхтэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлсэн;

Хичээлийн арга зүй нь амьдралд нийцсэн байх ба хичээлийн төрлөөс хамааран тунхагласан хэлбэрээс аль болохоор татгалзсан байна.

Сургалтад оролцогчдын сэтгэл зүйд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц сэдэлжүүлэх сургалтын арга, аргачлалыг туршихгүй байх.

Зан үйлд нөлөөлөх хичээл явуулах арга зүйг ашиглана: Үүнд:

- Лекцийн арга;
- Семинарын арга;
- Сэргээн санах, сэргээн бататгах арга байна.
- Лекцийн арга:

Сургалтад хамрагдах оролцогчдын мэдлэг, боловсрол, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг харгалзан сургалтын материалыг товч, тодорхой, ойлгомжтой, практикт суурилсан байхаар бэлтгэж, лекцийн аргаар заах нь илүү үр дүнтэй.

Лекцийн аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

Хүн анхаарлаа дунджаар 15-20 минут төвлөрүүлдэг тул лекц урт хугацаагаар үргэлжлүүлэх нь зохимжгүй бөгөөд боломжтой нөхцөлд сургалтын үр ашгийг дээшлүүлэх үүднээс хэлэлцүүлгийн арга болон багаар ажиллах, мөн бусад аргыг нэмж ашиглах нь зүйтэй.

- Семинарын арга:

Семинарын арга нь уншиж, сонссон мэдээлэлдээ тулгуурлан мэдлэг бүтээх, өргөжүүлэх, илүү нарийвчлан судалж, олон дахин давтсаны үндсэнд бий болох чадвар, дадлыг бий болгодог сурах үйлийн нэгдэл юм. Семинар нь оролцогчдын идэвхтэй оролцоотойгоор тодорхой сэдвээр явуулдаг хичээлийн онцгой хэлбэр.

Семинарын аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

Тухайн хичээлтэй холбогдох сургалтын кино болон дүрс бичлэг үзүүлэх, багаар ажиллуулах, сэтгэл зүйн сорилд хамруулах зэргээр семинарыг зохион байгуулна.

- Сэргээн санах, сэргээн бататгах арга:

Сэргээн бататгах хичээл:

Зан үйлд нөлөөлөх 6 цагийн лекц, семинарын хичээл зохион байгуулсны дараа сэргээн санах хичээлийг заана. Сэргээн санах хичээлээр оролцогчдын зан үйлд нөлөөлөх хичээлүүдийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах чиглэлээр оролцогчидтой харилцан ярилцах, туршлагаасаа хуваалцах, багаар ажиллах мөн асуумжийн болон хэлэлцүүлгийн аргыг ашиглан шалгаж болно.

Сэргээн санах хичээл:

Зан үйлд нөлөөлөх сургалтыг нэг улирал зохион байгуулсны дараа сэргээн санах хичээлийг багцалж заана. Сэргээх бататгах хичээл нь зан үйлд нөлөөлөх сургалт орсноос хойш шинээр ирсэн оролцогчид болон өмнө зохион байгуулсан хичээлээр олгох мэдлэг, чадварыг хараахан эзэмшээгүй оролцогчдод суурь ерөнхий мэдлэгийг олгож, бататгахад чиглэгдсэн байна.

Сургалтын ажилтан нь зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулахад дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хичээлийн хөтөлбөр зорилгод чиглэгдсэн чанартай үр дүнтэй, сургалт зохион байгуулах;

- Сургалтаар олгох мэдээллийг нийгэм, соёлын онцлогт уялдуулан жишээ баримт дээр тайлбарлаж хүргэх;

- Сургалтын явцад хүн бүрийг оролцуулан сургалтын идэвхтэй арга барилыг дэмжихэд анхаарах;

- Сургалтаар олж авсан мэдлэгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар харилцан ярилцаж байх;

- Сургалтад хамрагдаж буй оролцогчдын хандлагыг мэдэрч, нээлттэй, чөлөөтэй харилцааг эрхэмлэх;

- Оролцогч төвтэй аргыг сонгож, багийн ажиллагааг ашиглах;

- Аюулгүй нээлттэй орчинг бүрдүүлж, оролцогчдын өөрийгөө илэрхийлэх болон бүтээлч байдлыг дэмжих;

- Оролцогчдын тулгамдсан асуудал болон үнэт зүйлсийг хөндөж ярилцахад анхаарах /үйлдсэн гэмт хэрэг, гэр бүл, үр хүүхэд, г/м/.

Зан зан үйлд нөлөөлөх сургалтад дараах хэрэглэгдэхүүнийг ашиглана. Үүнд:

- Тухайн хичээлийг судлах гарын авлага, унших материалын эмхтгэл;

- Лекц болон семинарын хичээлийн хураангуй бичвэр;

- Үзүүлэх болон тараах материал, кейс, түүн дээр ажиллах удирдамж;

- Компьютер, проектор болон бусад шаардлагатай эд зүйлс.

Гурав. Баривчлагдсан этгээдүүдийн дунд явуулах зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үйлдсэн зөрчлийн шинж, хувийн онцлогыг нь харгалзан явуулна.

ХОЁР. ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

2.1.Зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн шинжилгээ

Зан үйлээ засах албадан сургалтыг явуулах эрх зүйн үндэслэл нь дараах хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд зохицуулагдаж байна.Үүнд:

Нэг. Зөрчлийн тухай хууль /2017 оны 05дугаар сарын 11-ны өдөр батлагдсан/

Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйл.Албадан сургалт

1.Энэ хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

2.Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

3.Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна.

4.Албадан сургалттай холбоотой харилцааг хуулиар зохицуулна.

Хоёр. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан/

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйл. Зан үйлд нөлөөлөх сургалт

44.1.Гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь албадан болон сайн дурын хэлбэртэй байна.

44.2.Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага хэрэгжүүлж болно.

44.3.Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн, нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

44.4.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна.

44.5.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Гурав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 оны 06 дугаар сарын 09-ны өдөр батлагдсан/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зан үйлд нөлөөлөх сургалтыг дараах хэлбэрээр явуулахаар заасан.Үүнд:

Хүснэгт 11. ШШГТХ-д зан үйлд нөлөөлөх албадан сургалтын талаар туссан байдал

Хуулийн зүйл, заалт	Агуулга
189 дүгээр зүйл.Үүрэг хүлээлгэх, эрх	189.1.Шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс

<p>хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх</p>	<p>хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх хугацаа, хуваарийг нарийвчлан тогтоож, энэ хуулийн Арван есдүгээр бүлэгт заасан журмын дагуу биелэлтэд нь хяналт тавина.</p> <p>189.2.Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүнд шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 189.1-д зааснаас гадна зан үйлд нөлөөлөх сургалтын агуулга, хөтөлбөрийг танилцуулна.</p> <p>189.11.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах мэргэжлийн нэгж, сургалтын хөтөлбөртэй байна.</p> <p>189.12.Сургалт явуулах журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.</p> <p>189.13.Албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг зөвшөөрөл бүхий төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.</p>
<p>222 дугаар зүйл.Хорих анги дахь албадан сургалт</p>	<p>222.1.Хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна.</p>

Дөрөв. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/73 тоот тушаалийн хавсралтаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”, “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”

Дээрх журамд зааснаар баривчлах байранд дараах хэлбэрээр зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж байна.

Хүснэгт 12.Зан үйлд нөлөөлөх сургалтын үйл ажиллагааны харьцуулалт

д/д	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга зам
Нэг. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам:		
1.	Журмын зохицуулах харилцаа:	Энэхүү журмаар хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд албадан сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
2.	Албадан сургалтын зорилго, чиглэл:	Албадан сургалт нь шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх, гэмт хэрэг, зөрчил давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг ойлгуулахад чиглэсэн байна.
3.	Албадан сургалтын зохион байгуулалт:	Нийслэлд захиргааны журмаар шийтгэл хүлээсэн этгээдэд Баривчлах төв, орон нутагт захиргааны журмаар шийтгэл хүлээсэн этгээдэд Цагдаагийн байгууллага тус тус зохион байгуулна. Сургалт хариуцсан ажилтан, багш шийтгэл хүлээсэн этгээдийн зөрчлийн шинж байдлаас хамаарч сургалтын төлөвлөгөөг боловсруулах бөгөөд Баривчлах төв, Цагдаагийн байгууллагын нэгжийн дарга баталж, хяналт тавина.

4.	Албадан сургалтын төрөл, хугацаа:	<p>Албадан сургалт нь дараах төрөлтэй байна:</p> <ol style="list-style-type: none"> 1.ганцаарчилсан; 2.бүлгийн; 3.бусад. <p>Албадан сургалтын 1 цагийг 60 минутаар тооцох бөгөөд үргэлжлэх хугацаа нь өдөрт 4 цагаас дээшгүй, долоо хоногт 16 цагаас доошгүй байна.</p>
5.	Албадан сургалтад тавигдах шаардлага	<p>Албадан сургалт дараах шаардлагыг хангасан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1.ганцаарчилсан болон бүлгийн сургалт явуулах танхимтай байх; 2.оролцогчдыг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байх; 3.бясалгалын өрөөтэй байна. <p>Оролцогчийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлөөс хамаарч албадан сургалтыг ялгамжтай байдлаар зохион байгуулна.</p>
6.	Албадан сургалтад хамрагдах оролцогчийн эрх, үүрэг	<p>Албадан сургалтад хамрагдах оролцогч дараах эрх эдэлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1.сургалтын үргэлжлэх хугацаа, ач холбогдлын талаар мэдээлэл авах; 2.сургалттай холбоотой ном, сэтгүүлийг авч ашиглах; 3.гадаадын иргэн, харааны болон сонсголын бэрхшээлтэй этгээдийн хүсэлтээр хэлмэрч, орчуулагчийг оролцуулах; <p>Албадан сургалтад хамрагдах оролцогч дараах үүрэг хүлээнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1.албадан сургалтын журмыг дагаж мөрдөх; 2.албадан сургалтын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, сургалтад бүрэн хамрагдах; 3.сургалтын ажилтан, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх 4.сургалтын хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах. 5.оролцогч дахин гэмт хэрэг, зөрчил гаргавал түүнээс үүдэн гарах үр дагавар, хор уршгийн талаар ойлголт эзэмшүүлсэн байх.
7.	Сургалтын ажилтны эрх, үүрэг	<p>Сургалтын ажилтан нь дараах эрхийг эдэлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1.сургалтад оролцогчдод хууль ёсны шаардлага тавих; 2.албадан сургалтад хамрагдаж буй этгээдийг үнэлж, дүгнэх; 3.аюулгүй байдлаа хангуулах. <p>Сургалтын ажилтан нь дараах үүрэг хүлээнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1.сургалтыг хөтөлбөрийн хүрээнд батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулах; 2.албадан сургалтад хамрагдсан оролцогчийн үнэлгээ, сургалт явуулсан тухай тайланг хорих анги, баривчлах төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийн даргад тус тус хүргүүлнэ; 3.албаны болон оролцогчийн хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байх; 4.оролцогчтой хувийн харилцаа тогтоохгүй байх; 5.албадан сургалт дууссаны дараа оролцогчоос сургалтын талаарх санал авах;

8.	Байгууллагын эрх, үүрэг	Эрх бүхий байгууллага нь дараах эрх, үүрэг хүлээнэ: 1.сургалтын орчин бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах; 2.оролцогчдыг албадан сургалтад бүрэн хамруулах; 3.оролцогч үүргээ биелүүлээгүй бол холбогдох арга хэмжээг авах; 4.сургалтын талаар нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, сургалтын тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ; 5.сургалтын талаар гадаад, дотоод байгууллагатай харилцах
9.	Албадан сургалтад хамруулах	Эрх бүхий байгууллагын ажилтан /нийгмийн ажилтан, сэтгэл зүйч сургалтын ажилтан/ албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээдийг 24 цагийн дотор бүртгэлд хамруулж, түүнд сургалтад хамрагдах талаар танилцуулж, баталгаажуулна. Сургалтын ажилтан албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээдийн сургалтад хамрагдаж буй байдал, түүний оролцоо, ирцийн талаар тэмдэглэл үйлдэнэ. Албадан сургалтыг шүүхээс оногдуулсан шийтгэл, ялын хугацаанд багтаан явуулна.Албадан сургалтад хамрагдах оролцогчийн талаарх бүртгэлийг нийслэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, Баривчлах төв, аймаг, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн Цагдаагийн байгууллага хариуцан хөтөлнө.
10.	Албадан сургалтад хамруулж дууссанд тооцох	Сургалтын ажилтан дараах үндэслэлээр албадан сургалтад хамруулж дууссанд тооцно: 1.шүүхээс тогтоосон цагийн албадан сургалтад хамрагдсан; 2.албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээд нас барсан, 3.гэмт хэрэг үйлдэж, шүүхийн шийтгэх тогтоол гарсан;
11.	Хүлээлгэх хариуцлага	Албадан сургалтыг хэрэгжүүлж буй алба хаагч энэхүү журмыг зөрчсөн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. Албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээд албан тушаалтны хууль ёсны шаардлага, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд /Захиргааны харицлагын тухай хууль/ заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. Сургалт явуулах байгууллага, албан тушаалтан гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцална.
Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр:		
1.	Хөтөлбөрийн үндэслэл	Захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд албадан сургалт явуулах, эрхийг нь хязгаарласан орчинд сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэх болно.
2.	Хэрэгцээ, шаардлага	Захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйл, сэтгэл зүйн чиг хандлагад нөлөөлөх,

		дахин хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагатай, ухамсарт иргэн болж төлөвшүүлэх, хүмүүжүүлэхийн тулд зан үйлд нөлөөлөх хөтөлбөр боловсруулж, сургалт явуулах шаардлагатай.
3.	Зорилго	Захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдал, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тайвшруулах чадвартай, амьдралын эерэг хандлага, зөв дадал, бодол санаатай иргэн болгон төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
4.	Удирдлага, зохион байгуулалт	Хөтөлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа нэгжүүд хариуцан зохион байгуулна.Сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж болох ба дээрх байгууллагууд нь хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг сургах нөхцөлөөр ханган, тэдэнд дэмжлэг үзүүлж, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтад идэвхтэй оролцуулах үүргийг тус тус гүйцэтгэнэ.
5.	Сургалтын хөтөлбөрийн зорилт	Хөтөлбөрийн зорилгыг хангах ажлын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. 1.оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах; 2.шүүхээс албадан сургалтад хамруулахаар заасан хугацааг харгалзан сургалтыг явуулах; 3.албадан сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх; 4.сургалт явуулах алба хаагчдыг мэргэшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтад тус тус тогтмол хамруулах; 6.оролцогчид сэтгэл зүйн болон амьдрах ухааны боловсрол олгон зөв бодол санаа, өөрийгөө хөгжүүлэх чадвартай, эерэг сэтгэлгээтэй болгох; 7.сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, амьдралын эрүүл хэв маяг, хэм хэмжээг төлөвшүүлэх; 8.сургалтын явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах.
6.	Сургалтын алсын хараа	Сургалтын алсын хараа нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц байна. Үүнд: 1.сургалтын үйл ажиллагаа бодит үр дүнтэй байх; 2.сургалтыг явуулах алба хаагч нь мэдлэг чадвартай, мэргэшсэн байх; 3.алба хаагчийн мэдлэгийг ур чадвар болгон хувиргах замаар байгууллагын ажлыг тодорхой үр дүнд хүргэх.

		4.Сургалтад хамрагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх замаар гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх.
7.	Сургалтын хэлбэр, хэрэглэгдэхүүн	Сургалтын хэлбэр: 1.ганцаарчилсан сургалт; 2.бүлгийн сургалт; 3.хосолсон сургалт гэсэн хэлбэртэй байна. Сургалтыг дараах хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийг ашиглан зохион явуулна: 1.компьютер; 2.проектор; 3.ном, гарын авлага, бусад материал; 4.хөгжим, дүрс бичлэг; Бясалгалын сургалтын өрөө, байрыг эрүүл ахуйн болон бусад шаардлага хангахаар тохижуулах.
8.	Сургалтын төрөл	Зан үйлд нөлөөлөх сургалт нь дараах төрлүүдтэй байж болно: 1.Сэтгэл зүйн сургалт: а.архинд донтолт, болон түүний хор уршгийн талаар; б.хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах; в.уур бухимдлыг хэрхэн зохицуулах, стрессийг даван туулах; г.харилцах ур чадвараа дээшлүүлэх; д.бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх; е.өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх; ё.хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүйн асуудал, сөрөг үр дагавар; ж.гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх. 2.Эрх зүйн сургалтыг Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор явуулна. 3.Бясалгалын сургалтыг эрх бүхий байгууллагын даргын тушаалаар баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, явуулна. 4.Тухайн оролцогчийн зан үйлийн өөрчлөлтөд тохирсон сэтгэл зүйн сургалтыг эрх зүйн сургалттай хослуулан явуулна. Оролцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжийг харгалзан тэдний сэтгэл зүйн онцлогт тохирсон хэд хэдэн сургалтыг хослуулан явуулна. Сургалтыг хослуулан явуулахдаа хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж болно.
9.	Хөтөлбөрт тусгагдсан сургалтын хугацаа	Баривчлагдсан оролцогчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрт тусгагдсан сургалтыг шүүхээс тогтоосон албадан сургалтын цагтай уялдуулан харилцан адилгүй тогтоож болно.
10.	Сургалт тус бүрийн үргэлжлэх хугацаа	Сэтгэл зүйн сургалт-16-41 Эрх зүйн сургалт-5-10

	хичээлийн цаг /60 минут/	Бясалгалын сургалт-2-5 Сургалтын нийт цаг-23-56 цаг Нэг удаагийн ганцаарчилсан болон бүлгийн сургалтын үргэлжлэх дундаж хугацаа 45 минутаас ихгүй байна. Харин шаардлагатай тохиолдолд бүлгийн сургалтыг 90 минутаас ихгүй байхаар явуулна.
11.	Сургалтын санхүүжилт	Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. 1.улсын төсөв; 2.төрийн болон төрийн бус байгууллагын санхүүжилт; 3.байгууллагын дотоод орлого.
12.	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	Хөтөлбөрийн үр дүнг тооцохдоо зан үйлийг өөрчлөх хосолмол-онолын загварыг ашиглан зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг оновчтой тодорхойлж, хөтөлбөрийн эхэн болон төгсгөлд үнэлсэн үнэлгээг харьцуулан гаргана. Зан үйл өөрчлөгдөх дараах 5 үе шатыг харгалзан үзнэ. 1.бодолгүй байх үе; 2.бодож эргэцүүлэх үе; 3.бэлтгэл үе; 4.үйлдэл хийх үе; 5.хэвших үе. Оролцогчийн зан үйлд илрэн гарах үр дүн: 1.бусдад хор хохирол учруулсан зан үйлдээ дүгнэлт хийж, өөрийн буруутай үйлдлийг ухамсарласан байх; 2.эрсдэлтэй зан үйлийг бууруулах, зохицуулах, засч сайжруулахад чадварыг эзэмшсэн байх; 3.зан үйлээ өөрчлөх итгэл үнэмшил нэмэгдэх, эрсдэлгүй шинэ зан үйлд суралцах оновчтой шийдвэр гаргах, өөрийгөө дайчлан ажиллах чадварыг эзэмшсэн байх; 4.уур бухимдлаа хянах, бууруулах, зохистой илэрхийлэх арга замд суралцсан байна; 5.өөрийгөө бодитойгоор үнэлж, бусдад зөв зохистойгоор илэрхийлж сурах, өөртөө зөв хандаж, нийгмийн нөлөөлөл дунд биеэ зөв авч явах арга замд суралцсан байна, Оролцогч нь зан үйлд нөлөөлөх сургалтад бүрэн хамрагдаж, гэр бүлийн хүчирхийллээс ангид байх ухамсар суусан байна.Этгээд нь зан үйл нөлөөлөх албадан сургалтад бүрэн хамрагдсанаар сургалт дуусгавар болж, үр дүнд хүрсэн байна.

Тав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан “Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам” гэсэн эрх зүйн зохицуулалтаар тус тус зохицуулагдаж байна.

Зан үйлд нөлөөлөх сургалтын хэрэгжилтийг нь 2019, 2020 оны эхний хагас жилийн байдлаар судлан авч үзье.

Нэг. Албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд зан үйлд нөлөөлөх сургалтын хэрэгжилт:

Улсын хэмжээнд зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан 2018 оны үлдэгдэл 426 этгээд 2019 онд шинээр 704 этгээдийг шүүхээс хүлээн авч, нийт 1130 этгээд бүртгэл хяналтад орсноос нас барсан 7, дахин гэмт үйлдэж ял шийтгүүлсэн 18, эрэн сурвалжилж байгаа 2, бусад үндэслэлээр 3 хасагдаж зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдвал зохих 1100 этгээдээс насанд хүрсэн 776, өсвөр насны 324 этгээд байна.

Зан үйлд нөлөөлөх сургалт явуулах эрх бүхий эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд эрх зүйн болон харилцааны чиглэлээр 146 удаагийн 297 цагийн сургалтыг зохион байгуулан ажилласан байна.

Хорих ангиас 2191 хоригдол шүүгчийн захирамжаар хугацаанаас өмнө тэнсэн суллагдаж хяналтад орсон бол үүнээс 91 хоригдолд зан үйл засах албадан сургалтад хамруулах шийдвэрийн дагуу эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нар дээрх этгээдүүдийг бүртгэл хяналтад авч сургалтыг зохих журмын дагуу зохион байгуулан ажилласан байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь 2019 онд зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, алба хаагчдыг мэргэшүүлэх, чадваржуулах чиглэлээр Монгол Улсын Багшийн Их сургуулийн харьяа “Сэтгэл зүйн үйлчилгээний төв”-тэй хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 92 дугаар тушаалаар 2019 оны 05 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч болон Баривчлах төв, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын нийт 49 алба хаагчдад “Бие хүний сэтгэл зүйн үндсэн асуудал болон сургалт зохион байгуулах арга зүй”-н чиглэлээр зан үйлд нөлөөлөх сургалт явуулах эрх олгох сургалтыг зохион байгуулж, “Сургагч багш”-ийн гэрчилгээ олгосон.

“Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран “Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэн гэмт хэрэг үйлдсэн болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэж, зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд сургалт зохион байгуулах хөтөлбөр”-ийг 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталж, Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 01 дүгээр сарын 09, 23, 02 дугаар сарын 14, 27, 03 дугаар сарын 27-ны өдрүүдэд зан үйлд нөлөөлөх сургалтыг тус тус зохион байгуулан, зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээсэн болон согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох хязгаарлалт тогтоогдсон нийт давхардсан тоогоор 378 этгээдийг сургалтад хамруулсан байна.

“Гэр бүл, хүүхдийн сэтгэл зүйн боловсролыг дэмжих төв” төрийн бус байгууллагатай хамтран “Зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх

албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд цахим сургалт зохион байгуулах хөтөлбөр"-ийг 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдөр баталж, орон нутаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хяналтад байгаа 408 /давхардсан тоогоор/ этгээдэд 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр, 2019 оны 01 дүгээр сарын 18, 02 дугаар сарын 22, 03 дугаар сарын 29, 04 дүгээр сарын 26-ны өдрүүдэд цахим сургалтыг зохион байгуулсан.

Хүснэгт 13. 2019 оны байдлаар зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа:

№	Шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс	Өсвөр насны хүн			Насанд хүрсэн хүн			Бүгд /Ажиллагаанд/
		Нийт	Хасагдсан	Ажиллагаанд	Нийт	Хасагдсан	Ажиллагаанд	
НИЙСЛЭЛ								
1	Нийслэл	137	55	82	382	161	221	303
2	Налайх	6	5	1	11	7	4	5
3	Багануур	9	5	4	25	10	15	19
Нийт		152	65	87	418	178	240	327
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР/ хорих ангитай/								
4	Говьсүмбэр	8	5	3	2	2	0	3
5	Дархан-Уул	15	6	9	25	14	11	20
6	Ховд	12	4	8	19	16	3	11
7	Хэнтий	21	6	15	39	8	31	46
8	Хархорин	5	0	5	7	2	5	10
9	Орхон	18	8	10	37	20	17	27
10	Мандал	5	4	1	9	6	3	4
Нийт		84	33	51	138	68	70	121
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР, ХЭЛТЭС								
11	Архангай	9	2	7	13	5	8	15
12	Баян-Өлгий	15	8	7	5	3	2	9
13	Баянхонгор	14	9	5	48	16	32	37
14	Булган	6	2	4	32	9	23	27
15	Говь-Алтай	9	1	8	4	1	3	11
16	Дорноговь	3	1	2	6	2	4	6
17	Замын-Үүд				3	1	2	2
18	Дорнод	11	9	2	50	24	26	28
19	Дундговь	5	1	4	6	3	3	7
20	Завхан				2	1	1	1
21	Тосонцэнгэл	3	2	1	2		2	3
22	Өвөрхангай	1	0	1	9	6	3	4
23	Өмнөговь	4	4	0	19	11	8	8
24	Сүхбаатар	10	8	2	17	8	9	11
25	Сэлэнгэ	9	4	5	4	2	2	7
26	Хөтөл				6	3	3	3
27	Хөвсгөл	1		1	17	3	14	15
28	Төв	1		1	23	11	12	13
29	Увс	14	11	3	7	4	3	6

Нийт	115	62	53	273	113	160	213
Бүгд	351	160	191	829	359	470	661

Нийслэлд:

-Зан үйл засах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд зохион явуулах сургалтыг дүүргүүдийн цагдаа, прокурорын газар, хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн төв, сэтгэцийн эрүүл мэндийн төв, албан бус насан туршийн боловсролын төв зэрэг төрийн байгууллагатай хамтарсан бол “Шалом төв”, “Эрчүүд гэр бүл хөгжлийн төв”, “Монгол халамж”, “Талын Монголын цуурай, увдис”, “Монгол өрх”, “Амжилтын аваргууд” зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран давхардсан тоогоор 18 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 2076 этгээдэд;

-Хорих ангитай шийдвэр гүйцэтгэх газруудад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/169 дүгээр тушаалаар батлагдсан “Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар сургалтыг явуулахаас гадна сургалт явуулах эрх бүхий эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран давхардсан тоогоор 1280 этгээдэд;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүд зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдаж хяналтад байгаа 388 этгээдэд сургалт явуулах эрх бүхий эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч болон орон нутгийн хууль хяналтын байгууллага, хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн төв, насан туршийн боловсролын төвийн багш, алба хаагчдыг урьж давхардсан тоогоор 1552 этгээдэд сургалтыг зохион байгуулан ажилласан байна.

Баривчлах төв:

Баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад анхаарч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”-ийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу “Эрчүүд, Гэр бүл хөгжлийн нийгэмлэг”, “Ивээлийн үйлчлэл”, “Help International”, “Өөрчлөлтийн хөтөч, донтолтоос эдгээх сургалт зөвлөгөөний институт”, “Хорихын үйлчлэлийн нэгдсэн төв” зэрэг ТББ-тай хамтран ажиллах гэрээг тус тус шинэчлэн байгуулж сургалтыг зохион байгуулан ажилласан байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нар танхимын сургалтаар 6892 баривчлагдсан этгээдэд 13784 цаг, ганцаарчилсан сургалтаар 302 этгээдэд 302 цаг, бие даалтаар 41153 цаг, хөгжим /зарлан мэдээлэх систем/ ашиглан 75804 цагийн сургалтыг зохион явуулсан бол хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын сургагч багш нар 4985 баривчлагдсан этгээдэд 9970 цагийн танхимын сургалтыг зохион явуулж тэдэнд гарын авлага, материал тарааж сургалтыг үр дүнтэй зохион байгуулан ажилласан байна.

Албадан сургалтад 7729 баривчлагдсан этгээдийн шүүхээс оногдуулсан албадан сургалтад хамруулах хугацааг /дунджаар/ 20 цагаар тооцоход 154,580

цагийн албадан сургалтыг зохион байгуулах тооцоолол гарч байгаа ба тайлангийн хугацаанд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, төрийн болон төрийн бус байгууллагын зохион байгуулсан 220,212 цагийн албадан сургалтыг ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулан ажилласан байна.

“Албадан сургалтын төлөвлөгөө”-ний дагуу хосолсон, бүлэг /зөрчлөөр ангилан/-ийн байдлаар танхимын сургалтыг 120-160 баривчлагдсан этгээдэд өдөрт 2-4 цаг, ганцаарчилсан хэлбэрийн сургалтыг өдөрт 1 цагаар баривчлагдсан этгээдэд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, “Баривчлах байрны дотоод журам” болон замын хөдөлгөөний аюулгүй байдлаар сургалтыг явуулж 6 төрлийн 865 ширхэг гарын авлага тарааж уншиж судлуулах, хөгжим /зарлан мэдээлэх систем/ ашиглан бие даалтаар өдөрт 1 цаг, нийтэд сонсох хэлбэрээр 2-3 цагийн сургалтыг тус тус зохион байгуулан ажиллаж байна.

2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Нийслэлийн Цагдаагийн газар, Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс, Баянзүрх дүүргийн Прокурорын газар, Баянзүрх дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар /1,2,3 дугаар хэлтэс/-тай хамтран “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-ын хэрэгжилтийг хангах өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгийн үеэр баривчлах шийтгэл эдэлж байгаа Баянзүрх дүүргийн харьяат этгээдүүд болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шүүхээр шийтгүүлсэн 250 этгээдтэй уулзалт, ярилцлага хийж, сургалт зохион байгуулан тэдний ар гэрийнхнээс ирүүлсэн захидал, илгээмжийг өгч, санал хүсэлтийг сонсохын зэрэгцээ 11 этгээдийг ар гэрийнхэнтэй нь уулзуулж “Итгэлцлийн гэрээ”-г байгуулж дахин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Улсын хэмжээнд зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдвал зохих 1100 этгээдийг сургалтад хамруулсан байгаа бол хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан оны үлдэгдэл 230 этгээд 2019 онд шинээр 406 этгээдийг шүүхээс хүлээн авч нийт 636 этгээд бүртгэл хяналтад орсноос нас барсан 4, дахин гэмт үйлдэж ял шийтгүүлсэн 13, эрэн сурвалжилж байгаа 2, бусад үндэслэлээр 1 хасагдаж, тайлангийн хугацаанд хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдвал зохих насанд хүрсэн 415, өсвөр насны 201 нийт 616 этгээд байгаагаас 382 этгээдийг 20 гаруй төрлийн мэргэжлээр хөдөлмөрлөх дадал чадвар эзэмшүүлэн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, 109 этгээд мэргэжлийн сургалтад хамрагдаж байгаа бол 125 этгээд сургалтад хамрагдаагүй байна.


Хөдөлмөрийн дадал олгох сургалтад сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад зарим газар, хэлтэс онцгой анхаарч тодорхой арга хэмжээг авч ажилласан байна.

Зан үйлд нөлөөлөх сургалт явуулах эрх бүхий эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд эрх зүйн болон харилцааны чиглэлээр 146 удаагийн 297 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь 2019 онд зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Багшийн Их сургуулийн харьяа “Сэтгэл зүйн үйлчилгээний төв”-тэй хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/92 дугаар тушаалаар 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 23-ны өдрүүдэд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч болон Баривчлах төв, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын нийт 49 алба хаагчдад хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах эрх бүхий “Сургагч багш” бэлтгэх мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан нь үр дүнтэй ажил болж сургалтын явц, үр дүнд тодорхой ахиц гарсан байна.

Хоёр. 2020 оны эхний хагас жил Шүүхээс зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэсэн 961 этгээд үүнээс насанд хүрсэн 695, өсвөр насны 266 этгээдэд сургалт зохион явуулахаас тайлангийн хугацаанд Өвөрхангай, Баян-Өлгий, Булган, Хөвсгөл Дундговь, Өмнөговь, Завхан аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, Ховд аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Сэлэнгэ аймаг Мандал сум дахь аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар болон орон нутгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, төрийн бус байгууллага албадан сургалтыг тогтмол зохион байгуулж насанд хүрсэн 360 этгээд, өсвөр насны 142 этгээдийг хамруулсан бол бусад аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс Шинэ короновирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Улсын онцгой комиссоос 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанаас шүүхээс зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд явуулах сургалтыг хойшлуулах тухай 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн За/122 дугаар албан бичгийг хүргүүлсэнтэй холбогдуулан сургалт зохион байгуулаагүй ба 459 этгээдийг сургалтад хамруулаагүй байна.

Зураг 15. 2020 оны эхний хагас жил зан үйлээ засах сургалтад хамрагдсан хүмүүсийн судалгаа



Баривчлагдсан этгээдүүдэд албадан сургалтыг зохион байгуулсан талаар;

2020 оны эхний хагас жилд Зөрчлийн тухай хуулийн баривчлах шийтгэл оногдуулах 9 зөрчилд холбогдон Нийслэлийн 9 дүүргийн шүүхээс 7-30 хоногийн баривчлах, 10-50 цагийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулахаар нийт 4689 этгээд баривчлагдсанаас эрэгтэй 4475, эмэгтэй, 192, насанд хүрээгүй хүүхэд 22 /эрэгтэй 16, эмэгтэй 2/ байгаа бол гадаад улсын харъяат 3 иргэн /БНХАУ, ӨМӨЗО-2, ОХУ-1/ байна. Баривчлагдсан этгээдүүдийг холбогдох хууль, журмын дагуу хүлээн авч нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар нь ганцаарчлан уулзаж Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Баривчлах байрны дотоод журам, зааврыг танилцуулан, сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Сургалтыг гаргасан зөрчилд нь тохируулан ганцаарчилсан болон танхимын, зарлан мэдээлэх систем ашиглан дараах сэдвүүдийн хүрээнд зохион байгуулж байна. Үүнд:

- Зөрчлийн тухай хуулийн 5.1.3 дахь заалт буюу мансуурах зөрчил гаргасан 72 этгээдэд “Мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай ойлголт ба түүний төрөл, ангилал”, “Мансуурах дон ба түүнээс үүсэх хор уршиг, үр дагавар”, “Мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос өөрийгөө хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх арга замууд”, “Хувь хүний сэтгэл зүйн онцлог”, “Стрессийг даван туулах арга зам, зөвлөгөө”, “Мансуурах зөрчилд холбогдож буй шалтгаан, нөхцөл” сэдвээр 35 удаа 62 цагийн;

- Зөрчлийн тухай хуулийн 5.2.1 дэх заалт буюу танхайрах зөрчил гаргасан этгээдэд 278 этгээдэд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Баривчлах байрны дотоод журам, “Танхайрах зөрчил, түүний төрөл, шалтгаан”, “Танхайрах зөрчил, танхайрах гэмт хэргийн ялгаа”, “Танхайрах зөрчлөөс үүсэх үр дагавар” сэдвээр 46 удаа 88 цагийн;

- Зөрчлийн тухай хуулийн 5.4.4 дэх заалт буюу гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 3396 этгээдэд “Гэр бүлийн хүчирхийлэл, түгээмэл хэлбэрүүд”, “Архины хэрэглээ, хор хөнөөл”, “Стресс ба түүнийг даван туулах арга зам”, “Хандлага, эерэг харилцаа”, “Уур бухимдлыг зохицуулах”, “Зөрчлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” сэдвээр 217 удаа 199 цагийн;

- Зөрчлийн тухай хуулийн 8.6.1 дэх заалт буюу хулгайлах зөрчил гаргасан 338 этгээдэд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Баривчлах байрны дотоод журам, “Хулгайлах зөрчил, түүний арга хэлбэр, шалтгаан”, “Хулгайлах зөрчил, хулгайлах гэмт хэргийн ялгаа”, “Хулгайлах зөрчлөөс үүсэх үр дагавар” сэдвээр 59 удаа 112 цагийн;


- Зөрчлийн тухай хуулийн 14.7.5 дахь заалт буюу согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил гаргасан 600 этгээдэд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Баривчлах байрны дотоод журам, “Тээврийн хэрэгсэлтэй тулгардаг асуудлууд”, “Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоноос үүсэх үр дагавар, сэдвээр 45 удаа 84 цагийн ганцаарчилсан болон танхимын нийт 402 удаа 545 цагийн сургалтыг тус тус зохион байгуулан ажилласан байна.

- Зөрчлийн тухай хуулийн 6.26.1 дэх заалт буюу бэлгийн дарамт учруулах зөрчил гаргасан 2 этгээд, 5.13.2 дахь заалт буюу гамшгаас хамгаалах тухай хууль зөрчсөн 1 этгээдэд ганцаарчилсан сургалтыг 7 хоногт 3 удаа зохион байгуулж байна.

Зарлан мэдээлэх систем ашиглан “Гэр бүлийн харилцаанд эерэг хандлага бий болгох”, Архины хамаарлын талаарх лекц болон архины хор нөлөө, түүнд нөлөөлөх хүчин зүйлүүд, архи, архинд донтох өвчнөөс болж гэр бүлийн харилцаанд сөрөг зан үйл гарч хүүхдийн хүмүүжилд хэрхэн муу нөлөөлөл үзүүлж байгаа шалтгаан, “Монгол тулгатны зуун эрхэм”, “Стресс түүний хор нөлөө”, “Гэр бүлийн харилцаа”, “Гэр бүлийг төлөвшүүлэх нь”, н.Бандихүү лекторын илтгэл, “Стрессийг даван туулах арга зам”, Гэр бүл, сэтгэл судлалын ухааны доктор Г.Наранбаатарын “Алдаж боломгүй амьдрал”, “Гэр бүлийн харилцаа”, “Гэр бүлийн харилцааны асуудлыг төлөвлөх нь”, “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Мансууруулах бодисын хор уршиг”, өсвөр насны хүүхдүүд хар тамхинд донтож буй шалтгаан болон эмэгтэйчүүдийн нийгэмд хүлээх үүрэг, хариуцлага, хандлагыг эерэгээр бүрдүүлэх арга зам, хувь хүний эд хөрөнгөнд зөвшөөрөлгүй халдах нь буруу зүйл гэдгийг ойлгуулах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоноор амь, бие, эд эрхтнээрээ хохирч байгаа, хэн нэгний амь насыг эрсдэлд оруулдаг тухай, бие хүний зан төлөвт эерэг төлөвшил олгох зэрэг сургалтуудыг 7 хоногт 3 удаа 15-18 цагаар зохион байгуулсан байна.

Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн зан үйлд нөлөөлөх сургалтыг хэрэгжүүлж буй 61 алба хаагчаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад өгөх таны үнэлгээ гэх асуулгад хангалттай сайн зохицуулсан-14, хангалгүй-5, сайжруулах шаардлагатай-34, мэдэхгүй-8 хариулсан байна.

Зураг 16. Зан үйлд нөлөөлөх эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ




Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 60 шийдвэр гүйцэтгэгчээс зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг шинээр хуульчилж өгсөн нь хэр оновчтой вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 23 буюу 38.3 хувь нь цаг үеэ олсон, 2 буюу 3.3 нь цагаа олоогүй буруу, 35 буюу 58.3 хувь нь зөв боловч бэлтгэл ажил хангагдаагүй гэж хариулсан байна.

Зураг 17. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг шинээр хуульчилж өгсөн байдалд өгсөн үнэлгээ



Шүүхээс оноож буй зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлдэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 12 буюу 20 хувь нь бүрэн хэрэгжиж байгаа, 48 буюу 80 хувь нь учир дутагдалтай хэрэгждэг гэж гэж хариулжээ.

Зураг 18. Зан үйлд нөлөөлөх сургалтын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ:



Дээрх судалгааны дүнгээс харахад зан үйлд нөлөөлөх сургалтын эрх зүйн орчинг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

2.2.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөний талаарх судалгааны дүн

Нэг. Монгол Улсад гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд сургалт явуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлалд хийсэн шинжилгээ

Монгол Улс түүхэн хөгжлийнхөө явцад гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг шийтгэж “цээрлүүлэх” гэхээс илүү “нийгэмшүүлэх” бодлогыг хэрэгжүүлж ирсэн гэж хэлж болох бөгөөд хорих байгууллагын түүхэн хөгжлийн явцад хоригдлыг нийгэмшүүлэх ажил хорих ял эдлүүлэх ажиллагааны нэг бүхэл хэсэг нь байсаар ирсэн.

Түүхэн урт хугацааны туршид гяндан, шорон, колони, хорих анги хэмээн нэрлэгдэж ирсэн байгууллага ялаа эдэлж байгаа хэнийг ч бол хүмүүжил, сургалтын ажилд хамруулан тэдэнд аятай нөлөө үзүүлэн чөлөөт амьдралд бэлтгэх явдлыг гол зорилгоо болгосоор ирсэн. К.Маркс хэрэгтэн ялантай төрийн зүгээс харьцах чиг хандлагыг “... зүрх судас нь цохилж байгаа улс орны амьд эд эс, эх орноо хамгаалах үүрэгтэй цэрэг, нийгмийн үүрэг гүйцэтгэж байгаа нөхөрлөлийн нэг гишүүн... эцэст нь хамгийн гол нь улсын нэг иргэн гэж үзэх ёстой”¹³, В.И.Ленин ял эдлүүлэх байгууллагын ажил, хөгжлийн чиг хандлагыг “Шорон гяндангаас хүмүүжлийн байгууллагад шилжих явдал юм”¹⁴ гэж тодорхойлсон нь Монгол Улсын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар МАХН, Төрийн дээд байгууллагаас удаа дараа гаргасан олон тогтоол, шийдвэрүүдэд тусгалаа олсон байдаг¹⁵.

1921 оны долдугаар сард Ардын Намын Төв Хороо, Түр Засгийн газрын хамтарсан хуралдаанаар төрийн яамдыг шинэчлэн байгуулахад Шүүх Яамны ерөнхий хэлтсийн харъяанд “Гяндан хороо” нэртэй байгууллага бий болсноор эдүгээгийн Хорих байгууллагын эх суурь тавигдсан байна. Хорих байгууллага түүхэн хөгжлийнхөө явцад хорих ял эдлэгсдийг сурган хүмүүжүүлэх талаар тодорхой бодлогыг барьж, эрх зүйн актуудыг гаргаж байсан. Тухайлбал: 1924 оны 8 дугаар сард МАХН-ын III их хурлаас “Гяндангийн дотоод байдлыг сайжруулах, хэрэгтэн ардуудыг гэгээрүүлэх тухай”, 1925 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын хоёрдугаар хуралдаанаар “Монгол Улсад шүүн таслах эрхийг шинэтгэн явуулах тухай” тогтоол гаргасан. 1925 онд батлан гаргасан тогтоолд “Хэрэгтэн хүнийг шийтгэх ял, улс төрийн бодлого бол хэрэгтнийг сурган хүмүүжүүлэхийг гол болгох, оногдуулах ял нь хууль зүйд нийцсэн, хэрэгтэн этгээдийг засрах бололцоо олгосон хөдөлмөр хийлгэх, цаг хугацаа дуусахын өмнө тэнсэн суллах зэргийг оролцуулсан байвал зохино” гэж заажээ.

Түүнчлэн Засгийн газраас 1925 оны 2 дугаар сарын 13-нд “Хэргийн учир гянданд хоригдогсдод ном, судар, сонин бичиг, бийр цаас оруулж гэгээрүүлэх тухай” ҮІ тогтоол гаргасан, мөн 1925 оны 5 дугаар сарын 9-ний 16 дугаар хуралдаанаар баталсан “Шинэ гянданг байгуулахын наана хуучин гяндангийн дотоод байдлыг арга эрэн засан сайжруулах” дүрэмд “Ялтан нарт лекц хэмээн сайн суртал журмыг

¹³ К.Маркс, Ф.Энгельс. Зохиолууд. II боть /132 дахь тал/

¹⁴ В.И.Ленин. ПСС.Т-38, стр 408

¹⁵ А.Лхагва. Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн замнал. УБ., 2001. 134 дэх тал

одоо цагийн улс төрийн шинэ, хуучин байдал зэргийг ялган салгаж тодорхойлон хэлж ухуулахуйц олон сургуулийн багш нар ба оюутныг болон сургуулийн шавь нар мэтийн эрдэмтдийг урин ирүүлж ухуулан гэгээрүүлбээс тустай бөгөөд одоо гяндагийн газар байшин савгүй тул энэ лекцийг өдрийн дулаан сайныг үзэж сар бүр хоёр удаа гяндангийн хашаан дотор ухуулан уншиж, сэнхрүүлэн хэрэглэвээс зохино” хэмээн заасан нь хорих байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байсан анхны дүрэмд хоригдлыг сурган хүмүүжүүлэх талаар тусгасан зохицуулалт гэж хэлж болох юм.

БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуульд тулгуурласан, хорих байгууллагын үйл ажиллагааг тал бүрээс нь зохицуулах зорилт бүхий “Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хууль”-ийг Улсын Бага Хурлаас 1931 онд батлан гаргасан. Энэ нь хорих ял эдлүүлэх ажиллагааг эрх зүйгээр зохицуулах анхны хууль байсан ба энэ хууль батлагдан гарахаас өмнө ял эдлүүлэх эрх зүйн харилцааг зохицуулахдаа хоригдлыг сурган хүмүүжүүлэх, гэгээрүүлэх, *боловсрол олгох* үндсэн зарчмыг хэд хэдэн дүрэм, журамд тусган хэрэгжүүлж ирсэнийг дээрх баримтаас харж болно.

Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хуульд хорих газруудын дотоод байдал ба түүний үндсэн бодлого, зохион байгуулалтыг “хоригдогсдыг эрхбиш аливаа боловсролын ажилд оролцуулан сургаж, тэдгээрээс алсдаа ажлын дадлагыг олж, суллагдан гарсны хойно ард олонд тустай ажил үйлдвэр хийж, гэмт явдлыг үйлдэх хэв заншлаа устгахад дөхөм болгохыг хичээнэ” гэж тодорхойлоод, “Сурган гэгээрүүлэх гэсний зорилго болбоос хоригдогсдод нийтийн эрдэм ба аливаа ажил үйлдвэрийн ангид боловсруулах аргуудыг зааж сургахаас гадна тус улсын байгуулалтын үндсэн бодлого хийгээд харъяат ардын эрх, үүрэгтэй танилцуулж, суллагдан тавигдсаны хойно улсын ажил явуулгын хэрэгт биеэр оролцоход дөхөм тустай болохыг хичээсэн хэрэг болно”, “Сурган гэгээрүүлэх хамгийн бага ажил нь бичиг үсэгт сургах ба улс төрийн бодлогыг огт мэдэхгүйг нь ном сонинг чангаар уншиж чаддаг болгохын дээр, тэр уншсаныг нь асууж тайлбарлуулж байваас зохино”, “Хоригдогсдоос гаргах ший бүжиг зэрэг боловсролын утга чанар бүхий тоглоом наадмын зүйлүүдийг ард олны зорилго байдалд таацуулан гүйцэтгүүлж уул хоригдогсдын дотроос ялангуяа ажилчныг өөрчлөн сургаж боловсруулбаас зохино”, “Засан сайжруулах газар дутам харъяат хоригдогсдод хэрэглүүлэхээр номын сан байгуулан, түүнд улс төрийн бодлогыг тодорхойлсон ба гэгээрүүлэх, ерөнхийд нь хэрэглэх аливаа эрдэмд сурах зэрэг эрдэм боловсролын чанар бүхий ном дэвтрүүдийг хуралдуулбаас зохиоос гадна биеийн тамирыг сайжруулах ажил сургуулийг тогтоосон цаг хэмжээнд гүйцэтгүүлж байваас зохино” гэхчилэн сурган гэгээрүүлэх, боловсрол олгох чиглэлд зохион байгуулах ажил, арга хэмжээний талаар тодорхойлон хуульчилсан байна¹⁶.

Мөн 1935 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Сайд нарын Зөвлөлийн 32 дугаар тогтоол /хууль цаазыг зохиох хянах комиссын 7 дугаар хурлын 1 дүгээр зүйл/-оор баталсан “БНМАУ-ын Засан сайжруулах газруудын дэргэдэх хянан харгалзах комиссын тухай дүрэм”-д “хоригдон бүхий үедээ үндэсний бичиг үсэг сайн сурсан ба

¹⁶ Л.Чүлтэмсүрэн.БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар гарсан хууль эрхийн баримт бичгийн эмхтгэл.1991. 27-29 дэх тал.

бусдыг сургасан ялтан нарт зохихыг үзэж уул ялаас хорогдуулах” хэмээн зааснаас үзвэл хоригдолд боловсрол олгох, сургалт нөлөөллийн ажилд хамруулах нь тэднийг ялаас хугацааны өмнө чөлөөлөх, тэнсэн суллах ажилд чухал нөлөө үзүүлж байсныг харуулж байна.

Анхны хуульд ялтанд ерөнхий боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх чиглэлээр тусгагдсан дээрх заалт нь дараа дараагийн хуулиудад эрх зүйн эх сурвалж болон тусгалаа олж, амжилттай хэрэгжиж ирсэн байна. Тухайлбал:

Хорих байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хоёрдох бие даасан хуулийг “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль” нэрээр батлан гаргажээ¹⁷. Энэхүү хуулийн шинэлэг тал нь “Ял шийтгэгдсэн этгээдийг засан хүмүүжүүлэх үндсэн арга”-ыг тодорхойлсон явдал бөгөөд энэхүү аргад ял шийтгүүлсэн этгээдийг засан хүмүүжүүлэхдээ тэднийг нийгэмд тустай хөдөлмөрт заавал оролцуулж, хорих дэглэмийг нарийн чанд сахиулж албадлага хэрэглэх, хүмүүжлийн ажлыг явуулах, ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалт зохиох зэргийг дурдсан байна. Эдгээр үндсэн аргыг ял эдлэгсдийн үйлдсэн гэмт хэрэг, зан төрх, хувийн байдал, хөдөлмөрт хандаж байгаа байдлыг харгалзан хэрэглэнэ хэмээн заасан нь мөн шинэлэг зохицуулалт болжээ.

Үүнээс гадна Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага нь хоригдож байгаа тодорхой мэргэжилгүй хүмүүсийг хөдөлмөрийн дадлагатай болгох, мэргэжил олгох ба мэргэжлийг ахиулах ажил зохион байгуулна, насанд хүрээгүй хүүхдүүдийг ерөнхий боловсролын сургалтад хамруулан үнэ төлбөргүй сургах, сургалтыг аль болох үйлдвэрлэлтэй холбох, хоригдол тогтоосон журмын дагуу зохиогдож байгаа хүмүүжлийн ажилд идэхтэй оролцож, тусгай мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуульд суралцана, хоригдох хугацаандаа ямар нэгэн мэргэжил эзэмшинэ, хүмүүжил хөдөлмөрийн колонид байгаа хоригдлууд техник мэргэжлийн сургалтын програмаар мэргэжилд суралцан мэргэжил дээшлүүлэх үүрэгтэй зэргийг хуульчлан тусгаж өгсөн нь ялтны Үндсэн хуулиар олгогдсон язгуур эрхийг хангасан чухал зохицуулалт болсон гэж дүгнэж болно.

1981 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд¹⁸ 1966 оны хуульд ерөнхий байдлаар тусгагдсан зарим заалтыг дэлгэрүүлэн хамрах хүрээг тодорхойлж өгсөн байдаг. Тухайлбал: “...ялтны боловсролын хэмжээг харгалзан ерөнхий боловсролын оройн сургалтыг зохион байгуулна. Ялтан ерөнхий боловсролын сургалтад заавал оролцох үүрэгтэй. Харин 40-өөс дээш насны болон тахир дутуугийн I, II группд орсон ялтныг ерөнхий боловсролын сургалтад саналаар нь оролцуулна. Ерөнхий боловсролын сургалтад ялтан идэвхтэй оролцож байвал сайшаан урамшуулж байх бөгөөд тэдний засарч, дахин хүмүүжиж байгаа байдлыг тодорхойлохдоо уг сургалтад хэрхэн оролцсоныг харгалзан үзнэ.”; “хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдлэж байгаа ялтныг ерөнхий боловсрол, мэргэжил олгох сургалтын шалгалтад бэлтгэх, шалгалт өгөхөд зориулан колонийн дарга хууль

¹⁷ БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1966 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар зарлиг

¹⁸ БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1981 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 403 дугаар зарлиг

тогтоомжид заасан хугацаагаар ажлаас чөлөөлнө” зэрэг болно.

1966, 1981 оны хуулиудад юуны өмнө хоригдлын дунд зохиох хүмүүжлийн ажлыг ял эдлүүлэх байгууллагын дэглэмийн төрөл, онцлогт тохируулан ялгавартайгаар явуулах шаардлага тавигдсан бөгөөд ялтнуудын дунд зохиох улс төр-хүмүүжлийн ажлын үндсэн зорилт нь хорих ял эдэлж байгаа ялтнуудыг үйлдсэн гэмт хэрэгт нь гэмшүүлж, хүмүүжил, хөдөлмөр, дэглэм журамд хэвшүүлж дасгах, тэдний ухамсар соёлын хэмжээг дээшлүүлэх, үр ашигтай санаачилгыг нь дэмжин хөгжүүлэх явдал байв¹⁹.

Мөн 1981 оны хуулийн нэгэн гол зохицуулалт нь “...ялтны боловсролын хэмжээг харгалзан ерөнхий боловсролын оройн сургалтыг зохион байгуулна. Ялтан ерөнхий боловсролын сургалтад заавал оролцох үүрэгтэй...” гэсэн заалт юм. Энэхүү заалт өмнөх болон дараагийн хуулиудад зөвхөн “Насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтанд бүрэн хамруулж, бусад хоригдол бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих байгууллага туслалцаа үзүүлнэ...” гэсэн байдлаар тусгагдсан байдаг.

1990 онд ардчилсан хувьсгал ялж, улмаар 1992 онд батлагдсан ардчилал, хүний эрхийн дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг тусгасан Үндсэн хуулийн хүрээнд хорих ял эдлэгсдийн эрхийг дээдлэх, нөхцөл, журмыг сайжруулах чиглэлээр олон хууль тогтоомж гарч хэрэгжиж иржээ. Үүний нэг нь 1993 оны 12 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хууль юм. Тус хуульд хоригдолд боловсрол олгох чиглэлээр дараах заалтууд орсон байна. Үүнд: Хорих анги нь хорих ялыг эдлүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ гэж 5 үүргийг дурдсан байх ба үүнд хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад хамруулах гэсэн үүргүүд багтсан байна. Мөн хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалтыг “хоригдлыг нийгэм, улс төр, эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, *мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх*, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад хэлбэрийн хүмүүжлийн ажил зохион байгуулна” гэж тодорхойлжээ. Хорих ангид явуулах сургалтын талаар “Насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтанд бүрэн хамруулж, бусад хоригдол бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих байгууллага туслалцаа үзүүлнэ. Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна.”, “Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох сургалт зохион байгуулж болно. Дадлага олгох сургалтанд хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулна.” гэсэн зохицуулалтыг тусгаж өгсөн байна.

Хорих ял эдлүүлэх чиглэлээр 1996²⁰, 2002²¹ онд гарсан хуулиудад дээрх хуулийн (1993) ямар ч заалт өөрчлөлтгүйгээр хуулбарлагдан орсон боловч эрх зүйн орчны зарим шинэчлэл хийгдсэн юм.

¹⁹ А.Лхагва. дурдсан бүтээл.

²⁰ 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай Монгол Улсын хууль

²¹ 2002 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль

Энэ шинэчлэлд ШШГЕГ-ын даргын 2002 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/221 тоот тушаалаар “Насанд хүрээгүйчүүдийн хорих ангид ял эдлэгсдийн дунд боловсрол, мэргэжил олгох, сургалт-хүмүүжлийн ажлын талаар баримтлах хөтөлбөр”, 2009 онд Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаалаар “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр” болон ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн тушаалаар “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар”-ийг тус тус батлан гаргасан байна.

Ялтны нийгэмшүүлэх хөтөлбөрийн зорилтод “Бүх нийтийг бичиг үсэгтэй болгох үндэсний хөтөлбөртэй уялдуулан ялтанд нөхөн боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх”, хөтөлбөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд “Ном гарын авлага бэлтгэх, сургалтыг орчин үеийн шинэ арга барилд шилжүүлэх”, “Олон улсын хорих байгууллагуудын сургалт, нийгмийн ажлын ололттой туршлагыг өөрийн орны хорих байгууллагын системд нэвтрүүлэх талаар судалж, санал боловсруулах”, “Орчин үеийн сургалтын шинэ арга хэрэгслийг хорих ангиудад нэвтрүүлэх, сургалтад ашиглагдах тоног төхөөрөмж, бусад хэрэглэгдэхүүнүүдийг нэмэгдүүлэхэд туслалцаа үзүүлэхүйц төсөл хэрэгжүүлэх” зэрэг чиглэлүүд багтсан. Түүнчлэн хоригдолд мэргэжил эзэмшүүлэх чиглэлд барилгын болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт ажиллах чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэх “Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”-ийг байгуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулах”, “Ялтны ажлын байрыг нэмэгдүүлэх, мэргэжил олгон чадваржуулах”, “Хөдөлмөрийн дадал олгох мэргэжлийн түр сургалтад хамруулж үнэмлэх олгох”, “Ялтны ял эдлэх хугацааг үр ашигтай байлгаж тэднийг суллагдсаны дараа эзэмшсэн мэргэжлээрээ нийгэмд бие даан амьдрах боломжийг бүрдүүлэх”, “Бүх нийтийг бичиг үсэгтэй болгох үндэсний хөтөлбөртэй уялдуулан ялтанд бага суурь болон бүрэн дунд боловсрол нөхөн олгох, мэргэжил эзэмшүүлэх”, “Бичиг үсэг үл мэдэгч ялтанг сургах, бага дунд боловсрол олгох сургалтыг зохион байгуулах”, “Хорих ангиудын номын сан шинэчлэх, номын фондод баяжилт хийх” зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 06 дугаар сарын 09-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан гаргаж, мөн оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр болон дагаж мөрдөж эхэлжээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд орсон ба тухайлбал, хорих ял эдлүүлэх төрөл, дэглэм, зэрэглэлийг шинээр тогтоон нээлттэй, хаалттай хорих анги, энгийн ба тусгай зэрэглэл, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбоотой болон бусад асуудлуудыг шинээр хуульчилж өгсөн байна. Шинэ хуульд нийцүүлэн ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 тоот тушаалаар “Нийгмийн ажлын аргачилсан заавар”, 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/110 дугаар тушаалаар “Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн сэтгэл зүйн ажлын заавар”-ыг тус тус батлуулан үйл ажиллагаандаа даган мөрдөж байна.

Эдгээр хуулийн хэрэгжилт ямар түвшинд байсан талаар зарим эрдэмтэн²² судлаачдын бүтээлд нилээдгүй баримтыг дурдсан байдаг. Түүнчлэн хоригдлыг хүмүүжүүлэх ажил нь олон талт үйл ажиллагаанаас бүрддэг ба үүний нэг чухал хэсэг нь хоригдлыг боловсролоор дамжуулан хүмүүжүүлэх явдал гэдгийг ч онцгойлон тэмдэглэсэн байдаг. Тэдний заримаас дурдвал:

Ерөнхий боловсролын сургалт: Хувьсгалын дараахан үед хоригдлыг анхан шатны сургалтанд хамруулан бичиг үсэг тайлах, 50-иад оноос насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтанд хамруулах ажил өргөнөөр зохиогдож байлаа.

Монгол Улсын төрөөс хорих ял эдлэж байгаа хоригдлыг ерөнхий боловсролын /энд бичиг үсгийн сургалт мөн хамаарна/ сургалтанд хамруулахад ихээхэн анхаарч холбогдох эрх зүйн зохицуулалтын болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн түүхэн уламжлал нь арвин баялаг юм. Энэ нь хорих ял эдлүүлэх чиглэлээр гарсан удаа дараагийн хууль тогтоомж, төрийн төв байгууллагаас гаргаж байсан тушаал, шийдвэрүүдэд тусгагдаж ирсэн ба нэн ялангуяа насанд хүрээгүй хоригдлыг сургах, хөдөлмөрлүүлэх, хүмүүжүүлэн төлөвшүүлэх, хөгжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь сургалт гэдгийг бүр анхнаас нь онцгойлон анхаарч ажиллаж байжээ. Тухайлбал:

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1942 оны 8 дугаар хурлын тогтоолд “Хүмүүжүүлэн буй хүүхдийг сургахын тулд Насанд хүрээгүйчүүдийн колоний газар байгуулахын хамт ерөнхий эрдэмд сургах явдлыг ДЯЯ-ны харъяа Засан хүмүүжүүлэх лагерийн удирдах газарт үүрэг болгосугай”, Хүүхдийн колоний хэрэг эрхлэх комиссоос 1944 онд батлан гаргасан “Насанд хүрээгүй хоригдлуудын хөдөлмөрийн колоний дүрэм”-д “Насанд хүрээгүй хоригдлуудыг сургуулийн журмаар сурган хүмүүжүүлэх ба ажил хөдөлмөрийн дадлага, мэргэжилтэй болгох нь хүүхдийн колоний үндсэн үүрэг” хэмээн тодорхойлоод, тус колоний бүтэц, бүрэлдэхүүнд сургууль ба сурган хүмүүжүүлэх анги, үйлдвэр техникийн анги зэрэг анги танхимууд байхаар нарийвчлан заасан байна. Энэ дүрэмд хүүхдийн колоний бүхий л үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тавьж өгсөн бөгөөд хожмоо НАХЯ-ны сайдын 1958 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн тушаалаар шинэчлэгдэж батлагдсан байна.

МАХН-ын Төв хороо, СнЗ-өөс 1964 оны 8 дугаар сарын 26-ны өдөр “Хүүхдийн колоний ажлыг сайжруулах арга хэмжээний тухай” 228/387 дугаар тогтоол гаргаж, “Хүүхдийн колони нь хөдөлмөр голлосон сургалттай байх зарчим дээр үндэслэн 4-8 дугаар ангийн хичээлийн шинэ программ боловсруулан гаргаж мөрдөх, хүүхдийг мужаан, дархан, хөдөө аж ахуйн машин, механизмын жолооч, засварчны мэргэжилд сурган, мэргэжлийн үнэмлэх олгох, ялын хугацаа дууссан хүүхдийг зохих ажилд буюу сургуульд шууд шилжүүлэн өгч байх, хүүхдийн колонид дадлага, туршлагатай сайн багш нарыг томилох, хүүхдийг хүмүүжүүлэх хөдөлмөрт дадлагажуулах ажилд залуучуудын байгууллага шефийн туслалцаа үзүүлж байх” зэрэг олон чухал заалт

²² А.Лхагва, М.Ганхүү. Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ., 2015.

орж, сргалтын ажлыг сайжруулахад чиглэгдсэн эрх зүйн орчныг шинээр бүрдүүлж өгчээ. Мөн Ардын боловсролын яамны сайдын 348 тоот тушаал гарч Хүмүүжил-хөдөлмөрийн колонийн сургалтын программыг “бичиг үсэг үл мэдэгчдэд зориулсан бэлтгэл анги”, “бага анги”, “дунд анги”, “мужаан, токорьчин, тракторчин, ногоочны зэрэг мэргэжил олгох техник мэргэжлийн сургууль” гэсэн ангиллаар дахин шинэчлэн баталсан байна.

1981 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд 40-өөс дээш насны болон тахир дутуугийн I, II группд орсон хоригдлоос бусдыг ерөнхий боловсролын сургалтад заавал хамруулахаар тусгаж өгсөн нь өмнөх хуулиудаас онцлог юм. Өөрөөр хэлбэл насанд хүрсэн хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад заавал хамруулахаар тусгаж өгсөн ганц хууль гэж хэлж болно.

Энэхүү хуульд нийцүүлэн НАХЯ, АБЯ-ны сайд нарын 1986 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Ялтны дунд явуулж байгаа ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын сургалтыг сайжруулах арга хэмжээний тухай” А/78/360 тоот хамтарсан тушаал гарсан. Энэ тушаалд “Дарьт дахь хүмүүжил хөдөлмөрийн колоний ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, хичээл тус бүрийн программыг шинэчлэн боловсруулж, 1987-1988 оны хичээлийн жилээс мөрдүүлэх, колоний ерөнхий боловсролын сургалтыг удирдах ажлыг Зүүнхараа хотын 10 жилийн 1-р дунд сургуульд хариуцуулах, колонид ажиллах ерөнхий эрдмийн хичээлийн багш нарыг ЗХХБУГ-ын захиалгаар АБЯ-наас шууд томилж байх”-аар заасан байна.

Мөн ял эдлэж байх хугацаандаа бүрэн бус ба бүрэн дунд сургуулийг амжилттай төгсөөд суллагдсан ялтныг ТМС-д элсүүлэх, их, дээд, тусгай дунд сургуулиудын уралдаант шалгалтанд оруулж байхаас гадна, суллагдах үедээ 16 нас хүрээгүй хүүхдийг ерөнхий боловсролын сургуулийн зохих ангид нь шилжүүлэн сургаж байхыг холбогдох яам, газруудад үүрэг болгон хэрэгжүүлж байжээ.

1987 онд “Хүмүүжил-хөдөлмөрийн колоний сургалтын системд өөрчлөлт оруулах тухай” шийдвэр гарч, үйлдвэр сургалтын шинэ системээр ажиллаж, жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 01-ныг хүртэл 20 долоо хоногт багтаан хөдөө аж ахуйн машины засвар трактор, комбайны жолооч, ногоочны болон залуу малчны сургууль, курст тус бүр 480 цагийн хичээл заадаг болжээ. Мөн мэргэшүүлэх хичээлээс гадна бага, дунд, ахлах анги байгуулж ерөнхий эрдмийн хичээл заах, энэ сургалтын хүрээнд бүх хүүхдэд улс төрийн анхны мэдэгдэхүүн, хууль зүйн наад захын мэдлэг ойлголт өгөх 100 цагийн сургалт явуулдаг болов.

Ардчилсан нийгмийн тогтолцооны үед хорих байгууллагын нөхцөлд ерөнхий боловсролын сургалтыг зохион байгуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай Монгол улсын хууль, “Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр”²³-т тусгагдсан Монгол Улсын иргэн сурч боловсрох эрх эдлэх, 17 хүртэл насны иргэдийг сургаж суурь боловсрол заавал эзэмшүүлэх зэрэг нийтлэг зарчмыг баримталдаг байв. Энэ зарчим нь юуны өмнө насанд хүрээгүй хоригдолд бүрэн хамаарагдана. Өөрөөр хэлбэл нэгэнт л суурь боловсрол эзэмшүүлж байгаа

²³ Монгол Улсын Засгийн газрын 1995.2.6-ны 19 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөр

бол хорих байгууллагын дэргэдэх сургалтын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтад иргэний сургууль боловсролын байгууллагынхаас ялгагдах ямар нэг онцлог байж таарахгүй. Иймд насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн дэргэдэх ерөнхий боловсролын сургууль нь Монгол Улсын Боловсролын тухай хуульд зааснаар суралцагчдад бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхийн зэрэгцээ тэдэнд бие даан боловсрол эзэмших чадвар, амьдарч аж төрөх арга дадлагатай иргэн болж төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах зорилго бүхий сургалтын байгууллага байх ёстой гэдэг зарчмыг баримталж байжээ.

Насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, технологи нь дунд сургуулийнхтай адил агуулгатай байх бөгөөд төгсөгчдөд улсаас тогтоосон нэг загварын гэрчилгээ олгодог. Мөн насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад хамруулахтай холбогдсон зохион байгуулалтын бүх ажлыг тухайн хорих анги шууд хариуцан явуулдаг ба өөрийн нутаг дэвсгэр дэх боловсролын байгууллагатай харилцан зөвшөөрөлцсөн гэрээний үндсэн дээр цагийн багш томилон ажиллуулж байжээ²⁴.

Монгол Улсын төр засаг, төрийн төв байгууллагуудаас гаргаж байсан дээрх хууль тогтоомжийн заалтыг бодит ажил болгон амьдралд хэрэгжүүлэхийн тухайд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн төв байгууллага болон хүүхдийн колоний үе үеийн удирдлага, багш сурган хүмүүжүүлэгчид, ажилтан, ажилчид олон арван жилийнхээ нөр их хөдөлмөрийг зориулж, алдаж эндсэн хүүхэд багачуудыг “хүн шиг хүн болгох” түвэгтэй бөгөөд ач буянтай ажилд асар их хичээл зүтгэл гарган хийж бүтээж ирснийг хурандаа Д.Цээсэд бүтээлдээ нилээд дэлгэрэнгүй дурджээ²⁵. Тухайлбал: Өнгөрсөн хугацаанд бидний гар дээр хүмүүжээд гарсан хүүхдүүдээс Монгол Улсын Хөдөлмөрийн баатар 3-4 хүн байдаг ба сүүлийн 10 жилд ялтан хүүхдүүдийг сургах, хөгжүүлэх, төлөвшүүлэх талаар зохиосон ажил, хүрсэн түвшин, олсон ололт олон бий хэмээн дурджээ. Эдгээрийн заримыг дурдвал:

2000 оноос Кристина Нобелийн Хүүхдийн сангийн “Боловсрол” төсөл тус ангид хэрэгжиж хоригдол хүүхдүүдэд ерөнхий эрдмийн хичээл заах ажил шинэ шатанд гарсан байна. Энэ үед сургалтын материаллаг бааз, үйлдвэрлэлийн дадлага хийх газаргүй, зах зээлийн эхэн үеэр нийслэлд ундуй сундуй нүүж ирсэн учир бүхнийг шинээр эхэлж байлаа. Чухам энэ үед дотоодоос Н.Болормаа тэргүүнтэй “Хүүхдийн эрхийн төлөө төв”, гаднаас Кристина Ноблийн Хүүхдийн сан /КНХС/ зэрэг байгууллагууд тусламжийн гараа сунгаж тусласнаар хичээл хүмүүжлийн ажил дахин сэргэсэн түүхтэй.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдын 2000 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 258 тоот захирамжаар Зайсан дахь Насанд хүрээгүйчүүдийн хорих ангид “Хөдөлмөрийн төрөлжсөн сургалттай суурь боловсролын тусгай дунд сургууль” байгуулагдав. Ийнхүү хүүхдийн хорих анги анх удаа Нийслэлийн Хан-Уул дүүргийн 110 дугаар сургууль гэсэн хаяг зүүснээр барахгүй, сургалтын таатай орчин бүрдэж, төрөл бүрийн мэргэжлийн орон тооны багш 10 гаруй, цагийн багш нар мөн төдий тооны болж, хоригдол хүүхдийг ерөнхий

²⁴ А.Лхагва, М.Ганхүү. Дурдсан бүтээл. УБ., 2015.

²⁵ Д.Цээсэд. Хэн ч үзээд атаархах ирээдүй бидэнд бий. УБ.42-45 дахь тал

боловсролын болон хөдөлмөрийн дадлага, мэргэжил олгох сургалтанд бүрэн хамруулах болжээ.

2000-2002 онуудад КНХС-ийн тусламжтайгаар компьютер, англи хэлний сургалтын анги, кабинет нээж, БНГУ-ын Ханнс Зайделийн Сангийн ивээлээр гар хивс урлалын анги, мөн “Урам” ТББ-ын дэмжлэгтэйгээр “Жижиг урлал”-ын хичээлийн танхимуудтай болсон нь ихээхэн дэвшил болжээ.

Тэрчлэн Японы “Энх тайвны салхи” байгууллагын төслөөр орчин үеийн техник хэрэгслээр тоноглож тохижуулсан ном уншлагын танхим, сэтгэл зүйн кабинит байгуулж ашигласан нь хорих ангийг сургуулийн өнгө төрхтэй болгоход чухал хувь нэмэр болов. Мөн анх удаа орон тооны сэтгэл зүйч багштай болж, улмаар “Шри шри” амьдрах ухааны болон “Впяшня” бясалгалын хичээлийг 2-3 жил дараалан эрх бүхий мэргэжлийн багш нарын удирдлагаар явуулсан нь хүүхдийн сурлага, хүмүүжлийн төлөвшилд мэдэгдэхүйц үр нөлөө өгснөөр барахгүй Насанд хүрэгчдийн хорих ангиудад ч авмаар сайн туршлага гэгдэж байсан билээ.

2002 онд “Канадын сан” болон “Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгууллагын буцалтгүй тусламжаар барьж байгуулсан иж бүрэн тохижуулсан 30,0 сая төгрөгийн төсөвтэй “Сургалтын төв”, мөн 2004 онд “Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгууллага 10,0 сая төгрөгөөр хүүхдэд мэргэжил олгох мастерын газар байгуулж, ашиглалтанд оруулсан зэрэг нь сургалтын материаллыг орчинг зохих хэмжээгээр бүрдүүлжээ.

Харин насанд хүрсэн хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад албан ёсоор хамааруулах тухай хуулийн заалт байхгүй /1981 оны хуулиас бусад/. Хэрэв насанд хүрсэн ялтан биеэ дааж ерөнхий боловсролын түвшингээ ахиулахыг хүсвэл хорих байгууллагын захиргаа тэдэнд туслах үүрэгтэй ба сургалтыг хорих ангийн байрлалд зохион байгуулна хэмээн үе үеийн хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох хууль тогтоомжид заасан байдаг. Мөн ял эдэлж байхдаа ерөнхий боловсролын сургуульд сурч байсан боловч түүнийгээ дуусгалгүйгээр суллагдсан хүмүүсийн зохих шатны сургуульд үргэлжлүүлэн сургахад холбогдох баримт материалыг зохих журмын дагуу бүрдүүлж өгөх үүргийг хорих анги хүлээдэг байна.

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колониудад 1983 оноос эхлэн ерөнхий боловсролын оройн сургалтыг зохион байгуулж, энэ ажилд ойр зэргэлдээх боловсролын байгууллага ерөнхий боловсролын сургуулиудын туслалцааг авч ажиллаж байв²⁶.

Мөн 1986-1987 оны хичээлийн жилд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 11 колонид 500 шахам хоригдлыг хамруулан ерөнхий боловсролын сургалт явуулан 4-10 дугаар ангийн программаар хичээл зааж байсан тухай түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

Сүүлийн үеийн тоо баримтаас үзэхэд бичиг үсгийн сургалтад 2012 онд 278, 2013 онд 223, 2014 онд 276, 2015 онд 287, 2016 онд 235, 2017 онд 214, 2018 онд 89 хоригдол бичиг үсгийн сургалтад, 2012 онд 9, 2013 онд 30, 2014 онд 21, 2015 онд

²⁶ А.Лхагва. Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ., 2008. 167 дахь тал

21, 2016 онд 53, 2017 онд 72, 2018 онд 73 хоригдол ерөнхий боловсролын сургалтад тус тус хамрагдсан байна²⁷.

Мэргэжлийн сургалт: 1940-өөд онд ДЯЯ-ны харьяа Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба хорих ангиудыг удирдах газрын барилгын лагерьт Зөвлөлтийн мэргэжилтэн Зинько, Терих, Суров, Семенов зэрэг хүмүүс ажиллан хоригдолд барилгын төрөл бүрийн мэргэжил эзэмшүүлэхэд хүч оюунаа зориулж байсан баримт бий. Тэдгээр хүмүүс хоригдлыг бригадын дарга, норм зохиогч, жолооч, слесарь, сантехникч, чулууны мэргэжилд сургаж байсны дүнд 1940 онд барилгын лагериас суллагдсан хүмүүсийн 990 нь ямар нэг мэргэжил эзэмшсэн байв. Мөн лагерьт 1941 он гэхэд бүгд 1770 хоригдол байсны 980 буюу 50 гаруй хувь нь тодорхой мэргэжилтэй болсон байлаа. Ялтанд мэргэжил эзэмшүүлэх ажил 40-өөд онд их идэвхтэй өрнөж байсны бас нэг тод бишээ бол 1940 онд нийт хоригдлын мэргэжлийн зэргийг тогтооход нилээд өндөр үзүүлэлт гарсан явдал юм.²⁸

1960-аад онд хоригдолд мэргэжил эзэмшүүлэх ажил өргөн хүрээтэй зохион байгуулагдаж байсны нэг жишээ нь Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтсийн даргын 1961 оны 10 дугаар сарын 18-ны “тракторын жолоочийн курс байгуулах тухай” 216 тоот тушаалд “10 дугаар сарын 20-ноос эхлэн Тракторын жолооч бэлтгэх хоёр сарын хугацаатай курсийг Мод бэлтгэлийн захиргааны дэргэд байгуулж 4-7 дугаар ангийн боловсролтой 20-35 насны хүмүүсийг элсүүлэн сургасугай”, мөн хэлтсийн даргын 1968 оны 12 дугаар сарын 20-ны 329 тоот тушаалд “Бугантын мод бэлтгэлийн аж ахуйд хоригдолд мэргэжил эзэмшүүлэх зорилгоор авто жолооны 30 хүний курс зохион байгуулах, онолын хичээлийг зөвлөлтийн мэргэжилтэн И.А.Борянцев, офицер Дамдиндорж, Сандоо, Жилхүү нараар заалгахыг холбогдох хүмүүст даалгасугай” хэмээн тус тус дурдсан баримт юм.

НАХЯ-ны сайдын 1973 оны 699 тоот тушаалын хүрээнд барилгын бүх хорих колониудын дэргэд хоригдолд барилгын төрөл бүрийн мэргэжил эзэмшүүлэх 3 сарын хугацаатай курс байгуулсан байна. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага VI таван жилд /1975-1980/ 900-аад ялтанд токарь, мужаан, шаварчин, өрлөгчин зэрэг мэргэжил эзэмшүүлснийг тухайн үеийн тайланд дурдсан байна²⁹.

ЗХХБУГ-ын даргаар ажиллаж байсан хошууч генерал Ж.Содном дурсамждаа “НАХЯ, Ардын боловсролын яам, Хөдөлмөр нийгэм хангамжийн Улсын хорооны хамтарсан хэд хэдэн тушаал гаргаж ялтны ерөнхий боловсролыг ахиулах, ажил үйлдвэрлэлийн мэргэжил олгох арга хэмжээг шийдвэрлэж байв. Мөн мужаан, токарьчин, шаварчин, өрлөгчин, трактор, комбайны жолооч, дизельчин, рамчин зэрэг 15 төрлөөр хоригдолд мэргэжил олгох курсийг 45-60 хоногийн хугацаагаар зохион байгуулж, мэргэжлийн багш нараар хичээл заалган дадлага хийлгэж, шалгалтыг чиглэл чиглэлээр байгуулагдсан улсын комисс газар дээр нь авч, улсын хэмжээнд хүчин төгөлдөрт тооцогдох үнэмлэх олгодог байлаа. Жилд дунджаар 400

²⁷ “Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хийсэн дүн шинжилгээ судалгааны тайлан /2003-2018/. УБ., 2019.72 дох тал

²⁸ Л.Чүлтэмсүрэн. Засан хүмүүжүүлэх байгууллагын товч түүх.УБ.1979 он /37-38 дахь тал/

²⁹ “Засан хүмүүжүүлэх албаны мэдээлэл” сэтгүүл. 1981 он. №2 /21 дэх тал/

орчим хүн мэргэжлийн зэрэг авдаг байсан юм” гэжээ³⁰.

Мөн сургалтын ажлын эрх зүйн зохицуулалтыг улам нарийвчлан боловсронгуй болгох зорилгоор “Ялтнуудад мэргэжил олгох сургалт зохион байгуулах тухай”³¹, “Ялтны дунд явуулж байгаа ерөнхий боловсрол, мэргэжлийн сургалтын ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай”³², “Ялтанд мэргэжил шинээр эзэмшүүлэх, тэдэнд зохих шатны ерөнхий боловсрол олгох сургалтын журам батлах тухай”³³, “Ялтны дунд явуулах мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтанд өөрчлөлт оруулах тухай”³⁴ зэрэг тушаалуудыг гаргаж байжээ. Эдгээр тушаалуудын заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажил ЗХХБ-ын системд 1983-1990 он хүртэлх арваад жил идэвхтэй өрнөж байлаа.

1984 оноос Хархорин, Зүүнхараа, дараа нь Ганц худагийн урьдчилан хорих төвийн дэргэд ялтанд мэргэшил эзэмшүүлэхэд зориулсан сургалтын төв, сургалт-үйлдвэрлэлийн комбинат байгуулан ажиллуулсан ба ЗХХБУГ-ын даргын 1982 оны 5 дугаар сарын 31-ний 360 тоот тушаалаар нийт 9 анги, колоний 338 хоригдолд 15 төрлийн мэргэжил эзэмшүүлсэнийг баталсан комиссын дүгнэлтийг үндэслэн мэргэжлийн зохих зэргийн үнэмлэх олгож байв.

Мөн газрын даргын 1985 оны 360, 752 тоот тушаалаар Хархорин, Биндэр дэх ЗХХ-ийн колониудын бүгд 77 хүнд дизельчин, замчин, өрлөгчин, будагчин, мужаан, тоосгоны мэргэжлийн үнэмлэх, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 864 ялтанд 14 төрлийн мэргэжил эзэмшүүлсэн тухай НАХЯ-ны Коллегийн 1985 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хурлын протоколд тэмдэглэсэн юм. Хархорины сургалтын төв, Улаанбаатар хот дахь Сургалт үйлдвэрлэлийн комбинатын захирлаар ажиллаж байсан дэд хурандаа Н.Ганзориг дурсамжиндаа “...Мэргэжлийн сургалтыг мужаан, сийлбэрчин, дархан, өрлөгчин, засал чимэглэлчин, цахилгаанчин, сантехникч зэрэг мэргэжлээр явуулж 1986-1988 онд 800 гаруй хоригдолд мэргэжил эзэмшүүлэн үнэмлэх олгосон”, түүнчлэн ЗХХБУГ-ын нэгэн даргын илтгэлд “1989 онд 6000 ялтын байсны 655-ыг мэргэжил эзмшүүлэх сургалтад хамруулсан” гэж өгүүлсэн нь бас нэгэн түүхэн бодит жишээ юм.

Хорих байгууллагыг удирдах газраас ШУБЯ-тай хамтран “Хоригдлын сургалтын хөтөлбөр /1994-1996/”-ийг батлан гаргасан нь тухайн үед хоригдлын дунд явуулах сургалтын талаарх шинэлэг арга хэмжээ байв. Хөтөлбөрт заасан сургалтыг явуулахлаа хоригдлуудад хэт номчирхон тайлбарлахаас аль болох зайлсхийж, тухайн хичээлийн 60-70 хувийг ажиглалт, ярилцлага, даалгавар, дадлага, сорилт туршилтын арга, хэлбэрээр зохион байгуулах нь илүү үр дүнтэйг анхаарвал зохих, сургалтын явцад хоригдол нийгэм, олон нийт, гэр бүл, хүмүүсийн дунд өөрийн эзлэх

³⁰ А.Лхагва. Гяндан салаанаас шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн замнал. УБ., 2001 он /242 дахь тал/

³¹ НАХЯ-ны сайдын 1983 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 1090 тоот тушаал

³² НАХЯ, Ардын боловсролын яамны сайдын 1986 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А-78/360 тоот тушаал

³³ БНМАУ-ын Хөдөлмөр нийгэм хангамжийн улсын хорооны дарга, Ардын боловсролын яам, НАХЯ-ны сайдын 1987 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 80/371/А-67 тоот тушаал

³⁴ БНМАУ-ын Ардын боловсролын яамны сайд, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын даргын 1990 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн Б-434/251 тоот тушаал

байр сууриа үнэн бодитой мэдэрч, өөрийгөө хөгжүүлэх бие хүний тодорхой чадвар, боловсрол, бүтээлч чанарыг олж эзэмшсэн байх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай зэргийг дурдсан байна.

2009 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас “Барилгын салбарт мэргэжилтэй ажилчин бэлтгэх зарим арга хэмжээний тухай” 23 дугаар тогтоол гарч, 6 дугаар зүйлд “Ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх зорилгоор төвлөрсөн хорих ангиудын дэргэд мэргэжлийн түр сургалт зохион байгуулж ажиллуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай” гэж заажээ. Энэ нь хорих ял эдлэгсдийг суллагдсаны дараа нийгмийн бүтээн байгуулалтын ажилд оролцох, хамт олны дунд орж ажилласнаар засрал, хүмүүжил олж авахад нь төрөөс нөлөөлж байгаагийн нэг илрэл болсон юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /2002 он/ 124, 125 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар”-ын даргын 20/105 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /ШШГЕГ/-ын даргын 2009 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/31 тоот тушаалаар ШШГЕГ-ын дэргэдэх “Мэргэжил эзэмшүүлэх төв” анх байгуулагдаж “Чадамжийн гэрчилгээ” олгох сургалт явуулж үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ. Энэ төв нь суурин болон явуулын гэсэн чиглэлээр сургалтыг зохион байгуулж байсан бөгөөд суурин сургалтыг Амгалан дахь хорих 421 дүгээр анги дээр барилгын мэргэжлээр, хорих 407 дугаар анги дээр оёдол, эсгүүр, хорих 401 дүгээр анги дээр алт, мөнгөний дарханы чиглэлээр явуулж байжээ. Харин явуулын сургалтыг хөдөө орон нутгийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран явуулдаг байжээ. Түүхэн тоо баримтаас дурдвал: 2009 онд Говь-Сүмбэр аймгийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв /МСҮТ/-д 40 хоригдлыг уул уурхайн, Дархан-Уул аймаг дахь МСҮТ-д 30 хоригдлыг засал чимэглэлийн, Зүүн хараа дахь МСҮТ-д Зүүн хараа болон Дарьтын хорих ангиас 60 хоригдлыг авчирч төмс, хүнсний ногоо тариалалтын, Хэнтий аймаг дахь МСҮТ-д 30 хоригдлыг засал чимэглэл, өрөг угсрагч мэргэжлээр тус тус сурган төгсгөж, “Чадамжийн гэрчилгээ” олгосон байна. 2009 онд Мэргэжил эзэмшүүлэх төв нь орон нутгийн болон суурин сургалтад нийтдээ 128, давхардсан тоогоор 229 хоригдолд мэргэжил эзэмшүүлж “Чадамжийн гэрчилгээ” олгожээ. 2010-2011 онд Мэргэжил эзэмшүүлэх төв нь суурин сургалтынхаа хүрээнд сургалтын бааз дээр суурилан дадлага болон онолын сургалтын 120 цаг буюу 45 хоногийн сургалтыг явуулж байсан төв, орон нутгаас сургалтад хамруулах зорилгоор нийт 300 хоригдлыг Хорих 421 дүгээр ангид байршуулж, барилгын засал чимэглэлээр 37, өрөг угсрагч 37, сантехник, гагнуур 29, цахилгаан 18, бетон арматур 17, мужааны мэргэжлээр 150 хоригдолд мэргэжил эзэмшүүлэн, амжилттай төгссөн 20 ялтанд “Сайшаалын үнэмлэх”, шагналын хоног олгож урамшуулсан байна³⁵.

Хөдөлмөрийн зах зээлд мэргэжлийн ажилчны эрэлт өсөж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан хөдөлмөр эрхлүүлэх зайлшгүй шаардлага гарч ирсэн. Засгийн газраас энэ асуудалтай холбогдуулан “Үндэсний мэргэжилтэй ажилчин бэлтгэх” хөтөлбөрийг 2011 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүний дагуу

³⁵ Эрх зүй, албаны мэдээлэл сэтгүүл. УБ., 2010. 52,53 дахь тал

хоригдлыг мэргэжлийн сургалтад хамруулан улмаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор байгуулсан “Мэргэжил эзэмшүүлэх төв”-ийг өргөжүүлэх талаар ХЗДХЯ, БСШУЯ-тай харилцан зөвшилцөж Засгийн газрын 2012 оны 05 дугаар сарын 9-ны өдрийн хуралдааны 159 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн сургалт, үйлдвэрийн төв” байгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн билээ. Тус тогтоолын хүрээнд ШШГЕГ-ын даргын 2012 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулах тухай” А/69 дүгээр тушаал батлагдаж, тус төвийг “Амгалан” мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, хорих 449 дүгээр анги гэсэн дугаар олгон үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллаж эхэлсэн юм.

Гэвч “Хорих 449 дүгээр анги” гэсэн дугаар олгосон нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /2002 он/ 106 дугаар зүйлийн 106.1 дэх³⁶ заалтыг зөрчсөн гэж үзэн А/69 дугаар тушаалыг хүчингүй болгож ШШГЕГ-ын даргын 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/108 дугаар тушаалаар ШШГЕГ-ын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болгон нэрийг өөрчилж “Мэргэжлийн үнэмлэх зэрэг” олгох сургалт явуулах болсон байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь ШШГЕГ-аас батлагсан захиргаа-санхүү, сургалтын алба, харуул хамгаалалтын алба гэсэн бүтэцтэйгээр 35 алба хаагчийн орон тоотой үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд дээрх Засгийн газрын тогтоолын хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлснээр сургалтын бааз, тоног төхөөрөмж, багшлах боловсон хүчнийг нэмэгдүүлэн Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2013 оноос хичээл сургалтыг 8 мэргэжлээр явуулж эхэлсэн байна.

Энэхүү 8 мэргэжил нь Боловсрол, шинжлэх ухааны яамны 2012 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн №2012/009 тоо тусгай зөвшөөрлөөр батлагдан индексжсэн бөгөөд эдгээр нь барилгын цахилгаанчин /7411-12/, барилгын засал чимэглэл /7123-20/, барилгын сантехник /7126-36/, барилгын өрөг угсрагч /7112-19/, гагнуурчин /7112-14/, бетон арматурчин /7114-20/, барилгын мужаан /7112-22/, тогооч /5120-11/ болно.

Мэргэжлийн үнэмлэх зэрэг олгох сургалтыг 2 сарын онол, 3 сарын үйлдвэрлэлийн дадлага гэсэн хэлбэрээр явуулахаар төлөвлөж, эхний ээлжийн сургалтыг 2013 оны 03 дугаар сард Хорих 421, 441 дүгээр ангиудаас нийт 100 суралцагч-хоригдлыг, хоёрдугаар ээлжийн сургалтыг 2013 оны 05 дугаар сараас эхлэн Хорих 401, 403, 423, 461 дүгээр ангиас 100 суралцагчийг өөрийн төвийн байранд татан авч сургалтыг зохион байгуулсан байна. Мөн 2013 оны 09 дүгээр сард жирийн дэглэмтэй хорих ангиудаас 28 хоригдол, 2013 оны 10 дугаар сард чанга дэглэмтэй хорих ангиудаас 35 хоригдлыг татан авч “Тогооч”-ийн мэргэжлийн 3 дугаар зэргийн гэрчилгээ олгох сургалт зохион байгуулсан юм.

Түүнчлэн Хорих 401 дүгээр ангийн дэргэд уран дарханы сийлбэр, мужааны

³⁶ ШШГТХ-ийн 106.1.Хорих анги шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах, байршлыг өөрчлөх асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

сургалтын төв нийт 18 жил үйл ажиллагаа явуулж байна. Тус төв нь сургалт үйлдвэрлэл явуулсанаас хойш нийт 60 гаруй хоригдлыг дарханы мэргэжилд сургасан ба эдгээр хоригдлуудаас 20 гаруй нь суллагдан гараад уран дарханы мэргэжлээрээ хувийн жижиг үйлдвэрлэл эрхлэн үр бүтээлтэй ажиллаж байгаа гэсэн таатай тоо баримт байна³⁷. Мөн нарийн мэргэжил эзэмшсэн хоригдлууд дэглэм бууж, бусад хорих ангиудад шилжиж сурсан мэдсэнээ бусдад зааж сургах, хийсэн бүтээлүүдээрээ олон улсын болон дотоодын олон уралдаан тэмцээн, үзэсгэлэнд оролцон шагналт байр, өргөмжлөл зэргээр шагнагдаж байсан нь хорих байгууллагад явуулах сургалтын үйл ажиллагаа үр дүнд хүрч байсныг харуулж байна.

Хорих байгууллагын нөхцөлд ялтанд мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрийн дадлага олгох сургалтыг явуулахдаа нэгд, тэдэнд шинээр мэргэжил эзэмшүүлэх, хоёрт, хоригдлын урьд эзэмшсэн мэргэжил нь тухайн хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэлтэй тохирч байгаа тохиолдолд мэргэжлийг нь дээшлүүлэх, гуравт, хос мэргэжил эзэмшүүлэх чиглэлийг баримталдаг байна. Мөн хорих ял эдлэгсдэд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг тэднийг ажлаас хөндийрүүлэхгүйгээр зохион байгуулдаг, өөрөөр хэлбэл сургалт-дадлагыг хослон явуулдаг байна.

Монгол Улсын Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 11 дүгээр хурлаар “Цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм”, “Цагдан цээрлүүлсэнийг зөрчсөнийг яллах хууль”-ийг анх баталж байжээ. “Цагдан цээрлүүлсэнийг зөрчсөнийг яллах хууль”-д захиргааны журам зөрчсөн, тухайн үедээ эрүүгийн хэргийн шинжгүй зөрчилд арга хэмжээ авах анхны хууль бөгөөд захиргааны зөрчлийн хүнд, хөнгөнийг харгалзан 1-15 хоног хорих, 1-15 төгрөгөөр торгууль ногдуулахаар заасан хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн эрх зүйн акт байжээ.

Ийнхүү Цагдан сэргийлэх байгууллага анх захиргааны журмаар баривчлах, нийгмээс тодорхой хугацаагаар тусгаарлан шийтгэл оногдуулдаг үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль /1992.11.27/ батлагдан гарах хүртэл захиргааны хариуцлагыг янз бүрийн хууль тогтоомж, эрх зүйн актаар хариуцлага хүлээлгэж байсан иржээ.

Социалист нийгмийн үед дийлэнх үйлдэгдэж байсан захиргааны шинжтэй зөрчил нь архидан согтуурах явдал байсан ба тухайн зөрчилтэй тэмцэх чиглэлээр олон арга хэмжээ авч хэрэгжүүлж иржээ. Манай улс 1960-аад оны сүүлч үеэс архидан согтуурах явдалтай тэмцэхэд анхаарлаа хандуулж эрх зүйн төдийгүй үзэл суртал, эдийн засаг, зохион байгуулалтын арга хэрэгслийг өргөнөөр ашиглаж гэмт хэрэг, нийгмийн хэв журам зөрчих явдалтай хамтран тэмцэх ажлын үр нөлөөг сайжруулах, согтуурлаас урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хүчийг төвлөрүүлэх хандлагыг бий болгосон төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байжээ. Тухайлбал, нийгмийн хэв журам зөрчигчид, танхайрагчидтай явуулах тэмцлийг

³⁷ Хорих 401 дүгээр ангийн сургалтын төвийн 2013 оны үйл ажиллагааны тайлан

хүчтэй болгох тухай Монгол Ардын Намын Төв Хорооны 1967 оны 263 тоот тогтоол гарган, уг тогтоолд “ууж согтууран хэрэг өдүүлэх явдалтай тэмцэх явдал бол нам, улс олон нийтийн үйлдвэр, албан газар, соён гэгээрүүлэх байгууллага, хөдөлмөрийн хамт олон, иргэн нэг бүрийн чухал зорилт, нэр төрийн хэрэг” гэж үзжээ.

Согтууруулах ундааны зүйл уусан үедээ авто техник жолоодсон жолоочийг 50-300 хүртэл төгрөгөөр торгох, авто техник жолоодсон жолоочийг 50-300 хүртэл төгрөгөөр торгож, авто техник жолоодох эрхийг 6 сараас 2 жил хүртэл, урьд нь эрхээ хасуулсан жолооч уг хугацаа дууссанаас хойш 3 жилийн дотор согтууруулах ундаа уусан үедээ авто техник жолоодвол 200-500 төгрөгөөр торгож авто техник жолоодох эрхийг 2-3 жил хүртэл хугацаагаар хасах, авто техник жолоодох эрхгүй боловч согтууруулах ундааны зүйл уусан үедээ авто техник жолоодсон этгээдийг 200-500 хүртэл төгрөгөөр, авто техник жолоодож яваа хүнтэй хамтарч согтууруулах ундааны зүйл уусан этгээдийг 25-500 төгрөгөөр тус тус торгохоор зарлигийн 12–р зүйлд заасан байна.

Архидалттай тэмцэх ажлын хүрээнд олон нийтийн үүсгэл санаачлагын зарим байгууллагад хөдөлмөрийн хамт олноос нийгмийн хэв журам зөрчигчид эрх зүйн зөрчил гаргагчидтай эвлэршгүй тэмцэх нөхцлийг бүрдүүлэх олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх эрх зүйн үндэслэлийг улам боловсронгуй болгох зорилгоор Ардын Их Хурлын Тэргүүлэгчид 1981 онд нийгмийн хэв журам хамгаалах ардын нөхөрлөл, хэв журам хамгаалах олон нийтийн дүрэм, 1982 онд олон нийтийн шүүхийн дүрэм, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс 1981 онд эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн хамт олны зөвлөлийн дүрмийг тус тус батлан гаргасан нь архидалттай тэмцэх эрх зүйн баримт бичиг болсон байна.

Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 онд гаргасан согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай 120-р зарлигт 1986 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Зарлигт нэмэлт өөрчлөлт оруулсан чиглэл нь архи, дарс, пиво, худалдах журмыг зохицуулах талаар орон нутгийн АИХ, түүний гүйцэтгэх захиргааны эрхийг өргөтгөж өөрийн орон нутагт байгаа хүн амын тархалт байршилтад тохируулан тухайн цаг үеийн байдалтай холбоотойгоор түүнийг худалдах цэг, цагийг тогтоох боломж олгосон явдалд оршиж байв. Дээрх эрх зүйн зохицуулалтууд нь архидан согтуурах явдалтай гол эрх зүйн акт байсан бөгөөд орчин цагт архидан согтуурах явдалтай тэмцэх хууль тогтоомжийн үндсэн эх сурвалж юм.

Монгол Улсад 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнд улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаа бүхэлдээ өөрчлөгдөн шинэчлэгдэж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг өөр арга хэлбэрээр зохицуулах шаардлага бий болжээ.

Зөрчлийн тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч зэрэг үнэт зүйлс, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай оногдуулах, хууль зүйн хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор³⁸ баталжээ. Зөрчлийн тухай хууль нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй 230

³⁸“Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”, <http://forum.parliament.mn/projects/75>

гаруй хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэсэн³⁹ анхны хууль болсон.

Хоёр.Зан үйлд нөлөөлөх сургалтад оролцох төрийн болон төрийн бус байгууллагын оролцоонд хийсэн шинжилгээ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.13 дахь хэсэгт заасны дагуу зөвшөөрөл бүхий төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бол тухайн байгууллагатай шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга гэрээ байгуулж, хамтран ажиллана⁴⁰ гэж заажээ.

Аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 60 шийдвэр гүйцэтгэгчийг хамруулан доорх асуулгын хүрээнд санал, асуулга явууллаа.Үүнд:

1.Хамгийн их төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо шаарддаг албадлагын арга хэмжээний 3 төрлийг дараалуулан бичнэ үү гэсэн асуултад зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох хязгаарлалт тогтоосон албадлагын арга хэмжээг нэрлэсэн байна.

Хүснэгт 14. Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо шаарддаг албадлагын арга хэмжээ төрлүүд.


Зан үйлээ засах сургалтад хамрагдах	43
Хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах	39
Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох	26
Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох	20
Оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, орхин явах тохиолдолд хяналт тавьж буй эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх	11
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	11
Гэмт хэргийн улмаас учирсан гэм хоригийг арилгах	7
Тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хязгаарлах	6
Галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох	5
тэнсэх	4
Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоох	3
Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ	3
Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан	2

2.Албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шийдвэр гүйцэтгэгчээс гадна төрийн болон төрийн бус байгууллага хяналт тавих шаардлагатай юу? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 50 буюу 83.3 хувь шаардлагатай, 10 буюу 16.7 хувь шаардлагагүй гэж хариулсан байна.

³⁹ Мөн тэнд

⁴⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 103 дугаар тушаалаар батлагдсан Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам.

Зураг 19. Төрийн бус байгууллагын хэрэгцээний судалгаа



3. Шаардлагатай бол ямар төрлийн арга хэмжээн дээр хяналт тавих вэ? гэсэн асуултад:

-зан үйлээ засах албадлагын арга хэмжээ гэж 22.5 хувь

-хөдөлмөрлөх дадал олгох албадлагын арга хэмжээ гэж 18.3 хувь

-хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох хязгаарлалт тогтоосон этгээдүүдэд хяналт тавих гэж 12.7 хувь

-галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох хязгаарлалт тогтоогдсон этгээдүүдэд гэж 8.5 хувь


-хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ гэж 7 хувь

-оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, орхин явах тохиолдолд хяналт тавьж буй эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хязгаарлах, тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох гэж тус бүр 4.2 хувь

-хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ гэж тус бүр 2.8 хувь нь хариулжээ.

4. Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултад 6 буюу 10 хувь нь сайн, 10 буюу 16.7 хувь нь сул, 26 буюу 43.3 хувь нь сайжруулах шаардлагатай, 17 буюу 28.3 хувь нь тодорхойгүй, 1 буюу 1.7 хувь нь сайн боловч сайжруулах шаардлагатай гэж хариулсан байна.

Зураг 20. Төрийн бус байгууллагын оролцооны эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ



5. Сайжруулах шаардлагатай гэж үзэж байгаа бол таны бодлоор ямар зохицуулалтуудыг оруулбал зүйтэй вэ? гэсэн асуултад:

- төрийн бус байгууллагууд, ялангуяа сэтгэл зүйн болон сургалтын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг төрийн бус байгууллагуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлын хүрээнд шүүхээр шийтгүүлсэн этгээдэд ганцаарчилсан ярилцлага, ганцаарчилсан зөвлөгөө, бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр сургалт зохион байгуулдаг, зохион байгуулсан ажлын хүрээнд тодорхой урамшуулал зардлыг нь улсын төсвөөс олгодог, урамшуулал олгохдоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай гэрээ хийсэн эсэхийг харгалздаг байхаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах;

- гэрээний үндсэн дээр зарим төрлийн үйл ажиллагааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр өөрчлөлт оруулах;


- зарим байгууллагууд хэлбэрийн төдий сургалт явуулдаг тул сургалт явуулж буй байгууллагуудад прокурор хяналт тавьдаг байхаар хуульчилж өгөх;

- сургалтын бааз суурийг бэхжүүлэх, мэргэжлийн багш, мэргэжилтэн сургалтыг ордог байхаар зохицуулалт оруулах;

- албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн оршин суугаа хорооны нийгмийн ажилтан, зохион байгуулагч, хэсгийн цагдаа нартай хэрхэн хамтарч ажиллах талаар тодорхой зохицуулалтыг тусгах зэрэг саналуудыг гаргасан байна.

6.Таны бодлоор албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо хэр чухал вэ? гэсэн асуултад 30 буюу 50 хувь нь маш чухал, 27 буюу 45 хувь нь чухал, 3 буюу 5 хувь нь чухал биш гэж хариулсан байна.

Зураг 21.Төрийн бус оролцоонд өгсөн үнэлгээ



7.Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагаас ямар хэлбэрээр оролцвол зүйтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад 5 буюу 8.3 хувь нь хяналт тавьж, 13 буюу 21.7 хувь нь зохион байгуулж, 35 буюу 58.3 хувь нь туслах хэлбэрээр, 1 буюу 1.7 хувь нь бусад хэлбэрээр, 3 буюу 5 хувь нь хяналт болон зохион байгуулалтын хэлбэрээр, 1 буюу 1.7 хувь нь хяналт болон туслах хэлбэрээр, 2 буюу 3.3 хувь нь туслах болон бусад хэлбэрээр гэж хариулсан.

8.Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллахад ямар бэрхшээл тулгардаг вэ? гэсэн асуултад 14 буюу 23.3 хувь нь сургалтын зардал байхгүй, 11 буюу 18.3 хувь нь хүн хүч, 5 буюу 8.3 хувь нь хамтран ажиллах байгууллага байхгүй, 1 буюу 1.7 хувь нь бусад, 5 буюу 8.3 хувь нь сургалтын зардал, хүн хүч байхгүй, 9 буюу 15 хувь нь сургалтын зардал, хүн хүч, техник хэрэгсэл байхгүй, 6 буюу 10 хувь нь сургалтын зардал, техник хэрэгсэл байхгүй, 4 буюу 6.7 хувь нь сургалтын зардал, хүн хүч, техник хэрэгсэл, хамтран ажиллах байгууллага байхгүй, 1 буюу 1.7 хувь нь сургалтын зардал, хүн хүч, хамтран ажиллах

байгууллага байхгүй, 1 буюу 1.7 хувь нь сургалтын зардал, техник хэрэгсэл, хамтран ажиллах байгууллага байхгүй, 3 буюу 5 хувь нь сургалтын зардал, хамтран ажиллах байгууллага байхгүй гэж;

9.Таны бодлоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд ямар нэгэн эрсдэл үүсэх магадлалтай юу? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 19 буюу 31.7 хувь албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн мэдээлэл алдагдах эрсдэлтэй, 4 буюу 6.7 хувь нь албадлагын арга хэмжээг зохиомлоор эдлүүлсэнд тооцох эрсдэлтэй, 28 буюу 46.7 хувь нь эрсдэлгүй, 4 буюу 6.7 хувь нь бусад төрлийн эрсдэл үүсэх магадлалтай, 5 буюу 8.3 хувь нь албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн мэдээлэл алдагдах, зохиомлоор эдлүүлсэнд тооцох эрсдэлтэй гэж тус тус хариулсан байна.


Дээрхээс дүгнэж үзвэл албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд дан ганц шийдвэр гүйцэтгэгч бус мэргэжлийн байгууллага, албан хаагч /сэтгэл зүйч,нийгмийн ажилтан, багш, цагдаа/, иргэдийн оролцоо маш чухал байна. Мөн нөгөөтэйгүүр эрүүгийн ял, хариуцлага нь гэмт хэрэг үйлдэж албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг нийгэмшүүлж, засрал хүмүүжлийг олгож, өөрийн гэсэн мэргэжил мэдлэгтэй болоход нь туслах зорилгыг агуулж байгаа бол түүний эргэн тойронд байгаа хүмүүсийн харилцаа хандлага, олон нийтийн оролцоо, үлгэр дуулиалал маш чухал. Иймээс хамтран ажиллах төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог маш нарийн хууль журмаараа зохицуулж өгөх ёстой. Мөн энэ ажилд оролцож байгаа иргэд, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг хэрхэн урамшуулах, тэдэнд эрхэлж буй ажил, албанд ямар хөнгөлөлт эдлүүлэх зэргийг тодорхой тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Цаашид дээрх төрлийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо ямар байх нь зүйтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж, харилцан туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллах, хууль журмаар зохицуулан нэгдсэн нэг ойлголттой байх нь чухал гэсэн санаануудыг гаргасан байна.

Гурав. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүнд хийсэн шинжилгээ:


Судалгаанд хамрагдсан 452 этгээд Баривчлах байрнаас зохиож буй албадан сургалтын үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? асуултад 123 нь буюу 27,2% нь үр нөлөө сайтай, 202 нь буюу 44,6% нь хангалтгүй, 28% нь ямар ч үр нөлөөгүй гэж хариулжээ.

Зураг 22. Албадан сургалтын үр нөлөөний талаарх судалгаа



Түүнчлэн албадан сургалтыг хэрхэн явуулах нь зүйтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад мэргэжлийн багш нараар заалгах гэж 252 буюу 55,7%, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг өөрчлөх гэж 61 буюу 13,4%, одоо явуулж буй сургалтын чанарыг сайжруулах гэж 139 буюу 30,7% нь үзжээ.


Зураг 23. Албадан сургалтын үр дүнг дээшлүүлэх талаарх санал



Судалгааны дүнгээс харахад баривчлагдсан этгээдүүд зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг хангалтгүй гэж дүгнэсэн байна.


Түүнчлэн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж буй 61 алба хаагчаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг та хэрхэн үнэлэх вэ? гэх асуултад үр дүн сайтай-18, үр дүнгүй-12, үр дүнг нь тодорхойлох боломжгүй-25, мэдэхгүй-6 хариулсан байна.

Зураг 24. Алба хаагчдаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд өгсөн үнэлгээ



Мөн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүнг сайжруулах хүрээнд ямар ажил чухал вэ? гэх асуултад сургалтын хөтөлбөр, удирдамж-8, багшлах боловсон хүчин-28, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа-12, төсөв, санхүү, удирдлагын дэмжлэг-13 хүн хариулсан байна.


Зураг 25. Зан үйлд нөлөөлөх сургалтын үр дүнг сайжруулах чиглэлээр гаргасан санал



Дөрөв.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулах хүний нөөц, сургалтын орчинд хийсэн шинжилгээ

Хорих байгууллагын “сэтгэл зүйч” гэж хоригдогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлсны үндсэн дээр сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх алба хаагчийг хэлдэг бол “нийгмийн ажилтан” гэж хорих байгууллагын нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй төрийн тусгай албан хаагчийг тус тус ойлгодог.

Зураг 26.2015-2020 оны хооронд хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ажиллаж байсан нийгмийн ажилтны судалгаа



Зураг 27 .Мэргэжлийн нийгмийн ажилтны судалгаа



Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулахад мэргэшсэн хүний нөөцөөс гадна сургалт явуулах орчин зайлшгүй чухал юм. Судалгааны явцад хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дахь сургалтын орчныг судлан үзэхэд хангалтгүй байгаа нь харагдаж байлаа.

Хүснэгт 15.Хорих ангиуд дахь сургалтын орчны судалгаа

Хорих анги	Жилд дунджаар ял эдэлдэг хоригдлын тоо	Сургалтын танхимтай эсэх	Танхимын багтаамж
401-р хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлэг	50-100	Танхимгүй	Номын санд 8-10 хүн багтах боломжтой.
405-р хаалттай хорих анги	70-100	Танхимгүй	Бясалгалын өрөөнд 4 хүн багтах боломжтой.
407-р нээлттэй, хаалттай хорих анги	250-300	Танхимтай	Зөвхөн нээлттэй хорих ангийн 2 дугаар танхимд 20-25 хүний багтаамжтай.
409-р хаалттай хорих анги	800-900	Танхимтай	Төв байранд сургалтын 90 хүний багтаамжтай нэгдсэн танхимтай.
СХТБ	40-80	Танхимтай	Сургалтын танхим-50 Шашны өрөөн-20 Зурагтын өрөөн-20 хүний багтаамжтай.
413-р нээлттэй, хаалттай хорих анги	350-400	Танхимтай	2 тасалгаа бүхий 60 хүний багтаамжтай 1 танхимтай.
415-р нээлттэй, хаалттай хорих анги	250-300	Танхимтай	Хаалттай-25, нээлттэй-25 хүний багтаамжтай 2 танхимтай.
417-р нээлттэй хорих анги	150-200	Танхимтай	1.Нийтийн байрны 100 хүний багтаамжтай 1 заал 2.Сургалтын байранд тус бүр 10 хүний багтаамжтай 9 танхимтай.
419-р нээлттэй хорих анги	200-300	Танхимтай	1.Тусгай зэрэглэлийн байрны 2 давхарт 90 хүний багтаамжтай 1 танхим 2. Тусгай зэрэглэлийн байрны 2 давхарт 20 хүний багтаамжтай номын сан
421-р нээлттэй хорих анги	250-350	Танхимгүй	Хоригдлын байрны 2-р давхарт 32 хүний багтаамжтай номын сантай.
423-р нээлттэй, хаалттай хорих анги	300-400	Танхимтай	1.20 хүний багтаамжтай видео сургалтын өрөө-1 2. 20 хүний багтаамжтай бясалгалын өрөө-1 3. 60 хүний багтаамжтай сургалтын танхим-1 4. 150 хүний багтаамжтай Соёлын төв-1 5. 20 хүний багтаамжтай номын сан-1
425-р нээлттэй хорих анги	200-250	Танхимтай	30 хүний багтаамжтай 1 танхимтай.
427-р нээлттэй, хаалттай хорих анги	300-400	Танхимтай	1.Хаалттай дэглэмд-50 хүний багтаамжтай 1 танхим 2.Нээлттэй дэглэмд-50 хүний багтаамжтай 1 танхим 3.Аж ахуйн үйлчилгээний хоригдлын байранд-16 хүний багтаамжтай-1 танхим

			4.200 хүний багтаамжтай-Соёлын төв
429-р хаалттай хорих анги	100-200	Танхимтай	80 хүний багтаамжтай-1 танхим
433-р хаалттай хорих анги	100-200	Танхимтай	“Б” хэсэгт 50 хүний багтаамжтай-1 танхим
435-р хаалттай хорих анги	100-200	Танхимтай	1.30 хүний багтаамжтай сургалтын танхим 2.Номын сан-25 хүний багтаамжтай
437-р нээлттэй хорих анги	100-200	Танхимтай	1.Номын сан-16 хүний багтаамжтай 2.Бясалгалын өрөө-40 хүний багтаамжтай 3.Видео дэлгэцийн өрөө-20 хүний багтаамжтай.
439-р хаалттай хорих анги	100-200	Танхимгүй	1.Хоригдлын 2 дугаар байранд-50 хүний багтаамжтай хоолны заал, 10 хүний багтаамжтай номын сан-1 2.Хоригдлын 3 дугаар байранд 50 хүний багтаамжтай хоолны заал, суллагдах хоригдолд зориулсан 10 хүний багтаамжтай өрөө-1, 40 хүний багтаамжтай номын сан-1 3. Хоригдлын 4 дүгээр байранд-50 хүний багтаамжтай хоолны заал, 10 хүний багтаамжтай номын сан-1
441-р нээлттэй хорих анги	100-200	Танхимгүй	Алба хаагчдын хурлын зааланд сургалт явуулдаг.
445-р нээлттэй хорих анги	100-200	Танхимтай	30 хүний багтаамжтай 1 танхимтай.
457-р нээлттэй хорих анги	100-200	Танхимгүй	25 хүний багтаамжтай 1 номын сантай.

Зан үйлд нөлөөлөх сургалтын чанар, үр дүнг сайжруулах чиглэлээр судалгаанд оролцогчдоос гаргасан санал:

- Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;
- Багшлах боловсон хүчнээр хангах;
- Сургалт зохион байгуулах зардал, мэргэшсэн боловсон хүчинтэй болох;
- Төсөв санхүү болон бусад байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;
- Сургалтын ажилтны орон тоог бий болгох шаардлагатай;
- Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг зан үйлд нөлөөлөх талаар тодорхой сургалт, дамжаанд суралцуулах;
- Хичээл явуулахад шаардагдах гарын авлага, видео хичээлүүд шаардлагатай;
- Тодорхой чиглэлээр гаргасан удирдамж, хөтөлбөр, тусгайлсан төсөв, материаллаг хангамж;
- Сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгож төсөв, санхүү, удирдлагын дэмжлэгийг нарийвчлан тусгах;
- Сургалт явуулж буй багшийг тусгай хөтөлбөр сургалтад хамруулах;
- Ажлын ачаалал ихтэй, мэргэжлийн боловсон хүчин байхгүй, сургалт зохион байгуулах орчин, нөхцөл дутмаг;
- Сургалтад хамрагдаж буй этгээд нь сургалтын талаар ойлгох, хүлээж авах чадвар султуул үр дүн муутай байдаг;
- Боловсон хүчний мэдлэг ур чадвар, ажилдаа хандах хандлага;
- Тусгай бэлтгэсэн өрөө тасалгааг сайжруулах;

- Сургалт явуулах тоног төхөөрөмж, ур чадвар сайтай багш;
- Мэргэжлийн багш, сэтгэл зүйчийн орон тоо байхгүй;
- Сургалтын танхим бий болгох;
- Сургалтын хөтөлбөрийг ЭХТА-д заасан зүйл анги тус бүрээр нарийвчлан гаргах шаардлагатай;
- Сургалтад хамрагдаж буй этгээд нь сургалт таслах тохиолдол цөөнгүй гарч байгаа тул сургалт тасалсан этгээдэд авах сахилгын шийтгэлийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Тухайн баривчлагдсан этгээдэд нөлөөлөхүйц, үр дүнтэй сургалт явуулахын тулд баривчлагдсан этгээдтэй биечлэн уулзаж боловсрол, ахуй орчин, үйлдсэн гэмт хэргийн талаар тодорхой мэдээлэл авсны үндсэн дээр сургалтаа тодорхойлж явуулах;
- Тухайн албадан сургалтын сорилууд, тэдгээрийн үр дүн тайлбар нь дэлгэрэнгүй бус хэт ерөнхий;
- Сургалтын үр дүнг тооцох аргачлал, сорил нь олон талыг харуулсан байвал дүгнэлт оновчтой болоход дөхөм;
- Албадан сургалтыг дан хичээл танхимын хэлбэрээр бус мэдрэмж, чадвар хөгжүүлэх урлагийн төрлийн сэтгэц заслын аргуудтай хавсарсан байдлаар боловсруулах зэрэг болно.

ГУРАВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ

3.1.Дүгнэлт

“Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” сэдэвт судалгааны ажилд цугларсан материал, санал асуулга болон холбогдох материалд үндэслэн дараах дүгнэлтэд хүрлээ.

Нэг.Судалгааны арга зүйн хүрээнд:

1.1.Судалгааны ажилдаа Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн Ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон түүний харьяа Баривчлах төвийн албан ёсны тайлан мэдээ, холбогдох хууль, журам, заавар, холбогдох материалыг уншиж танилцан ашигласан нь судалгааны үнэн бодит байдлыг илтгэн харуулж байна.

1.2. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөө, хэрэгжилтийн талаарх санал асуулгыг ШШГЕГ-ын харьяаны төв, орон нутгийн хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн 62 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, албадлагын арга хэмжээний нэг төрөл болох зан үйлд нөлөөлөх албадан сургалтын чанар, үр дүн, тухайн ажиллагаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны талаарх асуулгыг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 60 шийдвэр гүйцэтгэгч нийт 122 алба хаагч буюу зан үйлд нөлөөлөх сургалтыг гардан хэрэгжүүлэгч албан тушаалтны 90%, баривчлагдсан 452 этгээд буюу тухайн үед баривчлах шийтгэл эдэлж байсан нийт хүмүүсийн 80%-иас анкетын аргаар судалгаа хийн энэхүү судалгааг гүйцэтгэсэн болно.

Хоёр. Баривчлах шийтгэл ногдуулалтын хүрээнд:

2.1.Улсын хэмжээнд 2015-2020 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар 2015 онд-13174, 2016 онд-5380, 2017 онд-11345, 2018 онд-10981, 2019 онд-15296, 2020 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар 15620 хүн баривчлагдсан нь шүүхээс баривчлах шийтгэл ногдуулах байдал жил ирэх тусам өсч байгааг харуулж байна.

2.2. Монгол Улсад үйлдэгдэж буй зөрчлийн дийлэнхи хэсгийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил эзэлдэг ба Цагдаагийн байгууллагад 2020 оны эхний хагас жилийн байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 1,972,075 бүртгэгдэн 600 хүн баривчлах шийтгэл эдэлсэн байна.

Улсын хэмжээнд зөвхөн 2020 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих-1,972,075, олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах-87,440, хүний биед халдах-14,653, иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих-13,525, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих-8,838, хүүхдийн эрхийг зөрчих-2,743, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих-2,571, танхайрах-3,150, гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих-903 нийт-2,105,898 зөрчил үйлдэгдсэн байна.

2.3. ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд 2015-2020 оны хооронд шүүхээс оногдуулсан баривчлах шийтгэл эдлүүлсэн хүний тоог авч үзвэл, 2015 онд-6278, 2016 онд-3031, 2017 онд-5159,2018 онд-4356, 2019 онд 7815, 2020 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар-5584 хүн шийтгэл эдэлсэн байна.

2.4. ШШГЕГ-ын харьяа Баривчлах төв нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудад заасан зөрчил гарган шүүхээс баривчлах шийтгэл оногдуулсан 32223 этгээдэд 7-30 хоногийн баривчлах шийтгэлийг эдлүүлсэн байна.

2.5.2020 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар баривчлагдсан этгээдүүдийн 72.3% нь буюу 4029 хүн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлөөр баривчлагдсан байна.

2.6.Баривчлах төвд ажиллаж буй 41 алба хаагчаас баривчлах шийтгэлийн үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад 31 алба хаагч буюу 75,6% баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай, 9 алба хаагч буюу 21,9% нь ямар ч үр нөлөө алга, сайн үр нөлөөтэй гэж үзсэн алба хаагч байхгүй ба судалгаанд хамрагдсан 452 этгээдийн баривчлах шийтгэлийн үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад 247 хүн буюу 54,6 ямар ч үр нөлөөгүй, 144 хүн буюу 31,8% нь дунд зэрэг, 61 хүн буюу 13,4% нь сайн үр нөлөөтэй байна гэж хариулсан нь баривчлах шийтгэлийн үр нөлөө хангалтгүй байгааг харуулж байна.

2.7. ШШГЕГ-ын харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн 61 алба хаагчаас ШШГБ-аас аймаг, орон нутагт баривчлагдсан этгээдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулах боломж өнөөгийн нөхцөлд бий юу? гэсэн асуулгад бүрэн боломжтой-9, хугацаа болоогүй-0, бэлтгэл ажлыг сайтар хангах хэрэгтэй-41, мэдэхгүй-11 хариулсан байна.

Гурав. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хүрээнд:

3.1. Шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5-т Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна гэжээ. Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь сэтгэл зүйн ба эрх зүйн сургалт гэсэн төрөлтэй байна.

3.2.Сэтгэл зүйн сургалт нь архины шалтгаант зан үйлийг өөрчлөх, харилцааны чадвар сайжруулах, хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх, уур бухимдлаа зохицуулах, өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх гэсэн хэлбэртэй байна.

3.3. Зан үйлд нөлөөлөх эрх зүйн сургалтын үндсэн мөн чанар нь гэмт хэрэг, зөрчил үйлдэгчидэд:

1.Гэр бүлийн тухай болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгаалалын тухай хууль;

2.Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль;

3. Шаардагдах бусад хуулиудаар сургалт ордог.

Эрх зүйн сургалтын агуулга нь зөвхөн хуулийг зааж, мэдүүлэх гэхээсээ илүү, тухайн хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, учирж болох сөрөг үр дагаварыг ухамсарлуулан ойлгуулахад оршдог. Сэтгэл зүйн болон эрх зүйн сургалтыг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүний хувийн онцлог, зөрчлийн шинж болон бусад нөхцөл байдлыг харгалзан ялгамжтай байдлаар явуулбал зохистой юм.

3.4. Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь Зөрчлийн тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад журам, зааврын хүрээнд зохицуулагдаж байна.

3.5. Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн зан үйлд нөлөөлөх сургалтыг хэрэгжүүлж буй 61 алба хаагчаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад өгөх таны үнэлгээ гэх асуулгад хангалттай сайн зохицуулсан-14, хангалгүй-5, сайжруулах шаардлагатай-34, мэдэхгүй-8 хариулсан байна.

3.6. Шүүхээс оноож буй зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлдэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 12 буюу 20 хувь нь бүрэн хэрэгжиж байгаа, 48 буюу 80 хувь нь учир дутагдалтай хэрэгждэг гэж гэж хариулжээ.

3.7. Монгол Улс түүхэн хөгжлийнхөө явцад гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг шийтгэж “цээрлүүлэх” гэхээс илүү “нийгэмшүүлэх” бодлогыг хэрэгжүүлж ирсэн гэж хэлж болох бөгөөд хорих байгууллагын түүхэн хөгжлийн явцад хоригдлыг нийгэмшүүлэх ажил хорих ял эдлүүлэх ажиллагааны нэг бүхэл хэсэг нь байсаар ирсэн.

3.8. Аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 60 шийдвэр гүйцэтгэгчээс хамгийн их төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо шаарддаг албадлагын арга хэмжээний 3 төрлийг дараалуулан бичнэ үү гэсэн асуултад зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох хязгаарлалт тогтоосон албадлагын арга хэмжээг нэрлэсэн байна.

3.9. Судалгаанд хамрагдсан баривчлагдсан 452 этгээд баривчлах байрнаас зохиож буй албадан сургалтын үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? асуултад 123 нь буюу 27,2% нь үр нөлөө сайтай, 202 нь буюу 44,6% нь хангалтгүй, 28% нь ямар ч үр нөлөөгүй гэж хариулжээ. Түүнчлэн албадан сургалтыг хэрхэн явуулах нь зүйтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад мэргэжлийн багш нараар заалгах гэж 252 буюу 55,7%, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг өөрчлөх гэж 61 буюу 13,4%, одоо явуулж буй сургалтын чанарыг сайжруулах гэж 139 буюу 30,7% нь үзжээ.

3.10. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж буй 61 алба хаагчаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг та хэрхэн үнэлэх вэ? гэх асуулгад үр дүн сайтай-18, үр дүнгүй-12, үр дүнг нь тодорхойлох боломжгүй-25, мэдэхгүй-6 хариулсан байна.

3.11. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүнг сайжруулах хүрээнд ямар ажил чухал вэ? гэх асуулгад сургалтын хөтөлбөр, удирдамж-8, багшлах боловсон хүчин-28, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа-12, төсөв, санхүү, удирдлагын дэмжлэг-13 хүн хариулсан байна.

3.12. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулахад мэргэшсэн хүний нөөцөөс гадна сургалт явуулах орчин зайлшгүй чухал юм. Судалгааны явцад хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дахь сургалтын орчныг судлан үзэхэд хангалтгүй байгаа нь судалгаанаас харагдаж байлаа.

3.13. Цагдаагийн байгууллагаас орон нутагт гүйцэтгэж буй баривчлах шийтгэл эдлүүлж буй байдал нь хангалтгүй, тухайлбал, эрүүлжүүлэхийн нэг өрөөнд хоридог, зан үйлд нөлөөлөх сургалтыг хангалттай явуулдаггүй, орчин нөхцөл муутай байна.

3.2.Зөвлөмж

Судалгааны үр дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргалаа.

Нэг.Баривчлах шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан баривчлах шийдвэр биелүүлэхтэй холбоотой зүйл, заалтыг бүлэг болгон өөрчилж, эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас баривчлах шийтгэлийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх хүрээнд аймаг, орон нутагт баривчлах шийтгэл гүйцэтгэх чиглэлээр бэлтгэл ажлыг /баривчлах байр, өрөө, алба хаагч, зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах материаллаг бааз, хамтын ажиллагаа/ хангах;

3.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг удирдан явуулах мэргэшсэн багш, сэтгэл зүйчдийг 50 хүнд-1 гэсэн орон тоотой байхаар зохион байгуулах.

Хоёр.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хүрээнд:

1. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг эрх зүйн болон сэтгэл зүйн гэсэн жишиг хөтөлбөр болгон боловсруулж, сургалтанд ашиглах;

2. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр мэргэшсэн сургалтын байгууллага, багш нараар түлхүү заалгах, сургалтын орчин үеийн арга хэлбэрийг ашиглан сургалтын чанарыг сайжруулах зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, тогтоомж:

1. Үндсэн хууль.1992-01-13
2. Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/.2017-05-11
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/.2017-06-09
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/.2016-12-22
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай.2017-5-18
6. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай1999-01-07
7. Баривчлах байрны дотоод журам.2017-09-29
8. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам.2017-04-04
9. Сэтгэл зүйн ажлын заавар.2019-6-07

Ном, сурах бичиг:

1. Ч.Нямсүрэн, “Эрх зүйн онол” ерөнхий анги, УБ., 2016
2. Ж.Сүхбаатар, “Захиргааны эрх зүй”, УБ., 2005
3. С.Долгорсүрэн, “Захиргааны хариуцлага”, УБ., 2005
4. А.Лхагва. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй.УБ.2014
5. Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа:харьцуулсан судлал.УБ.2018 он

Судалгааны тайлан:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа: /харьцуулсан лавлагаа/.2017
2. Хууль зүйн үндэсний хүрээлэн.Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ.2018

Цахим хаяг:

1. www.mojha.gov.mn
2. www.cd.gov.mn
3. www.police.gov.mn

ХАВСРАЛТ

Баривчлах байрны сургалтын танхим засварлан тохижуулахад шаардлагатай материал, тавилга хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн тооцоо						
№	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тайлбар
Нэг. Сэтгэл зүйчийн өрөөнд:						
1	Сандал	ш	2	150,000	300,000	
2	Дугуй ширээ	ш	1	150,000	150,000	
3	Шүүгээ	ш	1	200,000	200,000	
4	Хөшиг	м	4	135,000	540,000	
ДҮН					1,190,000	
Хоёр. Сургалтын танхим:						
1	Өсгөгч	ш	1	500,000	500,000	
2	Проектор	ш	1	5,000,000	5,000,000	
3	Проекторын дэлгэц	ш	1	2,500,000	2,500,000	
4	Самбар 1 тал	ш	2	418,000	836,000	
5	Ухаалаг индэр	ш	1	6,500,000	6,500,000	
6	Стикер /зурагт самбар/	ш	10	25,000	250,000	
7	Стэйн	ш	10	35,000	350,000	
8	Агаар цэвэршүүлэгч	ш	2	1,879,900	3,759,800	91м ² Haier
9	Албадан сургалтад ашиглах эвхэгддэг ширээ сандал	ш	80	150,000	12,000,000	
10	Эд зүйл хадгалах шүүгээ / 9 хаалгатай/	ш	4	380,000	1,520,000	
11	Хөшиг	м	4	135,000	540,000	
12	Багш нарын сандал	ш	5	150,000	750,000	
13	Багшийн ширээ /урт/	ш	1	700,000	700,000	
14	Индэр	ш	1	350,000	350,000	
15	Өлгүүр /20 өлгүүртэй/	ш	1	300,000	300,000	
16	Дрож	м	51	80,000	4,080,000	
17	Телевизор /55 инч/	ш	1	2,500,000	2,500,000	
18	Ус шүүгч	ш	3	229,900	689,700	
19	Чанга яригч /зөөврийн/	ш	2	200,000	400,000	
20	Агаар чийгшүүлэгч	ш	2	989,900	1,979,800	45м ²
ДҮН					45,005,300	
Гурав. Бүлгийн сургалтын өрөөнд:						
1	Компьютер	ком	11	1,100,000	12,100,000	
2	Багшийн ширээ, сандал	ш	1	350,000	350,000	
3	Компьютерийн ширээ, сандал	ком	10	300,000	3,000,000	
4	Зөөврийн компьютер	ш	1	2,090,000	2,090,000	
5	Дугуй ширээ /урт/ бүлгийн ярилцлага	ш	1	2,000,000	2,000,000	
6	Сандал	ш	7	150,000	1,050,000	
7	Хөшиг	м	2	135,000	270,000	
8	Интернэт төхөөрөмж	ш	1	360,000	360,000	

9	Видео хурлын төхөөрөмж	ком	1	15,000,000	15,000,000	
10	Проекторын дэлгэц	ш	1	2,500,000	2,500,000	
10	Проектор	ш	1	1,500,000	1,500,000	
11	Зөөврийн компьютер	ш	1	2,090,000	2,090,000	
ДҮН					42,310,000	
Дөрөв. Номын сангийн өрөөнд						
1	Номын сангийн тавиур	ш	4	200,000	800,000	
2	Ширээ	ш	1	150,000	150,000	
3	Сандал	ш	2	80,000	160,000	
4	Хөшиг	м	2	135,000	270,000	
5	Номын сангийн баяжилт	ш	500	20,000	10,000,000	
ДҮН					11,380,000	
Тав. Телекамерын хэрэгсэл						
1	IP камер 2mp 2.8mm Full HD 1080p	ш	3	100,000	300,000	
2	Хяналтын дэлгэц	ш	1	185,000	185,000	
3	Хард диск /500GB/	ш	1	90,000	90,000	
4	12v 2g adapter	ш	3	8,000	24,000	
5	Кабел	м	160	1,200	192,000	
6	Толгой /lan port/	ш	6	1,000	6,000	
7	Бичлэгийн төхөөрөмж	ш	1	90,000	90,000	
ДҮН					887,000	
Зургаа. Бичгийн хэрэгсэл						
1	Зургийн аппарат NIKON D53000	ш	1	1,256,130	1,256,130	
2	Үдээсний машин	ком	1	6,500	6,500	
3	Ламинатор	ш	1	88,000	88,000	
4	Нуруулдагч машин	ш	1	104,500	104,500	
5	Цаас устгагч	ш	1	249,990	249,990	
6	Принтер 4 үйлдэлтэй	ш	1	1,800,000	1,800,000	
ДҮН					3,505,120	
НИЙТ ДҮН						104,277,420